



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолын дагуу "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Бундхорол), Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд Аудитын гуравдугаар газар (Д.Энхболд) хариуцаж хүргүүлэхийг үүрэг болгосугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Сангийн сайд (Б.Жавхлан), холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын гуравдугаар газар (Д.Энхболд)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Аудитын гуравдугаар газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2022\EA-Ын А Тушаал\0610 Auditin 3 Gazar - 1.Docx

0001010530

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал	5
Хүснэгтийн жагсаалт	6
Графикийн жагсаалт	6
Дүрслэлийн жагсаалт	6
Зургийн жагсаалт	6
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	9
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЭГДСЭН БОДЛОГООР ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН Ч БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	15
Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг хоорондын уялдааг бүрэн хангаагүй нь Хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна	15
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийг Сангийн яам 2019 оноос эхлэн нэвтрүүлсэн ч ТЕЗ нар бүрэн ашиглахгүй байна	16
Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй 110 төсөл, арга хэмжээг УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмсэн байна	18
Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй 128 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ	19
Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулж санхүүжилтийг төлөвлөөгүй, мөн төрийн өмчид бүртгэгдэхгүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг зөрчил хэвээр байна	20
Зарим барилга, байгууламжийг олон жилээр үргэлжлүүлэн төлөвлөж байгаа нь хэрэгцээ шаардлага хангахгүй болох, өртөг нэмэгдэх шалтгаан болж байна	22
Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж эхлээд дуусаагүй орхигдсон 184.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 59 барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна	23
Зах зээлийн чадамжид нийцсэн цөөн тооны арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөх нь эдийн засгийн хувьд өгөөжтэй байна	24
Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч иргэн, байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлж, мөрдөж буй хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна	25
БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАНАР БАЙДЛЫГ ДОРОЙТУУЛЖ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ, ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА	29
Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зөрчигдсөөр байна	30
Магадлалаар баталгаажаагүй төсөвт өртгөөр зарим худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна	31
Урсгал зардлаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байна	34
Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 65.8 хувийг бодит гүйцэтгэлд олгосон байна	34
Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар 397.2 тэрбум төгрөгийн 399 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна	34
Барилга угсралтын ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс барилгын материал сольж, барилгын чанар байдлыг доройтуулж байна	36
Магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан байна	38
Төрийн өмчит компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлын ашиглалт хангалтгүй байна	41
Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна	42
Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг сайжруулах, хариуцлагажуулах шаардлагатай байна	43

Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилгын ашиглалт хангалтгүй байна.....	45
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, худалдан авсан техник хэрэгслийн ашиглалт, үр дүнд ашиглалтын хугацааны турш хяналт хэрэгжүүлэхгүй, хариуцлага тооцохгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.....	46
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтээр хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн эрх зүйн орчин сайжирсан байна.....	50
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....	52
Төсөвлөлтийн шаардлага хангаагүй болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.....	52
Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулаагүй, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулаагүй байна.....	54
Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул байгаа нь улсын хэмжээнд удирдлагын нэгдсэн систем, цахим бүртгэл байхгүйтэй холбоотой байна.....	55
ДҮГНЭЛТ	59
ЗӨВЛӨМЖ	61
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	63
ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	65
ХАВСРАЛТУУД	66

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АТГД	Авлигатай тэмцэх газрын дарга
АУЗН	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэг
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баяндүрх дүүрэг
БНБД	Барилгын норм ба дүрэм
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БУА	Барилга угсралтын ажил
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУЕТГД	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
МУИХД	Монгол Улсын Их Хурлын дарга
МУШС	Монгол Улсын Шадар сайд
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СаС	Сангийн сайд
СЗХД	Санхүүгийн зохицуулах хорооны дарга
СоС	Соёлын сайд
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨӨЗ	Тендерт оролцогчдын өгөгдлийн заавар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТХХТ	
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШТА	Шууд тайлагнах аудит

ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр (тэрбум төгрөг)	9
Хүснэгт 2	Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл (тэрбум төгрөг, хувь)	10
Хүснэгт 3	Улсын төсвийн 2020, 2021 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)	11
Хүснэгт 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар (тэрбум төгрөг)	11
Хүснэгт 5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)	12
Хүснэгт 6	Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл (тэрбум төгрөг)	13
Хүснэгт 7	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтээр ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа (хүчин чадлаар)	14
Хүснэгт 8	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан 2021 онд үргэлжлэн болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт (тэрбум төгрөг)	15
Хүснэгт 9	Улсын төсвийн 2020, 2021 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)	17
Хүснэгт 10	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулаагүй баталсан, санхүүжих дүн нь 1.0 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр дутуу төсөвлөгдсөн зарим төсөл, арга хэмжээний жишээ (сая төгрөг)	20
Хүснэгт 11	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинж агуулаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас шийдвэрлэх боломжтой зарим төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)	22
Хүснэгт 12	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй 4-ээс дээш жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)	22
Хүснэгт 13	Улсын хэмжээнд ашиглалтад оруулсан үндсэн фонд (тэрбум төгрөг, хувь)	24
Хүснэгт 14	Зураг төслийг хугацаа алдалгүй боловсруулах шаардлагатай төслүүд (нэр, тэрбум төгрөг)	28
Хүснэгт 15	Тендерийн гомдлын судалгаа (тоо, хувь)	30
Хүснэгт 16	Түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулж, өртөг нэмэгдсэн төслүүд (сая төгрөг)	31
Хүснэгт 17	Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр авсан арга хэмжээ (сая төгрөг)	35
Хүснэгт 18	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд илэрсэн зөрчил (сая төгрөг)	35
Хүснэгт 19	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн дүн (сая төгрөг)	42
Хүснэгт 20	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны төрөл арга, зарцуулсан хугацаа, ил тод байдал (тоо)	54
Хүснэгт 21	Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт (сая төгрөг)	55

Графикийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
График 1	Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд хөрөнгийн зарлагын эзлэх хэмжээ (тэрбум төгрөг, хувь)	10
График 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа (тэрбум төгрөг)	11
График 3	ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа (хувь, сараар)	29

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дуусаагүй орхигдсон барилгуудын ангилал	23
Дүрслэл 2	Улсын хэмжээнд 2021 онд нийт ашиглалтад орсон барилга, байгууламжид улсын төсвийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон барилга, байгууламжийн эзлэх хэмжээ	24

Зургийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Зураг 1	Богд Зонхова төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж буй байдал	19
Зураг 2	Өвөрхангай аймгийн Тарагт сумын ЗДТГ-ын барилгын зураг, 2022 оны 5 дугаар сар	44
Зураг 3, 4	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын 320 суудалтай сургуулийн барилгын зураг, 2022 оны 6 дугаар сар	44
Зураг 5, 6, 7	Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын 320 суудалтай сургуулийн барилгын зураг, 2022 оны 6 дугаар сар	44
Зураг 8	Зураг 8. Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Соёл спортын цогцолборын барилгын зураг, 2022 оны 5 дугаар сар	44

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын зорилго, хамарсан хүрээ

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитад Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн 24 Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, Барилгын хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооны АДБОУС-100, 300, 3000-д стандартад нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын холбогдох стандарт заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаалаар оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитын асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”,

- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батдэлгэр, аудитор С.Одонцэцэг, Ж.Оюунтуяа, Ш.Наранбаатар, Г.Оргилмаа, гэрээт ажилтан И.Дөлгөөнтуул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын хамрах хүрээнд зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчээр дүгнэлт гаргуулан, үр дүнг аудитын дүгнэлтэд ашиглалаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлаас 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэн, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгосон байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн:

- 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг;
- 4 дүгээр зүйлийн 4.1.12-т “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичиг;
- 5 дугаар зүйлийн 5.2.12-т “төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөх;
- 6 дугаар зүйлийн 6.7.1.в-д “тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргасан байхаар тус тус заажээ.

Дээрх хуульд зааснаар нэгдмэл нэг зорилго, зорилтын хүрээнд салбар хоорондын уялдааг хангасан, урт, дунд, богино хугацааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжлийн бодлогын зорилтыг хангахаар байна.

Улсын төсвийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг эх үүсвэр байхаар хуульчилсан бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл “Өр үүсгэх зориулалт”-ын 12.1.5-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх” гэж заасныг үндэслэн Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, хөтөлбөрийн 35.5 хувийг гадаад, зээл тусламжаар, 31.1 хувийг шууд хөрөнгө оруулалтаар, 15.8 хувийг концесс, төр хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр, 9.3 хувийг улсын төсвөөр тус тус санхүүжүүлэхээр баталж, 7.5 хувийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна.

Хүснэгт 1. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр (тэрбум төгрөг)

Зорилтын нэр	ТАХ-ний тоо	Санхүүжилт, оноор					Нийт санхүүжилт
		2021	2022	2023	2024	2025	
Үндэсний нэгдмэл үнэт зүйл	6	190.6	135.9	50.8			377.3
Хүний хөгжил	19	620.0	589.5	468.6	424.4	21.0	2,123.5
Амьдралын чанар ба дундаж давхарга	14	488.9	339.6	1,216.4	169.2	94.7	2,308.8
Эдийн засаг	56	7,510.9	11,363.6	8,056.0	2,755.4	712.9	30,398.8
Засаглал	9	127.5	98.3	73.5	11.3	10.7	321.3
Ногоон хөгжил	6	134.6	129.9	212.0	179.1	53.2	708.8
Амар тайван, аюулгүй нийгэм	11	203.9	194.3	165.7	111.3	20.7	695.9
Бүс, орон нутгийн хөгжил	18	474.2	450.0	252.0	157.0	157.7	1,490.9
Улаанбаатар ба дагуул хот	11	374.7	412.2	264.6	95.7	40.1	1,187.3
НИЙТ	150	10,125.3	13,713.3	10,759.6	3,903.4	1,111.0	39,612.6
Үүнээс, санхүүжилтийн эх үүсвэрээр							
Гадаад зээл, тусламж		3,725.6	3,653.4	4,474.3	1,634.1	594.6	14,082.1
Шууд хөрөнгө оруулалт		2,888.5	5,656.7	2,979.7	624.9	164.0	12,313.8
Хөгжлийн банкны санхүүжилт		145.5	134.4	19.1			299.0
Концесс, төр хувийн хэвшлийн түншлэл		1,437.7	1,696.9	1,825.6	1,119.0	191.2	6,270.4
Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй		772.5	1,363.5	706.0	93.0	39.8	2,974.8
Нийслэлийн төсөв		1.6		0.3	0.3	0.3	2.5
Улсын төсөв		1,153.9	1,208.3	754.4	432.2	121.1	3,669.9
Нийт санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь		11.4	8.8	7.0	11.1	10.9	9.3

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрт санхүүжүүлэх эх үүсвэрийг нь шийдвэрлээгүй дараах төсөл, хөтөлбөрийг баталсан нь хөтөлбөр хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэж байна. Тухайлбал,

Хүний хөгжил зорилтын хүрээнд:

- Зүрх судасны үндэсний төв байгуулах 130.0 тэрбум;

Амьдралын чанар ба дундаж давхарга зорилтын хүрээнд:

- Эко яармаг-1 ээр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн 206.9 тэрбум;

- Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны 58 барилгыг буулган шинээр барих төслийн 111.0 тэрбум;
- Эдийн засаг зорилтын хүрээнд:**
 - Тавантолгойн 450МВт-ын цахилгаан станц барих 2,092.5 тэрбум;
- Амар тайван, аюулгүй нийгэм зорилтын хүрээнд:**
 - Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төслийн 82.9 тэрбум;
- Улаанбаатар ба дагуул хот зорилтын хүрээнд:**
 - Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг өргөтгөх төслийн 161.2 тэрбум;
 - Багахангай хөнгөн үйлдвэрлэл технологийн парк байгуулах 34.9 тэрбум;
 - Налайхын барилын материал үйлдвэрлэл, технологийн дэд бүтэц байгуулах төслийн 133.6 тэрбум;
 - Туул-1 коллектор болон ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажлын 21.8 тэрбум, нийт 2,974.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 2. Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл (тэрбум төгрөг, хувь)


Эдийн засгийн үзүүлэлт	2020.11.13-ны өдрийн хуулиар			2021.07.07-ны өдрийн хуулиар		
	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он	2023 он
ДНБ-ий өсөлтийн хувь	7.2	4.4	6.5	6.5	4.6	6.3
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	13,951.6	13,068.7	13,403.6	15,748.3	14,852.0	15,925.1
Үүнээс, ДНБ-д эзлэх хувь	33.0	28.6	26.8	37.4	32.5	31.6
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ	3,540.7	3,203.9	3,033.7	3,363.5	3,768.9	4,151.5
Үүнээс, ДНБ-д эзлэх хувь	8.4	7.0	6.1	8.0	8.2	8.2
Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр	26,140.5	25,862.7	26,620.2	25,818.4	27,073.7	27,961.9
Үүнээс, ДНБ-д эзлэх хувь	61.9	56.5	53.2	61.3	59.2	55.5

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай болон түүнд өөрчлөлт оруулалт тухай хууль

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2021 онд гадаадын зээл, тусламж болон улс, нийслэлийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн тухайн онд санхүүжих дүнг 4,881.1 тэрбум төгрөгөөр баталсан. Харин Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлээр нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг 3,363.5 тэрбум төгрөгөөр баталсан нь дунд хугацааны бодлогын хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг бий болгожээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгийн зардлын хэмжээг 3,363.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 8.0 хувьтай тэнцэхээр баталснаас гүйцэтгэлээр 2,982.2 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээ 6.9 хувь байна.

График 1. Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд хөрөнгийн зарлагын эзлэх хэмжээ (тэрбум төгрөг, хувь)



Эх сурвалж: Сангийн яам төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2021 он

Улсын Их Хурлаас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 24 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,763.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,100 төсөл, арга хэмжээг 1,390.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр шинээр эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 110.0 тэрбум төгрөгөөр, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 8.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 22 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 90.0 тэрбум төгрөгөөр бууруулжээ.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг өмнөх онтой харьцуулж төрлөөр ангилан үзвэл,

Хүснэгт 3. Улсын төсвийн 2020, 2021 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)

Санхүүжилтийн эх үүсвэр	2020 он				2021 он				Өмнөх жилээс өссөн, буурсан	
	TAX-ний тоо	Санхүүжих дүн	Санхүүжилт Дүн	Хувь	TAX-ний тоо	Санхүүжих дүн	Санхүүжилт Дүн	Хувь	Төлөв	Гүйц
Улсын төсөв	1,347	1,330.9	1,093.6	82.2	1,101	1,418.9	1,311.4	92.4	88.0	217.8
Концессын эргэн төлөлт	9	323.5	321.0	99.2	5	266.3	266.2	100.0	(57.2)	(54.8)
Нийт дүн	1356	1,654.4	1,414.6	85.5	1,106	1,685.2	1,577.7	93.6	30.8	163.1

Эх сурвалж: Монгол Улсын 2020, 2021 оны төсвийн тухай хууль

Нийт санхүүжилтийн 76.4 хувийг барилга, байгууламж барих 787, 14.2 хувийг тоног төхөөрөмж худалдан авах 118, 6.2 хувийг их засварын 169, 3.2 хувийг техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах 27 төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг салбараар нь авч үзвэл, дэд бүтцийн салбарт 42.8 хувь буюу 721.3 тэрбум, нийгмийн салбарт 40.2 хувь буюу 677.3 тэрбум, бусад салбарт 17.0 хувь буюу 286.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилсан байна.


Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар (тэрбум төгрөг)

Салбарын ангилал	2020 он		2021 он		Өмнөх оноос өссөн, буурсан дүн
	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Дэд бүтэц	734.7	44.4	721.3	42.8	(13.4)
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	500.2	30.2	464.7	27.6	(35.5)
Эрүүл мэнд	128.0	7.7	188.0	11.2	60.0
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	12.7	0.8	24.6	1.5	11.9
Төрийн төв байгууллагууд	176.1	10.6	186.1	11.0	10.0
Хууль сахиулах, батлан хамгаалах	59.6	3.6	59.6	3.5	-
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	39.0	2.4	39.2	2.3	0.2
Хүнд үйлдвэр	4.1	0.2	1.7	0.1	(2.4)
Дүн	1,654.4	99.9	1,685.2	100.0	30.8

Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Сүүлийн жилүүдэд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт буурсан хэдий ч хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сүүлийн 3 жилд тогтвортой хэмжээнд төлөвлөсөн байна.

График 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа (тэрбум төгрөг)



Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Улсын хэмжээнд 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 420.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 109.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 134 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг ТХААГ-т, 254.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 214 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын шийдвэрээр орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон байна.

Тайлант онд Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг шинэчлэн баталж, журамд худалдан авах ажиллагааг төлөвлөх хугацааг төсөв захирагчийн төрлөөр тодорхойлж, өмнөх журмаар ТЕЗ-ийн тухайн оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үнэлгээ хийдэг байсныг өөрчилж, төлөвлөх, тайлагнах үйл ажиллагааг цахимаар хянаж, баталгаажуулахаар журамласан байна.

Худалдан авах ажиллагааны цахим системээр 2021 онд улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 1416 захиалагчийн 21739 тендерийн урилга нийтэлж, тендер шалгаруулалтад 6642 аж ахуйн нэгж оролцож, нийт тендерийн 99.3 хувийг цахим системээр зохион байгуулсан нь өмнөх онтой харьцуулахад 6.2 хувиар нэмэгдсэн, 20788 тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод, бодитой мэдээлэх байдал хангалтгүй хэвээр байна. Тухайлбал,

- Худалдан ажиллагааны цахим системд 2021 онд 27969 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөсөн боловч 22334-г зохион байгуулсан нь төлөвлөлт алдаатай, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой байна.
- 2021 онд худалдан авах ажиллагааны цахим санд 2694 захиалагч бүртгүүлснээс 512 буюу 19.0 хувь нь хуулийн 48 дугаар зүйлийн 48.5¹-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө төсөв батлагдсанаас хойш сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэн.
- Сангийн сайдын 102 дугаар тушаалаар баталсан журмын 3.13 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд өөрчлөлт оруулахаар байгаа боловч зарим ТЕЗ төлөвлөгөөнд хэт олон удаа өөрчлөлт оруулсан нь төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт удаашрах, он дамжих шалтгаан болж байна. Жишээлбэл, НЗД 172, ЭМС 122, БШУС 98, ТӨБЗГ 71 удаагийн өөрчлөлтийг төлөвлөгөөнд оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 74.0 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 18.2 хувьд тендер шалгаруулалтын онцгой журам, 4.6 хувьд зөвлөх үйлчилгээний аргыг ашигласан байна.

Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)

Ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Худалдан авах ажиллагааны арга				Нууцад хамаарах
				НТШ	Онцгой журам	Зөвлөх үйлчилгээ	Шууд худалдан авалт	
Барилга, байгууламж	257	658.5	226.9	206	43	1		7
Их засвар	88	59.3	52.3	69	17			2
Тоног төхөөрөмж	89	217.7	181.6	61	23		1	4
ТЭЗҮ	23	13.7	12.8	2		20		1
ДҮН	457	949.2	473.6	338	83	21	1	14
Эзлэх хувь				74.0	18.2	4.6	0.2	3.1

Эх сурвалж: Сангийн яам

Нийт 14 төсөл, арга хэмжээг нууцад хамруулсан нь:

- Барилга байгууламжийн 6, их засварын 2, тоног төхөөрөмж худалдан авах 4, нийт 40.5 тэрбум төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг ТБОНӨТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасныг үндэслэн нууцад хамааруулсан;
- Сангийн сайдын багцад төлөвлөсөн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төсөл, хилийн боомтын дэд бүтцийн хүрээнд хийгдэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Улсын хэмжээнд/ 2

¹ Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тухайн зээлийн хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулсан байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,685.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 1,311.4 тэрбум төгрөг буюу 92.4 хувийн, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг буюу 100 хувийн санхүүжилтийг олгож, нийт төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 1,577.7 тэрбум төгрөг буюу 93.6 хувьтай гэж Сангийн яам тайлагнасан байна.

Хүснэгт 6. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл		Үүнээс:				Зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ	
					Дүн	Хувь	Ажлын бодит гүйцэтгэлээр		ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан		Дүн	Хувь
							Дүн	Хувь	Дүн	Хувь		
1	МУЕТГД	1	1.1	1.1	1.1	99.8	1.1	99.8	-	-	0.002	0.19
2	МУИХД	1	3.6	3.6	3.4	96.1	1.6	45.7	1.8	50.4	0.1	3.88
3	МУЕС	35	151.1	32.8	32.1	97.8	20.1	61.1	12.0	36.7	0.7	2.16
4	МУШС	6	32.6	22.0	22.0	100.0	21.9	99.7	0.1	0.3	0.004	0.02
5	ЗГХЭГД	48	111.5	31.0	28.7	92.6	21.4	69.0	7.3	23.6	2.3	7.43
6	БОАЖС	19	32.0	18.0	16.8	93.2	13.3	73.8	3.5	19.4	1.2	6.82
7	БХС	5	13.1	6.2	6.1	99.3	4.5	74.1	1.6	25.2	0.040	0.66
8	ГХС	2	4.3	4.3	4.3	98.5	4.3	98.5	-	-	0.1	1.47
9	СаС	9	289.9	88.2	54.8	62.2	38.3	43.5	16.5	18.7	33.4	37.83
10	ХЗДХС	22	69.1	29.2	28.9	99.0	28.9	99.0	-	-	0.3	1.04
11	ХНХС	41	73.1	24.6	23.6	95.7	14.7	59.5	8.9	36.2	1.1	4.30
12	БХБС	181	425.0	193.3	182.6	94.5	143.3	74.1	39.3	20.4	10.7	5.53
13	БШУС	354	887.8	361.8	337.3	93.2	257.3	71.1	80.0	22.1	24.6	6.79
14	СоС	86	549.0	92.8	89.7	96.6	59.6	64.2	30.1	32.5	3.1	3.35
15	ЗТХС	108	659.7	233.6	220.2	94.3	168.3	72.1	51.9	22.2	13.4	5.74
16	УУХҮС	1	3.7	1.7	1.7	97.0	1.7	97.0	-	-	0.1	3.03
17	ХХААХҮС	40	50.4	21.1	20.0	94.8	16.0	75.6	4.0	19.2	1.1	5.23
18	ЭХС	30	153.0	38.1	36.6	96.2	24.0	63.2	12.6	33.0	1.4	3.79
19	ЭМС	96	320.7	188.0	175.7	93.5	71.9	38.3	103.9	55.2	12.2	6.51
20	АТГД	2	1.2	1.2	1.1	99.2	1.1	99.2	-	-	0.009	0.78
21	ШЕЗ	2	4.0	4.0	3.7	92.4	3.7	91.8	0.0	0.7	0.3	7.57
22	УЕП	10	43.5	20.3	20.0	98.2	15.1	74.2	4.9	24.0	0.4	1.78
23	МУЕА	1	1.5	1.5	0.6	42.5	0.6	42.5	-	-	0.9	57.51
24	СЗХД	1	0.5	0.5	0.4	73.9	0.4	73.9	-	-	0.1	26.07
Улсын төсвийн дүн		1101	3,881.5	1,418.9	1,311.4	92.4	933.1	65.8	378.4	26.7	107.5	7.57
Концессын дүн		5	849.8	266.3	266.2	100.0	266.2	100.0	-	-	0.03	0.01
Нийт		1106	4,731.2	1,685.2	1,577.7	93.6	1,199.3	71.2	378.4	22.5	107.5	6.38

Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.3-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх шийдвэр гаргасан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийг авч үзвэл, санхүүжих дүнгийн 71.2 хувь буюу 1,199.3 тэрбум төгрөгийг ажлын бодит гүйцэтгэлээр олгож, дээрх тогтоолыг үндэслэн 22.9 хувь буюу 378.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Харин ТЕЗ-дын тайлант онд зарцуулаагүй үлдэгдэл 8.2 хувь буюу 107.4 тэрбум төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсний 32.0 хувь буюу 34.4 тэрбум төгрөг нь худалдан авах ажиллагааны хэмнэлтээс, 40.0 хувь буюу 43.0 тэрбум төгрөг нь ажлын гүйцэтгэл гараагүйгээс, 27.9 хувь буюу 30.0 тэрбум төгрөг нь гэрээ байгуулаагүйгээс тус тус шалтгаалжээ.

Тайлант онд улсын төсвөөр санхүүжиж, комисс хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний үр дүнг салбараар гаргаж харьцуулахад төмөрбетон гүүр, соёлын төв, эмнэлгийн барилгын хүчин чадал нэмэгдэж, бусад салбарт ашиглалтад орсон барилга, байгууламжийн хүчин чадал өмнөх 5 жилийн дунджаас буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтээр ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа (хүчин чадлаар)

Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Өмнөх 5 жилийн дунджаас өссөн, буурсан
Хатуу хучилттай авто зам	км	176.6	844.8	135.5	63.6	155.9	208.9	(66.4)
Төмөр бетон гүүр	у/м	289.9	509.6	202.4	341.7	659.6	1208.5	807.9
ЦДАШ	км	65.3	0	150	2000	326.1	10	(498.3)
Цэцэрлэг	орны тоо	2170	4295	1580	10455	8515	4375	(1028.0)
Сургууль	суудлын тоо	8008	15070	3968	17110	10800	6104	(4887.2)
Дотуур байр	орны тоо	620	900	170	1580	2145	675	(408.0)
Соёлын төв	суудлын тоо	1400	0	1050	4180	4240	2640	466.0
Хүн эмнэлэг	орны тоо	545	110	60	348	645	536	340.4

Эх сурвалж: УАГ

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЭГДСЭН БОДЛОГООР ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН Ч БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх нэг эх үүсвэр нь улсын төсөв байхаар заасан бөгөөд хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан төсөл, хөтөлбөрийн улсын төсвийн санхүүжилтийг “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт”-д батлуулан хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 8. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан 2021 онд үргэлжлэн болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт (тэрбум төгрөг)

ТЭЗ	Санхүүжилтийн эх үүсвэр												НИЙТ	
	Улс, нийслэл төсөв		Зээл, тусламж		Концесс, ТХХТ		Шууд хөрөнгө		Хөгжлийн банкны санхүүжилт		Эх үүсвэргүй			
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн
БОАЖС			3	36.4	1	31.9	1	12.1					5	80.4
БХБС	2	53.9	12	444.6							1	206.9	15	705.4
БШУС	3	246.5	5	94.4									8	340.9
МУЕС	1	37.5	1	31.7									2	69.2
ЗГХЭГД	1	0.9	1	0.3									2	1.2
ЗТХС	9	427.3	4	231.2	1	565.8	2	1,411.7					16	2,636.0
НЭДТГ	2	3.5	10	341.5							3	122.0	15	467.0
CaC	4	48.5	13	252.7									17	301.2
CoC	6	190.6											6	190.6
УУХҮС			1	1,013.4	3	730.9	8	1,436.1	1	18.9	1	32.2	14	3,231.5
ХЗДХС	7	58.3	5	50.0							1	20.7	13	129.0
ХНХС			4	48.1									4	48.1
ХХААХҮС	1	0.5	9	295.4			2	28.6					12	324.5
МУШС			4	121.0									4	121.0
ЭМС	1	2.6	7	158.5							1	32.5	9	193.6
ЭХС	5	85.4	9	609.4	1	109.1			2	123.6	1	358.2	18	1,285.7
ДҮН	42	1,155.5	88	3,728.6	6	1,437.7	13	2,888.5	3	142.5	8	772.5	160*	10,125.3
Эзлэх хувь		11.4		36.8		14.2		28.5		1.4		7.6		

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Тайлбар: *ТАХ-ний тоог эх үүсвэрийн давхардлаас шалтгаалж давхардсан тоогоор илэрхийлэв.

Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг хоорондын уялдааг бүрэн хангаагүй нь Хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна

1.2 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д тусгасан төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх дүн Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2021 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт улсын төсвөөс олгох санхүүжилтийн дүнгээс 263.4 тэрбум төгрөгөөр илүү буюу нийт санхүүжилтийн 81.4 хувийг хөтөлбөрт заасан арга хэмжээнд зарцуулахаар байна.

1.3 Хөтөлбөрт тусгасан зарим төсөл, хөтөлбөрийн 2021 оны санхүүжилтийг төсвийн тухай хуульд бүрэн хэмжээгээр батлаагүй нь Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

Соёлын сайд:

- Үндэсний урлагийн их театрын барилгын 50,840.0 сая;

ХЗДХС:

- Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төслийн 1,898.0 сая;
- Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх 15,000.0 сая;
- Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл хийх 10,000.0 сая;

ХХААХҮС:

- Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх төслийн 500.0 сая;

ЗГХЭГД:

- Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийн 919.7 сая, нийт 79,157.7 сая төгрөгийн санхүүжилтийг огт тусгаагүй байна.

Санхүүжүүлэх дүнг хөтөлбөрт заасан хэмжээгээр төсөвт тусгаагүй:

- Хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрийн дагуу 2021 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км автозам, Даланжаргаалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозам, Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай автозам, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63

км авто замын ажлын хугацааг 1 жилээр сунгаж, тухайн жилд олгох санхүүжилтийг 74,406.0 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн.

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар дээрх 4 замын төсөлд нэмж 50,855.0 сая төгрөгийн санхүүжилт баталсан боловч Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км автозамын санхүүжилт 10,582.3 сая, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын санхүүжилт 33,790.3 сая төгрөгөөр тус тус дутуу, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозамын санхүүжилт 3,420.5 сая, Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай автозамын санхүүжилт 8,023.8 сая төгрөгөөр тус тус тусгаасан байна.

1.4 Хөтөлбөрт туссан төсөл, хөтөлбөрийн 2021 оны санхүүжилтэд концесс, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээний санхүүжих дүн 14.2 хувийг, Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжих 3 төслийн санхүүжих дүн 1.4 хувийг тус тус эзэлж байна.

1.5 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад 2021 онд дотоодын нөөц, боломжоос илүүтэй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн 36.8 хувийг гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь ирээдүйд өр, зээлийн дарамт нэмэгдэх эрсдэлтэй тул Хөгжлийн банкны хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулж, эх үүсвэр бий болгох, Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрт эдийн засгийн үр ашгийн давтан тооцоолол хийж, боломжит эх үүсвэр рүү шилжүүлэх арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна.

1.6 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна” гэж заасны дагуу 2021 онд хэрэгжиж буй 30.0 тэрбумаас дээш өртөгтэй ихэнх төсөл, хөтөлбөрүүд Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байна.

1.7 Харин хуулийн ХҮИИ.1.7 дугаартай 52.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулааны станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/ (хөтөлбөрт Бүс нутгийн хөгжил зорилтын хүрээнд 10 аймгийн төвд дулааны станц барихаар төлөвлөсөн боловч Дорнод аймаг хамрагдаагүй), төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр нэмж баталсан 110.0 тэрбум төгрөгийн өртөгтэй хуулийн ХИХ.3.30 дугаартай Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний саналд Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын судалгаа хийж, үр дүнд үнэлгээ өгөөгүй байна.

1.8 Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолоор баталсан урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ерөнхий нэршлээр баталсан нь 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт бодлогын баримт бичигт заасан хүрэх үр дүнд үр нөлөө үзүүлсэн эсэхийг тооцоход хүндрэлтэй байна.

1.9 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1²-т заасан хугацаанд батлаагүй, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан нь төсвийн төлөвлөлтийн цагалбарын хувьд ТЕЗ нар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5-д заасан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан байх шаардлагыг хангахгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийг Сангийн яам 2019 оноос эхлэн нэвтрүүлсэн ч ТЕЗ нар бүрэн ашиглахгүй байна

1.10 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгох, төсвийн төсөлд тусгах эрх зүйн орчныг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, 2019 оны 282 дугаар

² Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу хэлэлцэж эцэслэн батална.

тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар бүрдүүлсэн байна.

1.11 Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны аппликейшн хэлбэрээр ашиглалтад оруулж төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгосон нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах алхам болсон ч төлөвлөх үйл явцад уг системийг бүрэн хэмжээнд ашиглаагүй байна.

1.12 Тайлант онд Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна.

1.13 Засгийн газраас шинэчлэн баталсан журмын агуулгыг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журамтай харьцуулбал, төслийн гэрээнд гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай заалт нэмэгдэж, төслийн санхүүжүүлэхэд бүрдүүлэх материалыг нарийвчлан зааж өгсөн байна.

1.14 Дээрх журам 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журамтай агуулгын хувьд ижил байх тул аудитын тайланд нийцлийн шалгуурыг хуучин журмын заалтаар авсан болно.

1.15 Журамд заасны дагуу ТЕЗ нь хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн эрэмбэлэн үнэлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатайг баримтаар нотолж, цаглабарт заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр байна.

1.16 Зарим ТЕЗ нар тайлант онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг боловсруулахдаа цахим системийн шаардлагын дагуу төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- Дорноговь аймгийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, үнэлгээ хийгээгүй;
- Баянхонгор аймгийн Засаг дарга 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 1а/425 дугаартай албан бичгээр ЭМС-д хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санал хүргүүлэхдээ БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний 1,100.0 сая төгрөгийн 2 ТАХ-г жагсаалтаар хүргүүлсэн нь эдгээр арга хэмжээ төсвийн саналд тусгахгүй байх нөхцөл болсон.

1.17 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3³-т заасны дагуу ТЕЗ-д 2021 оны төсвийн саналаа 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4⁴, 8.4.5⁵-д заасны дагуу Сангийн яам нэгтгэн боловсруулж, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

1.18 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг өмнөх онтой харьцуулж эдийн засгийн ангиллаар авч үзвэл,

Хүснэгт 9. Улсын төсвийн 2020, 2021 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөг)

Хөрөнгө оруулалтын ангилал	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль			Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль			Зөрүү нэмэгдсэн /+/, хасагдсан /-/			
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
Хөрөнгө оруулалт	Шинэ	444	1,543.1	353.2	257	658.5	226.9	(187)	(884.6)	(126.3)
	Үргэлжлэх	473	2,054.4	700.8	531	2,620.9	857.1	58	566.5	156.3

³ Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

⁴ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх.

⁵ Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор УИХ-д өргөн мэдүүлэх.

Их засвар	Шинэ	250	122.5	86.5	88	59.3	52.3	(162)	(63.2)	(34.2)
	Үргэлжлэх	24	58.1	26.9	81	57.6	35.3	57	(0.5)	8.4
Тоног төхөөрөмж	Шинэ	140	120.2	108.8	90	222.4	186.3	(50)	102.2	77.5
	Үргэлжлэх	6	196.4	48.9	27	210.4	15.6	21	14.0	(33.3)
ТЭЗҮ	Шинэ	10	23.5	5.8	23	13.7	12.8	13	(9.8)	7.0
	Үргэлжлэх	0	0	0	4	38.7	32.6	4	38.7	32.6
ДҮН	Шинэ	844	1,809.3	554.3	458	953.9	478.3	(386)	(855.4)	(76.0)
	Үргэлжлэх	503	2,308.9	776.6	643	2,927.6	940.6	140	618.7	164.0
НИЙТ		1347	4,118.2	1,330.9	1,101	3,881.5	1,418.9	(246)	(236.7)	88.0

Эх сурвалж: Монгол Улсын 2020, 2021 оны төсвийн тухай хууль

1.19 Дээрх хуулиар баталсан төсөл, арга хэмжээний 41.6 хувь буюу 478.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 458 нь шинээр, 58.4 хувь буюу 940.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 643 нь үргэлжлэн хэрэгжихээр байна. Үүнийг өмнөх 2020 онтой харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 1.9 дахин, санхүүжих дүн 80.7 тэрбум төгрөгөөр буурч, үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжих дүн 168.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг дуусгах бодлого баримталсан гэж үзэхээр байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй 110 төсөл, арга хэмжээг УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмсэн байна

1.20 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэлэлцүүлгийн явцад 181.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 75.4 тэрбум төгрөгөөр санхүүжих 110 төсөл, арга хэмжээг нэмж, 15 төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжих дүнг 66.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь ТЭЗ нар төсвийн төлөвлөлтийг хугацаанд нь чанартай боловсруулаагүй, төсвийн төсөлд тусгаж чадаагүй төсөл, арга хэмжээгээ тойргийн гишүүдээр дэмжүүлэхээр хүргүүлж, гишүүдийн дэмжлэгээр хуульд баталсан ч хөрөнгө оруулалтын шинж чанар агуулаагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй саналыг төсөл, арга хэмжээ болгон жагсаалтад батлуулсан байна.

1.21 Төсвийн тухай хуульд тусгасан дээрх төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс нийт 42,212.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна. Үүнээс шалтгаалж:

- 7,640.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг огт ашиглаагүй төсөвт буцаан татсан;
- 7,898.2 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг ТЭЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

1.22 Хэлэлцүүлгийн явцад нэмэгдсэн дараах төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁶-т заасан төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанарыг агуулаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ биш байна. Тухайлбал,

БХБС-ын багцад:

- 2018-2021 онд шинэ хороо, гэр хорооллын айл өрхүүдийн цэвэр, бохир, дулааны шугам, эко хороо төсөл нэрээр нийт 19,900.4 сая төгрөгийн өртөгтэй 7 ТАХ-а хэрэгжүүлэн 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 11,637.6 сая төгрөгөөр санхүүжүүлж, 600 гаруй айл өрхийн амины орон сууцны гадна, дотор дулаалга, био жорлонгийн ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн;
- Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум/ 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний үр дүнг ашиглагч нь хувийн хэвшлийн байгууллага байна.

БОАЖС-ын багцад:

- Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/ ТАХ бүрэн хэрэгжээгүй, 75.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ба уг арга хэмжээ нь урсгал зардлын шинжтэй, байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй байна.

ХХААХҮС-ын багцад:

- 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бяслагны үйлдвэр /Хөвсгөл, Жаргалант, Цагаан-Уул, Галт, Тосонцэнгэл, Ренчинлхүмбэ, Цагаан-Үүр, Рашаант, Их-Уул сум/-ийн газрын зөвшөөрөл олгогдоогүй, 2021 оны санхүүжилт болох 1,400.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Соёлын сайдын багцад:

- 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,432.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн "Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Дорноговь, Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/-ийн хүрээнд: Дорноговь аймагт "Нутгаа танья" байгалийн ухааны нэгдмэл лаборатори байгуулах төслөөр 1 суманд VR болон AR технологийн сургалтад 14.0 сая, Монгол ёс заншлын сургалтад 3.0 сая, байгалийн ухааны хичээлүүдийн онол, арга зүйн сургалтад 5.6 сая, нийт 22.6 сая төгрөгөөр 8 суманд тус бүр 180.8 сая төгрөгөөр сургалт явуулсан.

1.23 Дээрх арга хэмжээнүүд иргэдийн амьдралыг сайжруулж, аятай тухтай амьдрах орчныг дэмжиж, тодорхой ажлын байр бий болгож байгаа ч урт хугацаа, хөрөнгө шаардах, цөөн

⁶ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

иргэдийг хамруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийн шаардлагыг хангаагүй зэрэг сул талуудтай байна.

1.24 Иймд нийтийг хамарсан, богино хугацаанд үр дүнгээ өгөх, өртөг багатай, иргэдийн оролцоог хангасан Үндэсний хөтөлбөр хэлбэрээр боловсруулж, Төсвийн тухай хуульд нийцүүлэн салбарын холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх нь үр дүнтэй байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 60 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ

1.25 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар 24 ТЕЗ-ийн төсвийн багцад баталсан 1101 төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷-т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагатай нийт 141,069.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 барилга, байгууламжийг төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр хуульд батлуулсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

1.26 Үүнээс, өмнөх оноос үргэлжилэн болон шинээр хэрэгжсэн нийт 24,199.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тооцооллыг 2021 оны жилийн эцсийн байдлаар баталгаажуулаагүй байгаагаас 2,199.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр гүйцэтгэж, ашиглалтад хүлээн авсан байна.

1.27 Төсвийн тухай хуульд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталж байгаа нь нэг талаас, төсвийн төлөвлөлтийн зарчмыг алдагдуулж, нөгөө талаас “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/-ийн 4 дүгээр бүлгийн 4.10 дахь хэсэгт “Барилгын нэгдсэн төсвийн тооцоонд зураг төсөл хайгуулын ажлын зардал”-ыг тусгахаар заасантай холбоотой байна.

1.28 Өөрөөр хэлбэл, зураг төсөл боловсруулж, магадлал хийлгэх үе шатны ажлын зардлыг барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үе шатны ажлын төсвийн бүрэлдэхүүнд баталж байгаа нь зураг төсөл боловсруулах үе шатанд санхүүжилт авах боломжгүйд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.29 Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйл.Барилгын зураг төсөлд тавих шаардлага хэсгийн 12.1.1-д “эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2-т “төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй, үүнд: эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-т “газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх”, 35.1.6-д “газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно” гэж заасныг зөрчиж, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2021 оны төсвийн хуульд батлуулсан байна. Тухайлбал,

Газрын зөвшөөрөлгүй:

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан 2021 онд шинээр эхлэх барилга байгууламжийн 257 ТАХ-ээс 37,265.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 барилгыг барих газрын зөвшөөрөл аваагүй, хаана барих нь тодорхойгүй байдлаар төлөвлөжээ. Мөн 2020-2021 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 1,513.0 сая төгрөгийн 3 ТАХ-ний газрын асуудал бүрэн шийдэгдээгүйгээс хэрэгжилт хангаадаагүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу)
- Соёлын сайдын багцад хэрэгжүүлэхээр баталсан хуулийн XIV.1.61 дугаартай Түүх шашны соёлыг дэлгэрүүлэх төв “Богд Зонхова” /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Тасганы овоо/ ТАХ-г Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/55 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсэн 16,913 м.кв газарт хэрэгжүүлж байна. Тус барилга

⁷ хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3	III.1.1.25	Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/	2021	2022	5,000.0	1,000.0	2,500.0	(1,500.0)
4	III.1.1.30	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дорнод, Хэрлэн сум/	2021	2023	9,900.0	1,500.0	3,300.0	(1,800.0)
5	V.1.1.22	Удирдлагын академийн кампус, өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2021	2023	18,827.2	500.0	9,413.6	(8,913.6)
6	V.1.1.24	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2021	2022	7,000.0	1,000.0	3,500.0	(2,500.0)
7	V.3.1.6	"Дижитал-Эрдэнэт" төсөл /Орхон/	2021	2023	10,000.0	1,000.0	3,333.3	(2,333.3)
8	X.2.1.1	Эрэнцэвэн шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн отряд шинээр байгуулах /Дорнод, Чулуунхороот сум/	2021	2022	6,000.0	1,300.0	3,000.0	(1,700.0)
9	X.2.3.1	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт /Улсын хэмжээнд/	2021	2023	17,325.4	1,000.0	5,775.1	(4,775.1)
10	XI.1.1.8	Хүүхдийн парк байгуулах /Дорноговь, Сайншанд сум, 3 дугаар баг/	2021	2022	5,438.7	1,000.0	2,719.4	(1,719.4)
11	XI.4.1.8	Ахмадын сувиллын барилга, 60 ор /Дорноговь, Сайншанд сум, 2 дугаар баг/	2021	2022	4,461.0	1,000.0	2,230.5	(1,230.5)
12	XII.1.62	Бичил цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021	2022	4,680.0	680.0	2,340.0	(1,660.0)
13	XII.1.101	Цэвэр, бохир усны шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3, 4, 26, 36 дугаар хороо/	2021	2022	4,500.0	1,000.0	2,250.0	(1,250.0)
14	XII.1.104	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	2021	2022	5,000.0	1,500.0	2,500.0	(1,000.0)
15	XII.1.105	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2021	2022	5,000.0	1,500.0	2,500.0	(1,000.0)
16	XII.1.107	Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/	2021	2023	9,389.0	1,500.0	3,129.7	(1,629.7)
17	XIII.1.1.216	Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Тонхил сум/	2021	2022	2,800.0	320.0	1,400.0	(1,080.0)
18	XIII.1.1.219	Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2021	2023	15,000.0	1,000.0	5,000.0	(4,000.0)
19	XIII.1.1.238	Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/	2021	2022	7,300.0	1,050.0	3,650.0	(2,600.0)
20	XIII.1.1.239	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2021	2022	4,000.0	500.0	2,000.0	(1,500.0)
21	XIII.1.1.242	Дотуур байрын барилга, 200 ор /Хөвсгөл, Мөрөн сум, 14 дүгээр баг/	2021	2022	2,400.0	200.0	1,200.0	(1,000.0)
22	XIII.1.1.248	Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	2021	2022	5,000.0	200.0	2,500.0	(2,300.0)
23	XIII.1.1.257	Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Цээл сум/	2021	2022	3,938.5	400.0	1,969.3	(1,569.3)
24	XIII.1.1.260	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 84 дүгээр сургууль/	2021	2022	3,800.0	50.0	1,900.0	(1,850.0)
25	XIII.1.1.264	Сургуулийн барилга, спорт заал, 940 суудал /Баян-Өлгий, Өлгий сум/	2021	2023	8,800.0	200.0	2,933.3	(2,733.3)
26	XIV.1.50	Соёл, урлагийн ордон, 500 суудал /Дорноговь, Замын-Үүд сум, 3 дугаар баг/	2021	2023	7,000.0	1,000.0	2,333.3	(1,333.3)
27	XIV.1.55	Музей, номын сангийн цогцолбор /Дархан-Уул, Дархан сум/	2021	2022	5,000.0	1,000.0	2,500.0	(1,500.0)
28	XIV.1.59	Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори /Төв, Зуунмод сум/	2021	2023	18,000.0	500.0	6,000.0	(5,500.0)
29	XIV.1.60	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	2021	2023	9,500.0	1,000.0	3,166.7	(2,166.7)
30	XIV.1.61	Түүх шашны соёлыг дэлгэрүүлэх төв "Богд Зонхова" /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Тасганы овоо/	2021	2022	5,500.0	1,500.0	2,750.0	(1,250.0)
31	XV.1.1.56	Хялганат-Хангал чиглэлийн эхлэлийн хатуу хучилттай авто зам, 10 км /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	2021	2022	5,000.0	1,000.0	2,500.0	(1,500.0)
32	XV.1.1.57	Гачууртын авто замын төгсгөлөөс зүүн тийш үргэлжлэх авто зам, 4.7 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/	2021	2022	5,829.5	1,829.5	2,914.8	(1,085.3)
33	XV.1.1.62	Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/	2021	2022	8,161.7	1,000.0	4,080.9	(3,080.9)
34	XV.1.1.65	Сумын төвийн авто зам, 7 км /Архангай, Өндөр-Улаан сум/	2021	2023	6,300.0	300.0	2,100.0	(1,800.0)
35	XVII.1.12	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	2021	2023	12,000.0	1,500.0	4,000.0	(2,500.0)
36	XIX.1.43	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилга, 200 ор /Дорнод, Хэрлэн сум/	2021	2023	9,500.0	1,500.0	3,166.7	(1,666.7)

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

1.31 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах

хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй зарим төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулсан байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинж агуулаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн санааас шийдвэрлэх боломжтой зарим төсөл, арга хэмжээ (сая төгрөг)

Хуулийн дугаар	ТАХ-ний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
V.1.1.3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/	2020	2021	1,033.0	633.0
XII.1.2	Шинэ хороо төсөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23, 39 дүгээр хороо/	2020	2021	1,150.0	1,100.0
XII.1.3	Шинэ хороо төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/	2020	2021	7,600.0	3,800.0
XII.1.5	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	2020	2021	2,000.0	1,500.0
XII.1.7	Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 10, 11 дүгээр хороо/	2020	2021	400.0	350.0
XII.1.17	Жишиг гудамж төсөл-2 /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2020	2022	3,300.0	1,000.0
XII.1.52	Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есенбулаг сум/	2020	2021	200.0	150.0
XII.1.65	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1, 2, 4, 6, 8, 9, 13, 19 дүгээр хороо/	2021	2022	1,500.0	750.0
XII.1.79	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо, Цоглог хотхон, 19 дүгээр хороо, 61 дүгээр байр/	2021	2021	60.0	60.0
XII.1.84	Олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18, 19, 20 дугаар хороо/	2021	2022	1,500.0	500.0
XII.1.90	Сумдад хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Булган/	2021	2022	1,300.0	820.0
XII.1.92	Тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, 10 айл хэсэг, Гачуурт голын эрэг, Зүүн дэнжийн хойд тал/	2021	2021	100.0	100.0
XII.1.93	Тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 50 дугаар цэцэрлэг/	2021	2021	45.0	45.0
XII.1.103	Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум/	2021	2022	300.0	100.0
XII.1.113	Эко хороо төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021	2022	3,000.0	1,500.0
XII.2.26	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо/	2020	2021	229.9	100.0
XII.2.43	Багийн тохижилт, гэрэлтүүлэг, камержуулалт /Увс, Улаангом сум, 9 дүгээр баг/	2021	2021	300.0	300.0
XII.3.7	Эко жорлон төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 10, 12, 13, 14, 15 дугаар хороо/	2021	2022	1,000.0	500.0
XIV.3.1	"Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Дорноговь, Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/	2020	2021	1,500.0	1,500.0
НИЙТ				26,517.9	14,808.0

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Зарим барилга, байгууламжийг олон жилээр үргэлжлүүлэн төлөвлөж байгаа нь хэрэгцээ шаардлага хангахгүй болох, өртөг нэмэгдэх шалтгаан болж байна

1.32 Шилжих төсөл, арга хэмжээний жагсаалтад баталсан 4-өөс дээш жил үргэлжилж байгаа нийт 489,476.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 73 барилга, байгууламжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээр төсөл, арга хэмжээний анхны төсөвт өртөг хэрэгжилтийн явцад дунджаар 1.7 дахин нэмэгдсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү)

Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй 4-өөс дээш жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

№	Эхэлсэн хугацаа /оноор/	Үргэлжилж байгаа хугацаа /жилээр/	ТАХ-ний тоо	Анхны төсөвт өртөг	Төсөвт өртөг	Өртөг нэмэгдсэн байдал /дахин/
1	2010	12	5	21,048.8	68,845.5	3.3
2	2011	11	5	19,569.9	47,178.5	2.6
3	2012	10	2	11,100.0	21,492.2	1.9
4	2013	9	3	16,162.0	31,898.8	2
5	2014	8	4	18,448.0	45,205.8	2.5
6	2015	7	2	9,359.7	12,618.1	1.3
7	2016	6	2	14,328.3	19,433.9	1.4
8	2018	4	50	185,140.5	242,803.5	1.3
Нийт				295,157.2	489,476.3	1.7

Эх сурвалж: УАГ

1.33 Олон жилээр үргэлжлэн хэрэгжиж байгаа барилга, байгууламжийн угсралтын ажлын явцад технологийн алдаа гарсан, санхүүжилт хүрэлцээгүй зурэг шалтгаанаар төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зарим онд төсвийн тухай хуульд тусгаагүй, Барилгын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1⁸-д заасны дагуу 7 сараас дээших зогсолтын хугацаанд хамгаалалтын горимд шилжүүлэхгүй орхиж байгаа нь барилгын чанар муудах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх эрсдэлийг дагуулж, цаашид гэрээний үүргээ биелүүлээгүй, технологийн алдааг тухай бүр нь залруулаагүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцож, зөрчлийг цаг хугацаанд нь арилгуулж байх шаардлагатай байна.

1.34 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.1.4-т “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, 13.1.5-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх”-аар заасан нь хуулийн хэрэгжилтээр төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд санхүүжилтийг бодитой төлөвлөх, өртгийг нэмэгдүүлэхгүй байх томоохон алхам болжээ.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж эхлээд дуусаагүй орхигдсон 184.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 59 барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна

1.35 Төсвийн хөрөнгөөр 2008-2020 онд хэрэгжүүлж эхэлсэн, дуусаагүй орхигдсон нийт 184,091.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 59 төсөл, арга хэмжээг 85,032.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу)

1.36 Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 19 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах”-ыг ТЕЗ нарт даалгасан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.37 Аудитын явцад хийсэн судалгаагаар илэрсэн орхигдсон эдгээр 59 барилга, байгууламжийн ихэнхийг буюу 32.2 хувийг цахилгаан, дулааны инженерийн байгууламж эзэлж байна.

Дүрслэл 1. Дуусаагүй орхигдсон барилгуудын ангилал



Эх сурвалж: УАГ

1.38 МХЕГ-аас ирүүлсэн мэдээллээр 2016-2021 онд хамгаалалтын горимд шилжүүлсэн 13 барилга байгаа бөгөөд дээрх орхигдсон барилгаас зөвхөн 1 барилга буюу Сэлэнгэ аймгийн Мандал суманд баригдаж буй 100 ортой цэцэрлэгийн барилгыг хамгаалалтын горимд авсан байна.

1.39 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ ялангуяа барилга, байгууламжид төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн систем, цахим сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал ажиглагдаж байна.

⁸ Барилгын ажлыг долоон сараас дээш хугацаагаар түр зогсоосон бол захиалагч барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулж, энэ талаар барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэж, холбогдох шийдвэрийг гаргуулна. Барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах шийдвэрт хамгаалалтын горимын хугацаа, нөхцөлийг тусгана.

1.40 Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг бүртгэлжүүлж, кодлох, түүгээр дамжуулан бүтээн байгуулах, ашиглах бүхий л хугацаанд нэгдсэн хяналтын тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.

1.41 Цаашид сүүлийн 20 жилийн хугацаанд улсын хэмжээнд төсвийн хөрөнгөөр барьж, ашиглаж байгаа хөрөнгийн тооллого, бүртгэлийг хийж, паспортжуулан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, системээр дамжуулан хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зах зээлийн чадамжид нийцсэн цөөн тооны арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөх нь эдийн засгийн хувьд өгөөжтэй байна

1.42 Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 76.4 хувийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын барилгын салбарын хүчин чадлыг гарцаар буюу сүүлийн 10 жилийн гүйцэтгэлээр тооцож үзвэл, нийт бүтээн байгуулалтын ажлын 97.7 хувийг хувийн хэвшил гүйцэтгэж, жилд дунджаар 4,050.4 тэрбум⁹ төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга угсралтын ажил гүйцэтгэх чадамжтай байна.

1.43 Улсын хэмжээний тоон мэдээллээс харахад 2018 онд хамгийн их буюу нийт гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын 94.1 хувь (4,050.4 тэрбум төгрөгийн өртөгтэй) нь ашиглалтад орсон байна.

Хүснэгт 13. Улсын хэмжээнд ашиглалтад оруулсан үндсэн фонд (тэрбум төгрөг, хувь)

Статистик үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Барилга угсралт, их засварын ажил	1,034.1	1,845.9	2,702.9	3,267.4	3,356.3	3,783.6	4,305.6	4,869.8	5,208.8	4,513.2
Ашиглалтад оруулсан төсөвт өртөг	895.7	1,564.7	1,479.4	1,965.1	2,744.9	2,572.9	4,050.4	3,594.9	2,761.2	2,689.2
Ашиглалтад орсон хувь	86.6%	84.8%	54.7%	60.1%	81.8%	68.0%	94.1%	73.8%	53.0%	59.6%

Эх сурвалж: www.1212.mn

1.44 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламжийн ажил барилгын салбарын нийт чадавхийн 53.0 хувийг эзэлж байна.

Дүрслэл 2. Улсын хэмжээнд 2021 онд нийт ашиглалтад орсон барилга, байгууламжид улсын төсвийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон барилга, байгууламжийн эзлэх хэмжээ



Эх сурвалж: www.1212.mn, аудитын тооцоолол

1.45 Манай улсын эдийн засаг, санхүүгийн цар хүрээ хязгаарлагдмал, гадаад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байхад бага хэмжээний хөрөнгийн эх үүсвэрээ олон тооны төсөл, арга хэмжээнд амсуулах хэлбэрээр хуваарилж байгаа нь хөрөнгийн үр ашгийг бууруулж, дуусаагүй орхигдсон барилга, байгууламж нэмэгдэх, хөрөнгө оруулалтын шинж чанар агуулаагүй олон тооны жижиг, үр нөлөө багатай төсөл, арга хэмжээнд хөрөнгө зарцуулах нөхцөл болж байна.

1.46 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтээс харахад ДНБ-ий үйлдвэрлэл 2020 онтой харьцуулахад 2021 онд 1.4 хувиар өсөхөд төсвийн зарлага 12.2 хувиар өссөн нь төсвөөр дамжуулан зарлагадсан мөнгөний өсөлт хийж, бүтээж, бий болгосон баялагийн өсөлтөөс 8.7 дахин их байгааг харуулж байна. Иймд төсвийг хуулийн дагуу төлөвлөдөг, төсөвлөдөг,

⁹ 2018 онд хамгийн их буюу төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга байгууламж ашиглалтад орсон

зарцуулдаг тогтолцоо бүрдүүлэх, хуулийг төрийн бүхий л түвшинд сахин биелүүлж, хөрөнгө оруулалтын бодлогоо зөв тодорхойлж, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч иргэн, байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлж, мөрдөж буй хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна

1.47 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий 851 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 258 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж, боловсруулсан зураг, төслийг магадлалаар баталгаажуулах ажлыг Барилгын хөгжлийн, Зам тээврийн хөгжлийн, Эрчим хүчний хөгжлийн төвүүд зохион байгуулж байна.

1.48 Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2.2-т “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” шаардлага тавьж байгаа ч барилга байгууламжийн зураг төслийг ямар нөхцөл бүрдсэн үед хэн боловсруулах, ямар шаардлага тавигдах зэргийг нарийвчлан тодорхойлоогүйгээс улсын хэмжээнд төрийн байгууллагуудын захиалгаар хийсэн төлбөрийг нь төлөөгүй эсвэл төлсөн, бүртгэлтэй, бүртгэлгүй, төрийн захиалгаар боловсруулсан боловч хувийн хэвшлийн оюуны өмчид бүртгэсэн нэг маягийн болон нарийвчилсан олон тооны зураг төслийг боловсруулсан байна.

1.49 Гэвч эдгээр зураг төслийг бүртгэх, хянах мэдээллийн нэгдсэн систем байхгүй, БХБЯ, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, НХОГ-т хичнээн зураг, төсөв бүртгэлтэй, түүнээс хэдийг нь тухайн жилийн төсвийн төлөвлөлтөд ашигласан талаарх мэдээлэл байхгүй байна.

1.50 Мэдээллийн хомс байдлаас шалтгаалан зарим зураг төсөл зохиогч байгууллагад зургийн үнийг давхардуулан төлөвлөж, олгох тохиолдол гарч байна. Тухайлбал,

БШУС-ын багцад:

- Сургуулийн өргөтгөлийн барилга /УБ, ХУД, 118 дугаар сургууль/ ТАХ-ний зураг төсөл, төсвийн үнэ болох 29.1 сая төгрөгийг Чулуутын багш ХХК-д гүйцэтгэлээр давхардуулан олгосон тул төлбөрийн акт тогтооё.

БХБС-ын багцад:

- Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Хайрхан, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумдын Улаанбаатар хот дахь оюутнуудын дотуур байрны БУА гүйцэтгэх захиралын гүйцэтгэгчтэй байгуулсан 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн БСШУСЯ/201902036/30 дугаартай гэрээний нийт үнэд зураг төслийн үнэ 60.0 сая төгрөг багтсан байна.

1.51 Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байхад барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, барилга угсралтын ажлын явцад дахин магадлал хийж байгаа нь он дамжин үргэлжлэх барилгын өртөг нэмэгдэх нэг шалтгаан болж байна. Тухайлбал,

2020 онд:

- Улаанбаатар хотын Багануур дүүрэгт баригдсан Албан бус насан туршийн боловсрол төвийн барилгын 101.2 сая төгрөгийн нэмэлт ажлын;
- Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын хүзүүвчний барилгын 223.1 сая төгрөгийн;
- Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд баригдсан 150 ортой цэцэрлэгийн барилгын суурийн түвшнийг буруу тооцсоныг залруулж, цэвдгийн хил рүү оруулж 3.1 м-т суулаах 533.8 сая төгрөгийн;
- Хөвсгөл аймгийн Арбулаг суманд баригдсан 240 суудалтай Соёлын төвийн барилгын төсөвт арматурын үнийг дутуу, барилгын талбайн хэмжээг дутуу тооцсоноос 595.0 сая төгрөгийн;
- Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Орон нутаг судлах музейн барилгын гадна цахилгаан, цэвэр бохир усан хангамжийн ажлын 414.4 сая төгрөгийн;

2021 онд:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 14 дүгээр багт баригдсан 480 суудалтай сургуулийн барилгын байршил өөрчлөгдсөнөөс суурийн ажлын хийц бүтээц болон гадна инженерийн шугам сүлжээний ажлын өөрчлөлтийн 1,278.9 сая төгрөгийн;
- Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын суурийн бүтээц, цэвэр бохир усны шугамын өөрчлөлтийн 523.3 сая төгрөгийн;
- Хэнтий аймгийн Хэрлэн сумын Орон нутаг судлах музейн барилгын ажлын тоо хэмжээг төсөвт дутуу тооцсон 201.4 сая төгрөгийн, нийт 3,871.1 сая төгрөгийн нэмэлт ажилд тус тус дахин магадлал хийсэн.

1.52 Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4¹⁰, 39.5¹¹-д заасны барилгын зураг төсөлд магадлал хийсэн эрх бүхий этгээдэд “**мэргэжлийн хариуцлага**” хүлээхээр байгаа ч өртөг нэмэгдэх болсон шалтгаан нөхцөл, байдалд үнэлгээ хийгээгүй, хариуцлага тооцоогүй байна.

1.53 Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “*Барилгын материалын үнэ болон ханшийн өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ*” гэж заасныг зөрчиж, зарим барилга байгууламжийн төсөвт өртгийг 7.0-67.0 хувиар нэмэгдүүлж магадлал хийсэн байна. Тухайлбал,

- *Аврах гал унтраах 10 дугаар ангийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үнийн өсөлт болох 2,159.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1016/2021 дугаартай;*
- *Хөвсгөл аймгийн Түнэл сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах “Засаг даргын Тамгын газрын барилга”-ын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 494.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1109/2021 дугаартай;*
- *Байгалийн түүхийн музейн цогцолбор барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/-ын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 37,032.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1115/2021 дугаартай;*
- *Сүхбаатар аймгийн Асаат сумын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээ болон 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдах зуухны барилгын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 735.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1704/2021 дугаартай;*
- *Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 2 дугаар хороонд баригдаж буй Нийслэлийн Мал эмнэлгийн газрын оффис, лабораторийн барилгын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 273.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1841/2021 дугаартай;*
- *Баян-Өлгий аймгийн Толбо сумын 300 хүний суудалтай Соёлын төвийн барилгын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 1,080.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1870/2021 дугаартай;*
- *Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Жишиг өрхийн эмнэлгийн барилгын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 358.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1820/2021 дугаартай;*
- *Хөвсгөл аймгийн Тариалан сумын 960 сурагчтай сургуулийн барилгын төсөвт өртгийг үнийн өсөлт болох 2,921.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тус тус магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.*

1.54 Аудитаар улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжийн зураг, төслийн өөрчлөлт, өртгийн нэмэгдэл, үнийн өсөлтөд ажил гүйцэтгэгч байгууллагын санаачилгаар магадлал хийхгүй байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг Барилгын хөгжлийн төвд хүргүүллээ.

1.55 Мөн барилгын норм ба дүрмийн дагуу өртгийг тооцох боломжгүй урлагийн бүтээл, хөшөө, дурсгалын зүйлс, барилгад суурилагдахгүй нэмэлт тоног, төхөөрөмжийг барилга байгууламжийн төсөвт өртөгт оруулан тооцож, магадлал хийсэн байна. Тухайлбал,

Урлагийн бүтээл:

- *Түүх шашны соёлыг дэлгэрүүлэх төв “Богд Зонхова” цогцолборын 1338/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 13,714.2 сая төгрөгийн урлагийн бүтээл;*
- *Орон нутаг судлах музейн барилгын 693/2019 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 187.9 сая төгрөгийн шилэн хорго, хөшөө, музейн үзмэр;*
- *Монголын нууц товчоо аялал жуулчлалын цогцолборын 2232/2020 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 429.7 сая төгрөгийн урлагийн бүтээл;*
- *Их хуралдай орд өргөөний барилгын 1580/2019 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 2,398.5 сая төгрөгийн интерьер, уран сийлбэрийн ажил;*
- *Чингис хаан музейн барилгын 2233/2020 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 3,397.2 сая төгрөгийн гадна чимэглэл, урлагийн бүтээл;*

Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:

- *Нийт 50 барилга байгууламжийн зураг, төсөвт 4,969.0 сая төгрөгийн барилгад суурилагдахгүй тоног төхөөрөмжийг оруулан магадлал хийсэн байна.*

1.56 Энэ нь Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, 2020 оны 30 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж буй “барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 14 дэх тусгай төрлийн

¹⁰ Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

¹¹ Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ.

зардалд хөрөнгө хуваарилах хэсгийн 14.1¹², 14.2¹³, 14.3¹⁴-т заасантай холбоотой бөгөөд үнэ өртгийг нь тооцох норм, стандартгүй зардлыг төсөвт нэмж тусгаж байгаа нь өртөг өндөр байх нэг шалтгаан болж, хөрөнгийн зардалд зураг, баримал, ваар, гоёлын ахуйн хэрэгсэл, тавилга, шалны болон ширээний гэрэлтүүлэгч, цаг, хивс, хөшиг зэрэг бүртгэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

1.57 Барилгын норм, дүрэм, стандартад нийцсэн зургийг дараа онуудад хэрэгжих төсөл, арга хэмжээнд давтан ашиглах нь зураг төсөв зохиох зардлыг зохих хэмжээгээр бууруулах боломжийг бий болгосон байна. Тухайлбал,

Өвөрхангай аймагт 2022 онд баригдах дараах барилга, байгууламжийг өмнөх зураг, төсвөөр хийхээр төлөвлөсөн:

- Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн номын сан, урлаг заалны өргөтгөлийн барилгын баталгаажсан зураг, төсвөөр Уянга сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөл;
- Арвайхээр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөлийн зургаар тус сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийг барилгыг тус тус барихаар төлөвлөсөн байна.

Зураг төсөл, төсвийг нэгдсэн байдлаар боловсруулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна

1.58 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах арга хэмжээний хүрээнд зураг, төсөвт магадлал хийсэн боловч хуульд өөр өртгөөр тусгасан, зураг, төсөвт магадлал хийгээгүй байхад 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь өртгийн зөрүү үүсгэж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

Барилга байгууламжийн төсөвт өртөг магадлалаар баталгаажсан өртгөөс бага өртгөөр 2022 оны хуульд тусгагдсан:

- Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг баригдаж байгаа Цэнгэлдэх хүрээлэнгийн барилга, байгууламжийн өртгөтгөл, шинэчлэлийн ажлын төсөвт өртгийг 15.6 тэрбум төгрөгөөр магадлалаар баталгаажсан байхад 3.8 тэрбум төгрөгөөр;
- Төв аймгийн Зуунмод суманд Монголын үндэсний археологи, угсаатны зүйн музей барих ажлын төсөвт өртөг 22.5 тэрбум төгрөгөөр баталгаажсан байхад 18.0 тэрбум төгрөгөөр;
- Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт магадлал хийгдээгүй байхад 16.0 тэрбум төгрөгөөр хуульд батлагдаж, тендер зарлан гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан;

Барилга байгууламжийн төсөвт өртөг магадлалаар баталгаажсан өртгөөс өндөр өртгөөр 2022 оны хуульд тусгагдсан:

- Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах Лабораторийн барилгын зураг төсөв магадлалаар 2.7 тэрбум төгрөгөөр баталгаажсан байхад 2022 онд төсөвт 3.0 тэрбум төгрөгөөр батлагдаж, тендер зарлаж гүйцэтгэгч 2.9 тэрбум төгрөгөөр шалгарсан.

Барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийгдээгүй байхад 2022 оны хуульд тусгаж гүйцэтгэчийг шалгаруулсан:

- Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт барих Олон улсын Хүүхдийн найрамдал зуслангийн их засвар, шинэчлэлийн ажлын зураг төсөвт магадлал хийгдээгүй байхад 2022 онд төсөвт өртөг нь 8.3 тэрбум төгрөгөөр батлагдаж, тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан;
- Улаанбаатар хотын Баянгол дүүрэг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын их засварын ажлын зураг төсөвт магадлал хийгээгүй байхад 2022 онд төсөвт өртөг нь 12.1 тэрбум төгрөгөөр хуульд батлагдаж, Баац1 ажлын 1.1 сая төгрөгийн тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан байна.

1.59 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг дутуу баталж, дараа онд нөхөж зураг төсвийн зардлыг төсөвт тусгаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” зарчмыг алдагдуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

¹² Архитектур-уран сайхны шийдэл бүхий бүтээлийг гүйцэтгүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг төсөлд тусгагдсан ажлаар тусад нь боловсруулсан бүтээц, ажлын төрлөөрх төсвийн тооцоог үндэслэн барилгын өртгийн нэгдсэн төсвийн тооцоонд “Бусад нэмэлт ажил болон зардал” бүлэгт тусгана.

¹³ Мэргэжлийн байгууллага гүйцэтгэх уран сайхны бүтээлд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцож нэгдсэн төсвийн тооцооны “Бусад нэмэлт ажил болон зардал” бүлэгт тусгана.

¹⁴ Суурилуулсан уран сайхны бүтээл болон өрөөний дотор талын тохижилтын хэрэгсэл болох гоёлын-хавсарга урлагийн эдлэхүүн (зураг, баримал, ваар, гоёлын ахуйн хэрэгсэл гэх мэт), түүнчлэн барилга байгууламжийн дотор сул чөлөөтэй байрлуулдаг бусад хэрэгслүүд (тавилга, шалны болон ширээний гэрэлтүүлэгч, цаг, хивс, хөшиг гэх зэрэг)-ийн өртгийг нэгдсэн төсвийн тооцооны 9-р бүлгийн “бусад нэмэлт ажил болон зардал”-д тусгана.

1.60 Богино хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа зарим төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажил удаашралтай байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна. Үүнд:

Хүснэгт 14. Зураг төслийг хугацаа алдалгүй боловсруулах шаардлагатай төслүүд (нэр, тэрбум төгрөг)

№	Байршил	Төсөл, арга хэмжээний нэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих өртөг
1	УБ, БЗД	Вакцины хяналтын лабораторийн барилга	3,500.0
2	УБ, БГД	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга	7,900.0
3	УБ, БГД	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга	17,300.0
4	УБ, БЗД	Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилга	3,500.0

Эх сурвалж: УАГ

1.61 Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, байгууламжийн зураг төсөл, төсөвт магадлал хийх тогтолцоог сайжруулж, оролцогч талуудын хүлээх хариуцлагыг тодорхой болгон, улсын төсвөөс санхүүжүүлж боловсруулсан барилга, байгууламжийн зураг төслийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, ТЕЗ-дын төсвийн төлөвлөлтөд ашиглах боломжоор хангах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАНАР БАЙДЛЫГ ДОРОЙТУУЛЖ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ, ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

2.1 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиар 24 ТЕЗ-ийн төсвийн багцад үргэлжлэн хэрэгжих 643, шинээр хэрэгжих 458, нийт 3,881.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1101 төсөл, арга хэмжээг 1,418.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

2.2 Тайлант онд шинээр хэрэгжих 420.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 109.4 тэрбум төгрөгөөр санхүүжих 134 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг ТХААГ-т, 254.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89.3 тэрбум төгрөгөөр санхүүжих 214 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын шийдвэрээр орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон байна.

2.3 ТЕЗ-аас эрх шилжүүлсэн ихэнх тушаал боломжит хугацаагаар гарсан ч tender.gov.mn системийн цахим эрхийг шилжүүлэх асуудал удааширдаг, энэ нь тухайн системд ил харагддаггүй учраас хариуцлага тооцох боломжгүй байна.


2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 74.0 хувьд нь нээлттэй тендер шалгаруулалт, 18.2 хувьд нь тендер шалгаруулалтын онцгой журам, 4.6 хувьд нь зөвлөх үйлчилгээний аргыг ашигласан байна.

2.5 Амжилтгүй болсон тендерийг дахин зарлахдаа тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулахгүйгээр шууд онцгой журам хэрэглэж, хязгаарлагдмал тендер зарлаж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4.1¹⁵, 30.4.2¹⁶-т гэж заасныг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ажлын туршлага болон чадахаар илт давуу, 1,228.0 сая төгрөгийн үнэ санал ирүүлсэн Гурван тахилгат оргил ХХК-ийн тендерээс “техникүүдийн үзлэгт орох хугацаа 1-3 сараар хэтэрсэн” гэх шалтгаанаар татгалзаж, тендерийг хүчингүй болгон 1,300.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулахыг захиалагчид зөвлөсөн;
- Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өвөрхангай/ тендерийг 2 удаа зарласан ба 4 дүгээр багцад хамгийн бага үнэ санал болгосон Далай гүүр ХХК-ийн тендерээс эхний удаад “техникийн тодорхойлолтод брэнд заагаагүй, түргэн хөрвөх чадварын шаардлага хангаагүй” шалтгаанаар, дараагийн удаад “ижил төстэй ажлын шаардлага хангаагүй” шалтгаанаар тус тус татгалзсан боловч тус компани нь 2 удаагийн тендерт тендерийн баримт бичигт тавьсан “Samsung, LG болон түүнтэй дүйцэхүйц” шаардлагыг хангасан Samsung брэндийн хоёр төрлийн ус шүүгчийн техникийн тодорхойлолтыг хавсаргаж, түргэн хөрвөх хөрөнгөө нотолж дансны хуульгаа ирүүлсэн, ижил төстэй ажлын шаардлага хангаснаа баримтаар нотолсон байна. Уг тендерт илүү үнэ санал болгосон Содон сүлжээ ХХК-ийг шалгаруулж, сургуулиудад Hyundai брэндийн төхөөрөмжийг 1.4 сая төгрөгөөр илүү үнээр нийлүүлсэн.

2.6 Худалдан авах ажиллагаа зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан хугацааг сараар авч үзвэл, 2021 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 63.9 хувийн гүйцэтгэгчийг 5-7 дугаар сард шалгаруулсан байна.

График 3. ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа (хувь, сараар)



Эх сурвалж: УАГ

¹⁵ тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах

¹⁶ ...тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цэр хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах

2.7 ТЭЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж, их засварын 345 төсөл, арга хэмжээний 325-д буюу 94.2 хувьд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойш буюу барилгын улирал эхэлснээс хойш зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “*барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх*” гэж заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

2.8 Төсөв захирагчид ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.4¹⁷, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7¹⁸-д заасны дагуу тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлж байгаа ч цахим системд хугацаанд нь оруулах байдал хангалтгүй, зарим үр дүнг цахим системээр тайлагнаагүй байна.

2.9 Худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авалтын төлөвлөгөө, үр дүнг бодитой мэдээлэх, худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулж олон нийтийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангах байдлыг сайжруулах шаардлагатай байна.

2.10 Худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацааг баримтлан зохион байгуулаагүй тохиолдол цөөнгүй гарч байна. Тухайлбал,

Төлөвлөсөн хугацааг баримтлан зохион байгуулаагүй:

- Хөвсгөл аймагт үнэлгээний хороо байгуулахдаа дунджаар 24 хоног, гэрээ байгуулахад дунджаар 23 хоногийн хугацаа алдсан;
- Говь-Алтай аймагт цар тахлаас шалтгаалан 12 ТАХ-ний ХАА-г төлөвлөсөн хугацаанд зохион байгуулаагүй;
- Орхон аймагт зураг, төсөвт магадлал хийгдээгүй ТАХ-г эрх шилжүүлснээс 3 ТАХ-ний ХАА-г 2-3 удаа зохион байгуулж, төлөвлөсөн хугацаа 36-189 хоногоор хоцорсон;

Алдаатай тайлагнасан:

- Хөвсгөл аймагт Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Улаан-Уул сум, Мунгараг баг Байцын ар/ ТАХ-ний гүйцэтгэгчээр шалгарсан БИММ ХХК гэрээ байгуулахаас татгалзсан байхад гэрээ байгуулснаар тайлагнасан;

2.11 Тендер шалгаруулалттай холбоотой 2021 онд гарсан гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо буурсан хэдий ч тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гаргасан гомдол 9.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Тендерийн гомдлын судалгаа (тоо, хувь)

Ангилал	2020 он		2021 он	
	Гомдлын тоо	Эзлэх хувь	Гомдлын тоо	Эзлэх хувь
ШӨХТГ	154	12.1	262	21.7
Сангийн яам	1009	79.4	870	72.1
Захиргааны хэргийн шүүх	108	8.5	75	6.2
ДҮН	1271	100.0	1207	100.0

Эх сурвалж: УАГ

2.12 Захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр Сангийн яаманд гаргасан гомдлын тоо 7.3 хувиар буурсан бөгөөд 491 аж ахуйн нэгжээс 782 тендер шалгаруулалттай холбоотой гомдол ирүүлснээс 63.0 хувийг үндэслэлтэй гэж үзсэн нь үнэлгээний хорооны гишүүд үнэлгээ хийхдээ хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, түүнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зөрчигдсөөр байна

2.13 Зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэх ажлыг хууль, журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй, тендерийн саналыг үнэлэх, эрх олгох үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүйгээс дахин тендер зарлаж хугацаа алдах, өрсөлдөөнийг хязгаарлах байдал ажиглагдаж байна. Тухайлбал,

¹⁷ Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр мэдээлнэ.

¹⁸ Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендер оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019.06.04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ын дагуу ил болгох

Тендерийн баримт бичигт “Захиалагч тендерийг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно” гэж заасныг зөрчиж:

- Боловсролын салбарын их засварын ажлын тендерийн 9 дүгээр багцад /Өвөрхангай/ оролцсон Өндөр бөх ХХК-ийн ирүүлсэн тендерээс “ажлын тоо хэмжээ зөрүүтэй” гэх шалтгаанаар татгалзсан боловч цахим хуудсандаа нийтэлсэн ажлын тоо хэмжээ нь ойлгомжгүй, 2 дахь удаагийн шалгаруулалтаар ямар ч шалтгаан дурдахгүйгээр уг багцын тендерийг хүчингүй болгосон;

Тендерийн баримт бичгийг алдаатай бэлтгэсэн:

- Жаргалант багийн 120 суудалтай сургуулийн барилгын өргөтгөл, Сумын төвийн тохижилтын ажлын тендерийн 1 дүгээр багцад бусад багц, Эрүүл мэндийн салбарын их засвар /Өвөрхангай/-ын ажлын тендерийн 6 дугаар багцын засварын ажлын тендерт тус тус барилга барих төсөв хавсаргасан;
- Боловсролын салбарын их засвар-ын ажлын тендерийн 9 дүгээр багц /Сумдын сургууль, цэцэрлэгийн дээврийн засвар/-д материалын тоо хэмжээг үнийн дүнгүй нийтэлж зарласан;

Тендерийн баримт бичигт нэг шаардлагыг өөр өөр агуулгаар давхардуулан тусгасан:

- Хуулийн XIII.1.1.248 дугаартай Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/ ТАХ-ний тендерийн баримт бичгийн ТӨӨЗ 5.2-т “ижил төстэй ажлын мэдээлэл 3 жилээр” гэж заасан бол ТӨӨЗ 5.3-т “2 жилээр” шаардсан;

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзэх нөхцөлийн 14.1.3-т “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг” гэж заасныг зөрчиж:

- Дотуур байрны засвар /Өвөрхангай аймаг, Бүрд сум/ 67.0 сая төгрөгийн төсөвтэй төслийн гүйцэтгэгчээр үндсэн ажилтангүй, нэг ч хүний нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, түргэн хөрвөх хөрөнгийн эх үүсвэргүй, сүүлийн жилд ажил эрхлээгүй тул борлуулалтын орлогогүй Голден эко арт ХХК компанийг шалгаруулжээ.
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/ 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн гүйцэтгэгчээр шалгарсан Энх баялаг ХХК нь тендерт санал ирүүлсэн өдрийн байдлаар холбогдох тусгай зөвшөөрөлгүй байсан.

Магадлалаар баталгаажуулах төсөвт өртөгөөр зарим худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна

2.14 Өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах нөхцөлөөр зарлаж, гэрээ байгуулсан 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2021 онд 12,499.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 16. Түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулж, өртөг нэмэгдсэн төслүүд (сая төгрөг)

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Нэмэгдсэн өртөг
			Эхлэх	Дуусах	
1	XIII.1.1.187	Цэцэрлэгийн барилга буулгаж, барих, 150 ор /УБ, БЗД, 12 дугаар хороо, 20 дугаар цэцэрлэг/	2019	2022	577.0
2	XIII.1.1.159	Цэцэрлэгийн барилга, 240 ор /УБ, БЗД, 8 дугаар хороо, Харуул-Алтай хотхон/	2019	2022	362.3
3	XIII.1.1.72	Сургуулийн барилга, 960 суудал /УБ, СБД, 13 дугаар хороо/	2019	2021	1,430.1
4	XIII.1.1.94	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /УБ, СБД, 71 дүгээр сургууль/	2018	2021	850.0
5	XIII.1.1.5	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /УБ, ЧД, 19 дүгээр хороо/	2019	2021	985.4
6	XIII.1.1.12	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, ЧД, 12 дугаар хороо/	2018	2021	1,506.4
7	XIII.1.1.25	Олон улсын стандартын сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2019	2022	932.5
8	XIII.1.1.42	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/	2019	2022	756.7
9	XIII.1.1.30	Сургуулийн барилга, 1200 суудал /УБ, ХУД, Буянт-Ухаа 2 цогцолбор/	2019	2022	2,496.9
10	XIII.1.1.28	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /УБ, БГД, 19 дүгээр сургууль/	2018	2022	1,829.9
11	XIII.1.1.49	Сургуулийн барилга, 320 суудал /УБ, СХД, 31 дүгээр хороо/	2018	2021	772.3
Дүн					12,499.5

Эх сурвалж: УАГ

2.15 Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд баталснаас дутуу төсвөөр болон зураг төсөлгүйгээр худалдан авах ажиллагааг зарлаж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

БШУС-ын багцад:

- Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэх 9, үргэлжлэн хэрэгжиж буй 1, нийт 23,668.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг хувааж тендер зарласнаас МЭД-ээр баталгаажсан төсөвт өртөгийн зөрүүгээр 9,660.8 сая төгрөгийн нэмэлт төсөв шаардагдаж байна.
- Хуулийн XIII.1.1.63 дугаартай Сургуулийн барилга, 640 суудал /УБ, БЗД, 26 дугаар хороо, олон улсын сургалттай “Монгол тэмүүлэл” сургууль/ ТАХ-ний дулааны холболт хийх техникийн нөхцөлийг хамгийн ойр байрлах Шинэ зуун айл ХХК-ийн шугамаас холбох талаар Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраас тус компанигай зөвшилцөж, олгосон Эрчим төсөл ХХК-ийн ЭТ-49/2018 дугаартай гадна дулаан,

дулаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу хийхээр шийдэж, уг гадна дулааны шугамын ажлыг хийж гүйцэтгэхэд нийт 534.8 сая төгрөгийг зарцуулсан боловч Шинэ зуун айл ХХК тус сургууль, цэцэрлэгийн барилгуудыг холбуулахгүй гэсэн шалтгаанаар дулааны шугам угсралт, холболтын ажил зогссон байна. Улмаар Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгээс 021/2022 дугаартай холболтын цэгийг өөрчлөх техникийн нөхцөлийг 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр БШУЯ-д олгож, 2022 оны Нийслэлийн хөрөнгө оруулалтын төсвийн саналд 5,000.0 сая төгрөгийн зардал тусгахаар төлөвлөсөн нь нэмэлт үргүй зардал гарах нөхцөл болсон байна.

Худалдан авах ажиллагааны эрх зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулснаар хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах боломж байна

2.16 Төсвийн тухай хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөөгүйгээс үргэлжлэн хэрэгжиж буй 73 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2021 онд 115,337.8 сая төгрөгөөр буюу 37.0 хувиар нэмэгдсэн байна. Эдгээрээс 71 төсөл, арга хэмжээнээс төсөвт өртөг 15.0-аас дээш хувиар нэмэгдсэн байна. (Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт 6-аас харна уу)

2.17 Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 22 дугаар тэмдэглэлээр “...нэмэлт ажил нь магадлалаар баталгаажсан он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гэрээний үнэд тохируулга хийх асуудлыг Барилгын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ болон холдогдох бусад хууль, тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх”-ийг холбогдох ТЕЗ нарт даалгасан байна.

2.18 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6-1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасан боловч 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнгээр хэмнэсэн 6,840.5 сая төгрөгөөс ТЕЗ нар 6,742.8 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан зарцуулсан байна. Тухайлбал,

- Сургуулийн дотуур байрын барилга, 40 ор /Төв, Архуст сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 80.2 сая төгрөгөөр Хабул констракшн ХХК-тай;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /УБ, СХД, 11 дүгээр хороо/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 303.1 сая төгрөгөөр Дэрэн наран ХХК-тай;
- Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 171.7 сая төгрөгөөс Таванхан уул ХХК-тай;
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /УБ, БГД, 21 дүгээр хороо/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 500.7 сая төгрөгөөр Цац-Орхон ХХК, Монгол дээвэр ХХК-ийн түншлэлттэй;
- Цэцэрлэгийн барилга /УБ, ЧД, 12 дугаар хороо/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 197.3 сая төгрөгөөр Хөх-үзүүр ХХК-тай;
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 21.5 сая төгрөгөөр Баян-Өндөр булаг ХХК-тай;
- Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 711.7 сая төгрөгөөр Шинэ-Өлгийн зам ХХК-тай;
- Сургуулийн барилга, 240 суудал /Ховд, Ховд сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 229.4 сая төгрөгөөр Ховдбаганат ХХК-тай;
- Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 170.7 сая төгрөгөөр Хөхбүрдний эх ХХК-тай;
- Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Идэр сум/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 230.7 сая төгрөгөөр Ханжаргалант стоунс ХХК-тай;
- Албан бус насан туршийн боловсрол төвийн барилга /УБ, Багануур дүүрэг/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 101.2 сая төгрөгөөр Монмарс холдинг ХХК-тай;
- Сургуулийн барилга, 640 суудал /УБ, БЗД, 26 дугаар хороо, Олон Улсын сургалттай “Монгол тэмүүлэл” сургууль/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 2,022.4 сая төгрөгөөр Батс-Өргөө ХХК-тай тус тус нэмэлт гэрээ байгуулсан;
- Цэцэрлэгийн барилга, 320 ор /УБ, БЗД, 26 дугаар хороо/ ТАХ-ний тендерийн хэмнэлт болох 2,100.0 сая төгрөгөөс ГЦЦЭ ХХК-тай 2,002.1 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулсан байна.

2.19 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ыг 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчилсэн болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журамд өмнөх журмын 4.22-т “Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй” гэж заасныг тусгаагүйгээс ТЕЗ нар тендерийн хэмнэлтийг зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна.

2.20 Зураг, төсөв нь магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тойм төсвөөр зарлаж гэрээ байгуулсан, барилга, байгууламжийн зураг төслийг иж бүрэн боловсруулаагүй, зураг, төсөвт дахин магадлал хийсэн зэрэг шалтгаанаар төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 15-аас дээш хувиар нэмэгдэж, нэмэгдсэн өртгөөр нэмэлт гэрээг

Засгийн газрын хуралдааны дээрх тэмдэглэлд үндэслэн шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.4¹⁹-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, буулгаж, барих, 150 ор /УБ, БЗД, 12 дугаар хороо, 20 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний тендерийг 2019 оны 7 сард 1,558.5.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр зарлаж 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Чинбат ХХК-тай 1,404.3 сая төгрөгөөр гэрээ байгуулжээ. Төсөвт өртгийг 2019 оны 2215/2019 дугаартай МЭД-ээр 2,135.6 сая төгрөгөөр баталгаажуулсныг үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гэрээг 154.2 сая төгрөгөөр, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр нэмэлт санхүүжилтийн гэрээг 577.0 сая төгрөгөөр тус тус байгуулсан боловч тендерийн хэмнэлт 154.1 сая төгрөгийг хасаж тооцоогүй;
- Цэцэрлэгийн барилга буулгаж, барих, 360 ор /УБ, ЧД, 39 дүгээр цэцэрлэг/ ТАХ-ний тендерийг 2019 оны 10 сард 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр зарлаж, БУА гүйцэтгэх гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Баярс констракшн ХХК-тай 1,598.9 сая төгрөгөөр байгуулсан. Төсөвт өртгийг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2009/2020 дугаартай МЭД-ээр 3,896.6 сая төгрөгөөр баталгаажуулсныг үндэслэн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр ТӨБЗГ-209/ХII.1.1.293+2 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 3,896.6 сая төгрөгийн дүнтэй байгуулсан боловч тендерийн хэмнэлт 401.1 сая төгрөгийг хасаж тооцоогүй;
- Сургуулийн барилга, 480 суудал /Хөвсгөл, Мөрөн сум, 14 дүгээр баг/ ТАХ-ний 2019.07.26-ны өдөр 1148/2019 дугаартай МЭД-ээр төсөвт өртөг 5,278.9 сая төгрөгөөр баталгаажсан. БУА гүйцэтгэх ТӨБЗГ-/2019/ХIII.1.1.228 дугаартай анхны гэрээг 2019.10.11-ний өдөр Их эрин констракшн ХХК-тай 3,999.8 сая төгрөгийн дүнтэй байгуулсан боловч 2021.04.19-ний өдрийн ХО2021/50 дугаартай хурлын тэмдэглэлийг үндэслэн 2021.06.14-ний өдөр ТӨБЗГ-/2019/ХIII.1.1.288 дугаартай 1,278.9 сая төгрөгийн дүнтэй нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахдаа компанийн тендерт ирүүлсэн төсөвт иж бүрэн тусгагдсан ажлын /гадна дулаан холигчийн узель, дулаан механик, гадна цахилгаан хүчит төхөөрөмж, гадна холбоо, зуухны барилга, дэд өртөөний барилга/ дүн болох 562.4 сая төгрөгийг хасаж тооцоогүй байна. Гэвч гүйцэтгэгч батлагдсан зураг төсөл, төсөвт суугаагүй зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт газар шороо, суурь, гадна тохижилтын /хашаа/, спорт заалны шалны чанар байдлыг сайжруулсан /паркетан шалыг агч мод болгон өөрчилсөн/ 435.8 сая төгрөгийн ажил хийснийг холбогдох байгууллага болон хариуцсан албан тушаалтнууд баталгаажуулан ирүүлснийг үндэслэн хасаж, үлдэх 126.6 сая төгрөгийн дүнд төлбөрийн акт тогтоов.
- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /УБ, БЗД, 50 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний тендерийг 2018 оны 6 дугаар сард 2,160.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлаж, БУА гүйцэтгэх гэрээг 2018.07.10-ны өдөр Билэгт багана ХХК-тай 1,819.7 сая төгрөгөөр байгуулжээ. 2019.06.21-ний өдрийн 887/2019 дугаартай баталгаажсан МЭД-ийг үндэслэн зайлшгүй хийгдэх барилгын зоорийн нэмэлт ажил гарсангай холбогдуулан 2019.06.25-ны өдөр БСШУСЯ/201801165+1 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 272.9 сая төгрөгийн дүнтэй байгуулж ажлыг хийж гүйцэтгэсэн боловч 2020.01.29-ний өдрийн 093/2020 дугаартай 3,519.6 сая төгрөгийн дүнтэй баталгаажсан МЭД-ийн дүнд дээрх зоорийн нэмэлт ажлын дүн 332.2 сая төгрөгийг давхардуулан тооцож, МЭД-ийг үндэслэн 2021.07.20-ны өдөр байгуулсан БСШУСЯ/201801165+2 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээний 3,452.0 сая төгрөгийн дүнгээс үе дүнг хасаж тооцоогүй байна. Гэвч гүйцэтгэгчийн зураг төсөл, төсөвт тусгаагүй зайлшгүй хийх шаардлагатай 2018.09.28-ны өдрийн 1323/2018 дугаартай 153.0 сая төгрөгөөр баталгаажсан МЭД-ийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын /Баянзүрх үүргийн 3 дугаар хороонд байрлах 50 дугаар цэцэрлэгийн барилгын буулгалтын ажил/ дүнг хасаж, үлдэх 52.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх акт тогтоов.
- Сургуулийн барилга, 640 суудал /УБ, БЗД, 26 дугаар хороо, олон улсын сургалттай “Монгол тэмүүлэл” сургууль/ ТАХ-ний тендерийг 2020 оны 3 сард 7,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлаж, БУА гүйцэтгэх гэрээг 2020.03.27-ны өдөр Батс-Өргөө ХХК-тай 4,977.6 сая төгрөгөөр байгуулжээ. Гэвч 2021.07.05-ны өдөр БУА-ын тоо хэмжээний зөрүү, сургуулийн барилгын /920 хүүхэд/ гадна тохижилт, сургуулийн барилгын /640 хүүхэд/ гадна тохижилт, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна дулаан, дулааны узелийн нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэхээр БСШУСЯ/202001246+2 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 3,500.0 сая төгрөгийн дүнтэй байгуулсан боловч анхны гэрээний 640 хүүхдийн сургуулийн гадна тохижилтын ажлын 278.5 сая төгрөгийг тус гэрээний дүнгээс хасаж тооцоогүй тул акт тогтоов.

2.21 Энэ нь ТБОНӨХБАУХАТХ-аар сонгон шалгаруулалт явуулж, шударгаар өрсөлдөж, хамгийн бага харьцуулах үнийг санал болгосон оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн гэх нотолгоог үгүй болгож, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй байна.

2.22 Харин 2022 онд баталсан Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заасныг 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр байна.

¹⁹ нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэж болно.

2.23 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 33,955.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 барилга, байгууламжийг худалдан авахаар төлөвлөж, тайлант онд 14,880.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 13,082.0 сая төгрөгийг олгож, 856.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.24 Худалдан авахаар төлөвлөсөн нийт барилга, байгууламжийн 66.7 хувь нь сургууль, цэцэрлэгийн барилга бөгөөд тэдгээр барилгууд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 179 дүгээр тушаалаар баталсан “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-д заасан ерөнхий шаардлагууд, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-03, 2021 онд шинэчлэн санал авч буй Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-21-д заасан сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын барилгын эдэлбэр газрын хэмжээ, агааржуулалт ба гэрэлтүүлгийн норм, нормативын шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал,

- Сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/;
- Цэцэрлэгийн барилга худалдан авах /Ховд, Жаргалант сум, Жаргалан баг/;
- Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/;
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Дорноговь, Замын-Үүд сум/- уг барилга 2015 онд ашиглалтад орсон бөгөөд орон сууцны зориулалттай барилгыг хуучин 2014 оноос хойш ашиглаж байсан тоног, төхөөрөмжийн хамт худалдан авсан акт үйлдсэн.
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/.

Урсгал зардлаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байна

2.25 Аудитын явцад хийсэн судалгаагаар 2019-2021 онд төсвийн урсгал зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй нийт 34.5 тэрбум төгрөгийн 171 тендер зарлаж, 13.6 тэрбум төгрөгийн 130 гэрээг шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Үүнд:

- 2019 онд нийт 9,817.6 сая төгрөгийн 75 тендер зарлаж, аж ахуйн нэгжтэй 8.4 тэрбум төгрөгийн 68 гэрээ байгуулсан;
- 2020 онд нийт 13.3 тэрбум төгрөгийн 64 тендер зарлаж, аж ахуйн нэгжтэй 3.6 тэрбум төгрөгийн 51 гэрээ байгуулсан;
- 2021 онд нийт 11.4 тэрбум төгрөгийн 32 тендер зарлаж аж ахуйн нэгжтэй 1.6 тэрбум төгрөгийн 11 гэрээ тус тус байгуулсан байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 65.8 хувийг бодит гүйцэтгэлд олгосон байна

2.26 Аудитаар улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн бодит гүйцэтгэл 65.8 хувьтай дүгнэгдсэн бөгөөд 10.8 хувь буюу 119 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 7.5 хувь буюу 83 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байна. (Дэлгэрэнгүйг хаасралт 7, 8-аас харна уу)

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар 397.2 тэрбум төгрөгийн 399 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

2.27 Аудитаар эрх шилжүүлээгүй болон зарим эрх шилжсэн төсөл, арга хэмжээ хэрэгжилттэй холбоотой нийт 228.5 тэрбум төгрөгийн 171 зөрчил илрүүлж, 39 зөрчилд 6,518.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх 24 төлбөрийн акт тогтоож, 67 зөрчлийг арилгуулахаар 83,619.9 сая төгрөгийн 21 албан шаардлага, 10.6 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага, 120.6 тэрбум төгрөгийн 59 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, 11.2 тэрбум төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлээ.

Хүснэгт 17. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр авсан арга хэмжээ (сая төгрөг)

№	ТЕЗ	Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн		Нийт	
		Зөрчил тоо	Мөнгөн дүн	Зөрчил тоо	Мөнгөн дүн	Зөрчил тоо	Мөнгөн дүн	Зөрчил тоо	Мөнгөн дүн	Зөрчил тоо	Мөнгөн дүн	Зөрчил тоо	Мөнгөн дүн
1	МҮЕС			1	2.1	2	-			1	4,090.5	3	2.1
2	МУШС			7	1,187.3	4	-					11	1,187.3
3	БШУС	9	65.5	17	1,348.1	15	27,510.7	1	9,660.8	2	921.1	44	39,506.2
4	СоС	4	15,859.6	3	1,820.4	2	-					9	17,680.0
5	ЭТХС			1	889.7							1	889.7
6	ХХААХҮС	2	2,250.0			1	4,000.0					3	6,250.0
7	БОАЖС			1	23.7							1	23.7
8	ЭМС	3	18,500.0			1	28,058.0	1	942.9	1	6,214.6	6	53,715.5
9	ХНХС	7	16,400.0			1	1.2	1	-			9	16,401.2
10	УУХҮС	4	1,495.9									4	1,495.9
11	СЗХД	4	150.1									4	150.1
12	ЭХС	18	65,819.9	1	705.3							19	66,525.2
13	ШЕЗ	3	70.5									3	70.5
14	АТГД	2	-									2	-
15	СаС			2	87.4							2	87.4
16	БХБС	3		1	12.1	11	24,050.0					15	24,062.1
17	Завхан аймгийн ЗД			3	276.6	3	-					6	276.6
18	НХОГ			2	166.2	2	-					4	166.2
19	БХТ					25	-					25	-
	Дүн	59	120,611.5	39	6,518.9	67	83,619.9	3	10,603.7	4	11,226.2	171	228,489.7

Эх сурвалж: УАГ

2.28 Орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд аудит хийж, нийт 168.7 тэрбум төгрөгийн 228 зөрчлийг илрүүлж, 11 зөрчилд 434.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 76 зөрчлийг арилгуулахаар 79.0 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч, 88.5 тэрбум төгрөгийн 139 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, 723.4 сая төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Хүснэгт 18. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд илэрсэн зөрчил (сая төгрөг)

№	АНТАГ	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх		Нийт зөрчлийн дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Архангай	-	-	1	669.2	3	9,470.1	-	-	10,139.3
2	Баян-Өлгий	1	6.4	2	186.7	5	-	-	-	193.1
3	Баянхонгор	-	-	14	1,261.7	7	6,518.5	-	-	7,780.2
4	Булган	-	-	1	-	4	-	-	-	-
5	Говь-Алтай	3	100.7	4	2,455.4	2	-	-	-	2,556.1
6	Говьсүмбэр	-	-	5	3,326.1	4	922.6	-	-	4,248.7
7	Дархан-Уул	-	-	5	338.3	6	14,950.9	-	-	15,289.2
8	Дорноговь	-	-	3	3,203.4	4	-	-	-	3,203.4
9	Дорнод	-	-	-	-	4	384.0	-	-	384.0
10	Дундговь	-	-	1	40.0	11	-	-	-	40.0
11	Завхан	1	18.9	-	-	8	2,494.0	-	-	2,512.9
12	Орхон	1	113.6	3	108.2	4	9,974.4	-	-	10,196.2
13	Өвөрхангай	-	-	6	14,818.4	8	-	-	-	14,818.4
14	Өмнөговь	-	-	4	4,305.9	3	2,137.8	-	-	6,443.7
15	Сүхбаатар	-	-	1	300.0	4	-	-	-	300.0
16	Сэлэнгэ	-	-	2	6,550.0	8	-	-	-	6,550.0
17	Төв	2	38.8	5	12,673.5	9	39,831.3	-	-	52,543.6
18	Увс	-	-	-	-	5	-	-	-	-
19	Ховд	-	-	2	1,218.5	8	-	2	723.4	1,941.9
20	Хөвсгөл	1	5.5	7	6,358.9	17	224.0	-	-	6,588.4
21	Хэнтий	2	150.4	6	-	5	1,571.9	-	-	1,722.3
22	Нийслэл	-	-	4	21,224.1	10	-	-	-	21,224.1
	Дүн	11	434.3	76	79,038.3	139	88,479.5	2	723.4	168,675.5

Эх сурвалж: Орон нутаг дахь Төрийн аудитын газар

Барилга угсралтын ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс барилгын материал сольж, чанар байдлыг доройтуулж байна

2.29 Аудитаар төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан болон баригдаж буй зарим барилгын угсралтын ажлын явц, гүйцэтгэлтэй танилцахад барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ материал сольж, чанар байдлыг доройтуулсан байдал нийтлэг байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Бугат сум/ ТАХ-ний БУА-ыг гүйцэтгэгч Балкер ХХК-тай 3,898.7 сая төгрөгийн дүнтэй байгуулжээ. Гэвч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөв дэх гадна заслын ажил 120 мм-ийн өнгө өрлөгийг 120 мм-ийн энгийн тоосгон өрлөг, шавардлага болгон өөрчилсөн бөгөөд ажлын баримтыг бодит гүйцэтгэлтэй нийцүүлэн үйлдээгүй, төсвийг залруулаагүй санхүүжилтийг бүрэн авсан тул материалын үнийн зөрүүгээр 0.5 сая төгрөгийн;
- Сургуулийн спорт заалын барилга /Ховд, Булган сум, 1 дүгээр сургууль/-ын ажлыг гүйцэтгэгч Хатан Түнгэл ХХК батлагдсан зураг төсөл, төсөв дэх спорт заалны хэсгийн дүүргэлт, гадна заслын ажил 360 мм-ийн хөнгөн блок, 150 мм-ийн хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн тоосго, шавардлага эмульсийг 360 мм-ийн тоосгон өрлөг, 150 мм-ийн хөөсөнцөр дулаалга болгон өөрчилсөн бөгөөд ажлын баримт үйлдээгүй, төсвийг тусгаагүй гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан тул материалын үнийн зөрүүгээр 3.5 сая төгрөгийн;
- Аврах гал унтраах 10 дугаар ангийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/-ын ажлын гүйцэтгэгч Голден лайт ХХК барилгын зоорийн ханыг 10 см зузаантай хөөсөнцөр хавтангаар бүрэх, зоорийн гадна хананд 1/2-ын тоосго өрөх, зоорийн бетон ханыг шохойн зуурмагаар гараар ердийн шавардах, суурийн гадаргууд ус тусгаарлагчийг битuum түрхлэгээр 2 үе хийх /суурь, зоорины хананы хөрстэй харьцах хэсэг/ шавардлагыг хийж гүйцэтгээгүй, гадна нээдүгээр давхраас дээш ханыг чулуун хавтангаар өнгөлөх 3,918 м.кв талбайд хийх ажлыг металл хавтангаар орлуулж хийсэн, гадна ханыг 15.0 см-ийн зузаан эрдэс хөвөнгөөр дулаалахаар байхад 10.0 см-ийн зузаантай эрдэс хөвөнгөөр буюу 4,623.18 м.кв талбай бүхий ханыг 5.0 см-ээр нимгэн эрдэс хөвөнгөөр дулаалсан, зоорийн давхрын 14.5 м урт, 12 м өргөн, 3.0 м өндөртэй зоорийн ажлыг хийж гүйцэтгээгүй байхад ажлыг бүрэн гүйцэтгэсэнээр тайлагнаж, санхүүжилт олгосон тул материалын үнийн зөрүүд 137.8 сая төгрөгийн;
- Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн БУА-ыг гүйцэтгэгч Хаш гоёо ХХК барилгын 764.23 м.кв гадна заслын ажлыг дулаалгатай гантиг хавтангаар өнгөлөөр ажлын зураг, төсөвт тусгаж магадлалаар баталгаажуулсан байхад металл хавтангаар, дулаалгын үндсэн материал болох эрдэс хөвөн хавтанг шүрддэг хөөсөөр, гадна дулааны шугамын ажлын лотки /дулааны сувгийн тэвш/-ийг ширхгийн материал буюу блокоор хийж гүйцэтгэсэн тул материалын үнийн зөрүүд 69.0 сая төгрөгийн;
- Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн БУА-ыг гүйцэтгэгч Их үен ХХК барилгын гадна заслын ажлыг 764.23 м.кв дулаалгатай гантиг хавтангаар өнгөлөөр ажлын зураг төсөл, төсөвт тусгаж магадлалаар баталгаажсан байхад металл хавтангаар орлуулсан, зоорийн ханыг 10 см хөөсөнцөр хавтангаар бүрэх, зоорийн гадна хананд 1/2-ын тоосго өрөх, зоорийн бетон ханыг шохойн зуурмагаар гараар ердийн аргаар шавардах, суурийн гадаргууд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх /суурь, зоорины хананы хөрстэй харьцах хэсэг/ 226.85 м.кв шавардлагын ажлыг хийж гүйцэтгээгүй тул 18.6 сая төгрөгийн;
- Грийн ресурс констракшн ХХК Хэнтий аймгийн Батноров сумын Нутгийн удирдлагын ордны барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын нүүр хэсэгт сеталл рамтай цонх хийх байсныг хувцанцар рамтай цонхоор, 1, 2 дугаар давхрын нийтийн эзэмшлийн хэсгийг чулуун хавтангаар өнгөлөх байсныг плитагаар хийсэн тул 12.1 сая төгрөгийн;
- Чинбат ХХК Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын цамхагийн барилгын ажлыг гүйцэтгэхдээ гадна шилэн фасадны ажлыг хөөсөн дулаалга, металл хавтан болгон өөрчилсний материалын үнийн зөрүүгээр 23.7 сая төгрөгийн;
- Завхан аймгийн Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын БУА-ыг гүйцэтгэгч Саран инж деевелопмент ХХК барилгын гадна заслын хөнгөн блок өрлөг, хөөсөнцөр дулаалга, тоосгон өрлөгийн ажлыг хөөсөнцөр дулаалга, шавардлага, эмульсээр, шалны чулуун хавтанг плитагаар, цоколын хэсгийн агааржуулалтын цонхыг гаргаагүй битүүлсэн, гадна ганжуулсан шилэн хаалгыг төмөр рамтай түүхий шилэн хаалгаар гүйцэтгэсэн тул материалын знийн зөрүүд 10.9 сая төгрөгийн;
- Олон улсын стандартын сургуулийн барилга, 640 суудал ТАХ-ний БУА гүйцэтгэгч Хүрэл-Ордон ХХК батлагдсан зураг төсөл, төсөв дэх дотор халаалт, цэвэр усны шугамын цутгамал сувгийн тагийг хийж гүйцэтгээгүй, нөхөн гүйцэтгэх боломжгүй тул аудитаар 3.2 сая төгрөгийн төлбөрийн актыг тус тус тогтоолоо.
- Цэцэрлэгийн барилга, 320 ор /УБ, БЗД, 26 дугаар хороо/ ТАХ-ний гүйцэтгэгч ГЦЦЭ ХХК батлагдсан зураг төсөл, төсөв дэх дээврийн ажлын мембран материалыг хар цаас болгон өөрчилсөн байна.
- Спорт цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Мандалт констракшн ХХК 73.4 м.кв металл цонхыг хуванцар вакум цонхоор, 1373.4 м.кв хананд ус тусгаарлагч 1 үе хийх, D-150 мм базальт хавтангаар дулаалах, 6.32 тн кассет төмөр угсрах, 1373.4 м.кв гипсэн хавтан өнгөлөө хийх, гадна ханыг металл хавтангаар өнгөлөх ажлуудыг өөрчилж, сэндвичэн хавтангаар өнгөлсөн.
- Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын 240 хүүхдийн сургуулийн барилга, Баянхонгор сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гадна дулааны шугамын бүтээцийн ажлыг зураг, төсөвт цутгамал бетон хийцээр гүйцэтгэхээр байхад сувгийн ханыг хүрмэн блокоор өрсөн тул зургийн дагуу дахин гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.
- Сургуулийн барилга, 1200 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/-тай барилгын гадна фасад 100 мм-ийн хөөсөн дулаалга, өнгөлгөөний тоосгоор хийх байсныг шахдаг хөөсөөр дулаалж, металл фасад хийсэн, Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/-тай барилгын гадна дулаалгыг чулуун хөвөнгөөр хийхээр төсөвт тусгасныг шахдаг хөөсөөр дулаалсан тул гүйцэтгэлийн тооцоо хийж, гүйцэтгэсэн ажлын чанар, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн;

- Орон нутаг судлах музейн БУА-г гүйцэтгэгч Монкон констракшн ХХК тус барилгын 1305.4 м.кв дотор шалны ажлыг шахмал чулуу дэвсэж хийхээр байсныг плитагаар сольж хийсэн тул материалын үнийн зөрүүд 26.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, барилгын зураг төсөл, төсөвт сан хөмрөг хадгалах өрөөнүүдийн таазыг эмульсээр будах байсныг галд тэсвэргүй дүүжин таазаар, 1 дүгээр давхрын 15, 16, 17, 18 дугаар өрөө, 2, 3 дугаар давхрын ханын заслын ажлыг шалны түвшнээс дээш 3.12 метр хүртэл галд тэсвэртэй будгаар будах байсныг зарим хэсэгт цаасан обой наасан, сан хөмрөг хадгалах зарим өрөөний хаалга цоожгүй, ариун цэврийн өрөөний суултуур хооронд тусгаарлагч ханагүй, бохир зайлуулах шугам хөлдсөн зэрэг чанарын шаардлага хангаагүй болон дутуу хийсэн ажлыг гүйцээх хугацаатай албан шаардлага өглөө.
- Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хуучин барилгыг Багшийн хөгжлийн ордон болгож өөрчлөх ТАХ-ний гүйцэтгэгч Ашид гэгээн өргөө ХХК барилгын цонхонд өнгөлсөн гантиг чулуун тавиур суулгах ёстой байтал өөр материалаар хийсэн, ажлын гүйцэтгэлд хямд өртөг багатай материал ашигласан байдал түгээмэл ажиглагдсан.

2.30 Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4²⁰, 38 дугаар зүйлийн 38.1.6²¹, 40 дүгээр зүйлийн 40.1.1²²-д заасан захиалагч, зураг төслийг зохиогч байгууллагаас барилга, байгууламжийн үе шат бүрээр хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зураг төсөлд оруулсан өөрчлөлтийг тухай бүрд нь баталгаажуулж, өртгийн тооцооллыг хийгээгүйтэй холбоотой бөгөөд Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-т "...улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.31 Түүнчлэн барилга, байгууламжийн баримт бичгийн бүрдэл дутуу, иж бүрэн архивлаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3²³, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3²⁴-т заасантай нийцэхгүй байна. Тухайлбал,

Баянхонгор аймагт:

- Сургуулийн барилга, 1200 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/, цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/ ТАХ-ний БУА-ын холбогдох баримт бичгийг архивд өгөөгүй;
- Бага сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Баян-Овоо сум/ ТАХ-ний БУА-ын гүйцэтгэлийн баримт бичгийг архивд дутуу өгсөн;

ЭМС-ын багцад:

- Тус яамны захиалгаар 2011 оноос эхлэн хэрэгжүүлж буй Геронтологийн төвийн 60 ортой барилгын Арвис интернэйшнл ХХК-ийн гүйцэтгэж, захиалагчийн баталгаажуулж, санхүүжүүлсэн ажлын 4, 5 дугаартай гүйцэтгэл тус яамны архивд байхгүй байгаа цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гаргах боломжгүй байдалд хүргэж байна.

Соёлын сайдын багцад:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ТАХ-ний баримтаар цахим архивын нэгж үүсгээгүй.

2.32 Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ төсөл, арга хэмжээний бодит бус гүйцэтгэлийг баталгаажуулж гүйцэтгэгч байгууллагад санхүүжилт олгох нөхцөл үүсгэсэн зөрчлийг жил бүр давтан гаргаж байна. Тухайлбал,

МУШС-ын багцад:

- Аврах гал унтраах 10 дугаар ангийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/-ын ажлын гүйцэтгэгч Голден лайт ХХК-тай магадлалаар баталгаажуулаагүй, хийж гүйцэтгээгүй ажилд 998.6 сая төгрөгийн;

БШУС-ын багцад:

- Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын БУА-ын гүйцэтгэлийг ажлын тоо хэмжээ бүрээр тулган шалгаж баталгаажуулаагүйгээс 1,188.2 сая төгрөгийг гүйцэтгэгчид илүү олгосон;
- Баянхонгор аймгийн Заг сумын 160 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч Энх баялаг констракшн ХХК-ийн 328.0 сая төгрөгийн хийгдээгүй ажлын гүйцэтгэлд;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг гүйцэтгэгч Эндус-Эрхэт ХХК-д дээврийн ус цуглуулах ховилыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй, салбар цэцэрлэгийн цонхыг солихдоо хуучин модон цонхны суурин дээр хийсэн зай, завсартай байхад 2021 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн ББКД-67-24/21 тоот комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон.

ЗТХС-ын багцад:

- Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60км /Төв, Мөнгөнморьт сум/-ын ажлыг Тотал инж ХХК, Рингроуд ХХК түншлэл гүйцэтгэхээр 2019 онд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгчийн ажлыг

²⁰ Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

²¹ Барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах

²² Барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих;

²³ Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох төрийн архивт шилжүүлнэ.

²⁴ Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл цаасан болон цахим хэлбэрээр байх бөгөөд уг санг ашиглан төрийн архивууд хооронд мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлсэн байна.

захиалагч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ бодит гүйцэтгэлд үндэслэж, баталгаажуулаагүйгээс замын зөөврийн далан, хөлдөлтөөс хамгаалах үе, дэд суурь, шуудуу татах, төмөр бетон дугуй хоолойн хийгээгүй ажилд 3,093.4 сая төгрөгийг илүү олгосон байна.

БХБС-ын багцад:

- Баянхонгор аймгийн Галуут сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийн гүйцэтгэгч Алегроввер констракшин ХХК 448.6 сая төгрөгийн хийгдээгүй ажлын гүйцэтгэлд;
- Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/ -ын ажлыг гүйцэтгэгч Төрөлх мөрөн ХХК-д барилгын ажил огт эхлээгүй байхад 50.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон;
- Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/ -ын ажлыг гүйцэтгэгч Төрөлх мөрөн ХХК-д барилгын ажил огт эхлээгүй байхад 50.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон;
- Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14-р баг/ ТАХ-ний гүйцэтгэгч Хөвсгөл Мон Трэвел ХХК-д чийрэгжүүлэх төхөөрөмж 5 ширхэг дутуу, жижиг гэрэл 4 ширхэг суурилагдаагүй, том гэрэл, 4 ширхэг суурилагдаагүй байхад 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн БХБЯ/202001098/1.3.12 дугаар актаар хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон;
- Хөвсгөл аймгийн Тариалан сумын Халуун усны барилгыг гүйцэтгэгч Голден прогресс ХХК-д гадна тохижилтын ажил болон комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн ажлыг хийгээгүй байхад 2021 оны 12 сарын 14-ний өдрийн ББКД-67-52/21 тоот комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон;

ЗГХЭГД багцад:

- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын барилгын ажлыг гүйцэтгэгч Тэмээн ХХК-д ажлын гүйцэтгэл 65.0 орчим хувьтай байхад 90.0 хувийн санхүүжилт олгосон;
- Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын барилгын ажлыг гүйцэтгэгч Цэцэг мандал ХХК-д гэрээнд заагдсан ажил нь бүрэн дуусаагүй байхад 1,197.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээг дахин сунгаагүй;
- Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Сургуулийн барилга, спорт заалны ажлыг гүйцэтгэгч Уул-Өвгөд ХХК-д ажил нь бүрэн дуусаагүй байхад 3,186.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон;

ХНХС-ын багцад:

- Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Ахмадын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч Тэмээн ХХК-д ажил эхлээгүй байхад 65.0 сая төгрөгийн;
- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Ахмадын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч Тэмээн ХХК-д ажил эхлээгүй байхад 70.0 сая төгрөгийн;

ЭХС-ын багцад:

- Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, Их-уул сум мандал баг сараалж баг/ ТАХ-а гүйцэтгэгч Хос Хан Хөхий ХХК-д зураг төсөвт заагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон; .

БОАЖС-ын багцад:

- Соёмбо цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил /Хөвсгөл, Мөрөн сум/-ын гаднах хашаа, 0.4 кВт ЦДАШ, гадна цэвэр усны ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.33 Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын холбогдох заалтыг зөрчиж, барилгын үе шатанд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан байна

2.34 Зарим барилга байгууламж, их засварын ажлыг магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр хийж гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.10-т “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1²⁵ -т гэж заасныг зөрчиж ТЭЗ нар захиалагчийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр ажил гүйцэтгүүлж, хүлээн авсан байна. Тухайлбал,

- Багшийн хөгжлийн ордны дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний засварын ажил гүйцэтгэх 57.5 сая төгрөгийн гэрээг Гом Илч ХХК-тай 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 01 дугаартай комиссын актаар хүлээн авсан;
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн их засварын ажил гүйцэтгэх 35.0 сая төгрөгийн гэрээг Хунт-Улз ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдөр байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн комиссын актаар хүлээн авсан;
- Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2 дугаар байрны спорт заалны засварын /УБ, СБД/ ажил гүйцэтгэх 108.2 сая төгрөгийн гэрээг 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Онон Бридж ХХК-тай байгуулж, 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаартай комиссын актаар хүлээн авсан;

²⁵ Захиалагчийн чиг үүрэгт ТАХ-ний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативийн баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг ТАХ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах

- Мал эмнэлгийн хүрээлэнгийн хөргүүрийн өрөөний засварын /УБ, ХУД/ ажил гүйцэтгэх 30.0 сая төгрөгийн гэрээг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Эм Ар Жи Прожектс ХХК-тай байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн БШУЯ/2021021498 дугаартай комиссын актаар хүлээн авсан;
- Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн байрны засварын /УБ, ХУД/ ажил гүйцэтгэх 43.9 сая төгрөгийн гэрээг 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Өнөших Трейд ХХК-тай байгуулж, 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 1/89 дугаартай комиссын актаар хүлээн авсан;
- АШУИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны Био-Анагаахын хүрээлэнгийн засварын /УБ, СБД/ ажил гүйцэтгэх 116.8 сая төгрөгийн гэрээг 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Роуд Дэвелопмент ХХК-тай байгуулж, 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 1/89 дугаартай комиссын актаар хүлээн авсан;
- Бага сургууль, дотуур байрны барилгын өргөтгөлийн их засварын /Хөвсгөл, Цэцэрлэг сум, Могойн гол баг/ ажлын 163.0 сая төгрөгийн гэрээг 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Төмөр Хос Бэрс ХХК-тай байгуулж, барилгын өргөтгөл буюу модон бүтээцтэй байшин барьсан.
- Бага сургуулийн барилгын өргөтгөлийн их засвар /Хөвсгөл, Ар булаг, Сүмбэр баг/ ажлын 172.4 сая төгрөгийн гэрээг 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Этернал констракшн ХХК-тай байгуулж, барилгын өргөтгөл буюу модон бүтээцтэй байшин барьсан.
- Цэцэрлэгийн барилга их засварын /Ховд, Булган/ ажил гүйцэтгэх 447.8 сая төгрөгийн гэрээг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Харганы Ус ХХК-тай байгуулсан.

2.35 Аудитаар гүйцэтгэгч байгууллагын хариуцлага сул, ажиллаж буй боловсон хүчний мэдлэг, чадвар дутмаг байдлаас шалтгаалан барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНБД 52-02-05, ачаалал ба үйлчлэл БНБД 20-04-17, бетон ба төмөр бетон бүтээц ерөнхий журам БНБД 52-01-10-д заасан норм ба дүрмийг зөрчсөн нь барилгын насжилт, эдэлгээнд сөргөөр нөлөөлөхөөр байна. Тухайлбал,

Барилгын хөгжлийн төв техникийн хяналт хэрэгжүүлсэн:

- Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж буй Геронтологийн 60 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Арвис интернэйшнл ХХК барилгын суурь, зоорийн давхрын ус тусгаарлалт, ханын дулаалга хийхдээ зоорийн давхрын хананд булаас дүүргэлт хийн нягтруулж, бетон хаяавч хийгээгүйгээс ус нэвчиж, барилгын суурь хэв гажилтад орох эрсдэл үүссэн. Мөн цутгамал төмөр бетон хучилтын арматурын хамгаалалтын үе гаргаж зай баригч /spacer/ хийгээгүйгээс доод үеийн арматур ил гарч зэвэрсэн, бетон авах үед доргиур тавиагүйгээс арзайсан, суулт өгсөн нь БНБД 52-02-05-ын 4.1.3-т арматурын хамгаалах үеийн заасан хэмжээнээс хэтэрч болох дээд хэмжээ нь /ф15мм хүртэл арматурт/- 4 мм байна гэснийг зөрчсөн, цутгамал төмөр бетон баганууд давхар бүрд зураг төсөлд заасан тэнхлэгээс зөрсөн нь БНБД 52-01-10-ын 2.7-д заасныг тус тус зөрчсөн;
- Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 200 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Хар үжин ХХК-ийн цутгамал төмөр бетон суурь, зоорийн давхрын ажлын гүйцэтгэлд 285.4 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч БНБД 52-02-05 зөрчсөнөөс ажил зогссон;
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын 200 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Оточ ноёдууд ХХК-д цутгамал төмөр бетон суурь, зоорь, нэгдүгээр давхар, хана, хамар ханын ажлын гүйцэтгэлд 564.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч БНБД зөрчсөн тул ажил зогссон;
- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт баригдаж байгаа 1000 суудалтай дүүргийн спорт цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Грийн ресурс ХХК БНБД 52.02.05 зөрчсөн;

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас техникийн хяналт хэрэгжүүлсэн:

- Улаанбаатар хотын Налайх дүүрэгт баригдаж байгаа Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн оюутны дотуур байрын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Химон констракшн ХХК БНБД 52-02-05-ын 9.1-д “хоногийн дундаж температур +5°C-аас бага буюу өдөрт 0°C-аас илүү дулаарахгүй болох үеийг сэрүүн цаг агаарын нөхцөл” гэж заасныг зөрчиж, 2019.11.11-нд /өдөртөө -2, шөнөдөө -10/ хоногийн дундаж температур -6°C байхад D блокын В1 давхрын, 2019.11.15-нд /өдөртөө -5, шөнөдөө -16/ хоногийн дундаж температур -10°C байхад E блокын 2 давхрын, 2020.03.23-нд /өдөртөө +2, шөнөдөө -3/ хоногийн дундаж температур -1°C байхад D блокын 1 давхрын, 2020.03.26-нд /өдөртөө +9, шөнөдөө -1/ хоногийн дундаж температур +4°C байхад E блокын 3 давхрын хана, багана, дам нуруу, шат, хучилтын М300 маркийн нийт 951 м.куб бетон цутгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд БНБД 52-02-05-ын 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалтын дагуу авах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ГХБХБГ-аас хяналт хэрэгжүүлсэн:

- Завхан аймгийн Түдэвтэй сумын 200 суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Этүгэн жим ХХК барилгын цутгамал төмөр бетон шатыг барилга бүтээцийн зурагт заасны дагуу хийж гүйцэтгээгүй;
- Завхан аймгийн Тэлмэн сумын 320 суудалтай сургууль, спорт заалны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Тэнгэрийн тэмдэг ХХК барилгын 2 дугаар давхрын хучилт, дам нурууны цутгамал төмөр бетоны ажлыг 2021 оны 10 дугаар сард гүйцэтгэхдээ БНБД 52-02-05-ын 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;
- Завхан аймгийн Нөмрөг сумын 200 суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Ар Си Ди ХХК-ийн гүйцэтгэсэн цутгамал төмөр бетон хийцэд ШУТИС-ын БАС-ийн оношилгоо, зураг, төсөл судалгааны "Реконстракшн" төвийн гаргасан дүгнэлтээр БНБД 52-01-10-ын 6.4.5-д арматурын хэвийн нөхцөлийг хангахад ан цавын удаан хугацааны нээгдэлтийн үед 0.3 мм, богино хугацааны нээгдэлтийн үед 0.4 мм-ээс ихгүй байх шаардлагатай гэж заасныг зөрчсөн, барилгын 3-А, 4-А, 3-В, 2-В, 6-А, 2-Д, 3-Д, 4-Д, 5-Д, 6-Д тэнхлэгийн багана нь БНБД 52-01-10-ын 6.4.5-ын шаардлагыг хангаагүй, 1 ба 2 дугаар давхрын зарим хэсгийн баганатай холбогдох хэсэгт дам нурууны тулгуур хэсгийн бат бэх нь хүрэлцэхгүй, багана 3-А, 4-А, 3-В, 2-В, 6-А, 2-Д, 3-Д, 4-Д, 5-Д, 6-Д дугаар тэнхлэгийн нэг давхрын баганын бат бэх зарим хэсэгт хангалтагүй гарсан тул багануудыг хүчитгэх шаардлагатай гэснийг хэрэгжүүлээгүй;

- Сэлэнгэ аймгийн Мандал сумын 100 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Талын Монгол групп ХХК цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНБД 52-02-05-ийг зөрчсөн тул аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас 2016 онд 2/1069 дугаар албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байхад ажлын гүйцэтгэлд 478.2 сая төгрөг олгосон байна.

2.36 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс чанаргүй гүйцэтгэл баталгаажуулах тохиолдол цөөнгүй гарч байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал,

- Завхан аймгийн Сонгино сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч Саран инж девелопмент ХХК 2019 онд барилгыг байнгын ашиглалтад хүлээлгэн өгч санхүүжилтээ бүрэн авсан боловч тогооны барилга, гадна зүлэгжүүлэлтийн 167.5 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй тул төлбөрийн акт тогтоов.
- Эрдэнэзуу музейн "Аялал жуулчлалын гудамж" төсөл /Өвөрхангай Хархорин сум/ ТАХ-ний гүйцэтгэгч Өв дулаан ХХК-ийн цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээ, бохирын цооногийн ажлын гүйцэтгэл дутуу, ДШЛ ХХК-ийн гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн ажлаас холболтын ажлыг огт гүйцэтгээгүй, гэрэлтүүлэг суурилуулаагүй, гадна хайсны ажил дутуу, сүүдрэвч, явган замын ажлын суурийн шороог буулгаснаас өөр ажил хийгдээгүй, Хархорин АЗЗА ТӨХК-ийн авто зогсоолын талбай тохижуулалтын ажлаас талбайг тэгшилэн хашлага хийсэн ч хучилтыг хийгээгүй;
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Өвөрхангай, Баянгол сум/ ТАХ-ний гүйцэтгэгч Тэрхийн ундраа ХХК ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, барилга дээр 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажилласан техникийн комисс 45 төрлийн үүрэг даалгаврыг өгсөн ч хэрэгжүүлээгүй;
- Худаг /Өвөрхангай/ ТАХ-ний гүйцэтгэгч Монтегео ХХК худгийн дээврийн төмрийг дутуу хийснээс хана ус нэвчсэн, хаяавч бетоны чанар муу, мал услах онгоцны бетоны бат бэх стандартад нийцэхгүй, онгоцны төмөр хийцийг чанаргүй хийсэн, гүний усны түвшнийг буруу тооцооноос усны гаралт улирлаас шалтгаалдаг.
- Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /УБ, БГД-тай барилгын БУА-ыг гүйцэтгэгч Молор констракшн ХХК барилгын дээврийн борооны ус зайлуулах хаялга, босоо хоолойг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, усан бассейны доороос ус нэвчиж шүүрсэн, явган замын хашлагыг тэнгэнцэртэй иргэн зорчих налуулга гаргаагүй;
- Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 5 дугаар цэцэрлэг/ ТАХ-г гүйцэтгэгч Тана орд ХХК 8 төрлийн ажил хийх дутуу байхад хугацаатай үүрэг даалгавар өгч ашиглалтад хүлээн авсан. Тус барилгын агуулахын дээврийг чанаргүй хийснээс хана дагаж ус нэвчсэн;
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны төвийн эмнэлгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч Гуулин-Эрдэнэ ХХК барилгын гадна өнгөлгөөний хэсэгт бага зэрэг цууралт өгсөн, агааржуулалтгүйгээс хэвтэн эмчлүүлэгчдийн өрөөний цонх мөөгөнцөртсөн эмнэлгийн стандарт хангахгүй;
- Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум 3 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний гүйцэтгэгч Трайзен ХХК-д санхүүжилтийг бүрэн олгосон боловч дээврийн төмөр баруун талдаа 800x100 см хэмжээтэй урагдаж ханзарсан;
- Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний гүйцэтгэгч ЭСПМ ХХК 5 байршилд цементэн талбай цутгасан боловч чанар байдал муу эхнээсээ бутарсан байдалтай, байршлыг тодорхой болгоогүйгээс 2 байршилд ажил эхлээгүй байна.

2.37 Манай орон газар нутгийн хувьд Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөрт өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай тул ялангуяа хаврын улиралд гал түймэр дэгдэх хандлагатай байдаг.

2.38 Аудитын явцад хийсэн судалгаагаар зарим барилга, байгууламжийн гадна фасад, дулаалга, дүүжин таазыг галын аюулгүй байдлын норм ба дүрмийг зөрчиж, шаардлага хангаагүй материалаар гүйцэтгэсэн тул хяналтыг хэрэгжүүлсэн, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлтийг баталгаажуулсан буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг ОБЕГ-т хүргүүллээ. Тухайлбал,

Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм БНБД 21-02-02-ийн 2.8-д "Гал тэсвэршилтийн I-III зэрэглэлийн барилгын гадна ханын гадаргууг шатдаг, тэсвэрлэн шатдаг материалаар өнгөлөхийг зөвшөөрөхгүй" гэснийг зөрчиж барилгын зураг, төсөвт гадна фасадыг хөөс болон эрдэс хөөсөөр дулаалахаар заасан байхад шүршдэг хөөсөөр орлуулан хийсэн:

- Баянхонгор аймгийн Баянхонгор суманд баригдсан 1200 суудалтай Номундалай сургуулийн БУА-ыг Хаш гоёо ХХК гүйцэтгэснийг 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2020/41 дугаар дүгнэлтээр;
- Баянхонгор аймгийн татварын хэлтсийн БУА-ыг Хаш гоёо ХХК гүйцэтгэснийг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2020/46 дугаар дүгнэлтээр;
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 320 суудалтай сургуулийн өргөтгөлийн БУА-ыг Эх бүрдэн ХХК гүйцэтгэснийг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2021/24 дугаар дүгнэлтээр тус тус байнгын ашиглалтад хүлээн авсан.
- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа Үндэсний номын сангийн барилгын консолын дулаалгыг шүршдэг хөөсөөр хийсэн.

Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02-ын 2.5-д "Дүүжин таазны яс /каркас/-ыг шатдаггүй материалаар хийнэ" гэж заасныг зөрчиж:

- Хэнтий аймгийн Хэрлэн сумын Орон нутаг судлах музейн барилгын сан хөмрөг хадгалах өрөөнүүдийн тааз зураг төсөл, төсөвт эмульс байсныг галд тэсвэргүй дүүжин таазаар, 1 дүгээр давхрын 15, 16, 17, 18 дугаар өрөө, 2, 3 дугаар давхрын ханын заслын ажлыг шалны түвшнээс дээш 3.12 метр хүртэл галд тэсвэртэй будгаар будахаар заасныг ханын зарим хэсэгт цаасан обой наасан;
- Хэнтий аймгийн Дадал сумын Нутгийн удирдлагын ордон, Дадал сумын 150 ортой дотуур байр, Баян-Адарга сумын 150 ортой дотуур байр, Баян-Адарга сумын сургуулийн барилгын өргөтгөлийн барилга, Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгад дээрх ном ба дүрмийн шаардлагыг хангаагүй дүүжин тааз хийсэн.

2.39 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардал, захиалагчийн техник хяналтын зардлыг холбогдох дансанд шилжүүлээгүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг захиалагч байгууллагууд жил бүр давтан гаргасаар байгаа нь мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажилладаггүй, техникийн хяналтын зардлыг тухайн арга хэмжээний хяналтад бүрэн хэмжээгээр зарцуулж хэвшээгүйтэй холбоотой байна. Тухайлбал,

Магадлашгүй ажил ангилалд хамаарахгүй зардлыг актаар баталгаажуулж, санхүүжүүлсэн:

- Орон нутаг судлах музейн БУА-г гүйцэтгэгч Монкон констракшн ХХК-д ажлын гүйцэтгэл №4-өөр 19.7 сая төгрөгийг;
- Татварын хэлтсийн БУА-ыг гүйцэтгэгч Их үен ХХК-д ажлын 3 дугаартай гүйцэтгэлээр 34.7 сая төгрөгийг;
- Гал түймэр унтраах 10 дугаар ангийн барилгын хөрсний ус зайлуулах дренажын ажил, соёлын заалны дотор интерьер, тохижилтын ажил /УБ, ЧД-ын БУА-г гүйцэтгэгч Голден лайт групп ХХК-д ажлын гүйцэтгэл №02/2021-ээр 14.6 сая төгрөгийг;
- Завхан аймгийн Сонгино сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн БУА-ыг гүйцэтгэгч Саран инж девелопмент ХХК-д 21.3 сая төгрөгийг тус тус үндэслэлгүй олгосон.

Зохиогч, захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй төслийн захиалагчийн хяналтын зардалд санхүүжилт авсан:

- Багшийн хөгжлийн ордны дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний засварын ажлын гүйцэтгэлд зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байхад техникийн хяналтын 699.4 мянган төгрөгийн;
- Багшийн хөгжлийн ордны дулаан лифт засварын ажлын гүйцэтгэлд зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байхад техникийн хяналтын 684.1 мянган төгрөгийн зардлыг БШУЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд тус тус байршуулсан тул төлбөрийн акт тогтоов.
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн их засварын ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулаагүй байхад захиалагчийн хяналтын зардал болох 996.4 мянган төгрөгийг УАУТХ-гийн дансанд шилжүүлсэнд мөн улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.
- Завхан аймгийн Алдархаан сумын төвийн шинэчлэлтийн ажилд захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр мэргэжлийн бус хүнтэй гэрээ байгуулж, санхүүжилт олгосон, хяналтын үлдэгдэл зардлыг төсөвт төвлөрүүлээгүй тул 76.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Зориулалт бусаар зарцуулсан:

- Хөвсгөл аймагт захиалагчийн хяналтын зардлаас 28.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Төрийн өмчит компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлын ашиглалт хангалтгүй байна

2.40 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтын хүрээнд УИХ-ын 2020 оны 39 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд Эрдэнэт ТӨҮГ-ын санхүүжилтээр 2021-2022 онд хэрэгжүүлэхээр баталжээ.

2.41 БШУЯ-аас хийсэн судалгаагаар 357 сургууль, 220 цэцэрлэг, 242 дотуур байр, нийт 819 байгууллага гадна нүхэн жорлонтой үйл ажиллагаа явуулж байгаагаас Эрдэнэт ТӨҮГ-ын 100.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2021 онд эхний I, II ээлжийн 368, 2022 онд III-IV ээлжийн 350 орчим ариун цэврийн байгууламжийг төсөвт өртгийг харгалзан шийдвэрлэх, харин үлдэх 100 гаруй ариун цэврийн байгууламжийг Барилга, хот байгуулалтын салбарт 2020-2024 онд хэрэгжих сумдыг инженерийн шугам сүлжээнд холбох “Сумын хөгжил” төслийн хүрээнд шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.

2.42 БШУС-ын 2021 оны А/188 дугаар тушаалаар I ээлжид сонгогдсон нэн шаардлагатай 26,620.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 аймгийн 51 суманд төсөл хэрэгжүүлэхээр жагсаалт баталж, нэг маягийн зураг, төсөлд холболт хийхээр худалдан авах ажиллагааг зарлаж, 184 байршилд /77 сургууль, 47 цэцэрлэг, 60 дотуур байрны барилга/ 14 компанитай 2021 оны 8 дугаар сард гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлж, II ээлжид 16 аймгийн 49 суманд төсөл

хэрэгжүүлэх 138 байршилд /55 сургууль, 34 цэцэрлэг, 49 дотуур байр/ 12 компанитай 2021 оны 10 дугаар сард гэрээ байгуулан, барилга угсралтын ажлыг эхлүүлж нийт 10.8 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

2.43 Гэвч БШУЯ-тай 2021 оны 9 дүгээр сард БХТ-тэй байгуулсан “Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх” гэрээний дагуу хийсэн хяналтаар гүйцэтгэгч батлагдсан зураг төсөлгүй, холбогдох судалгаа төлөвлөлтгүй, технологийн дараалал болон барилгын норм зөрчиж ажил гүйцэтгэсэн, шугам сүлжээний трассыг газар дээр нь хэмжилгүй таамгаар төлөвлөсөн, инженер геологийн судалгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээгүй, бохир усны шугамыг хөлдөлтийн гүнээс дээш суурилуулсан зэрэг зөрчлүүд ихэнх байршилд илэрсэн байна.

2.44 УИХ-аас байгуулагдсан ажлын хэсгийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар 1, 2-р ээлжид илэрсэн зөрчлийг арилгуулж, ажлыг эрчимжүүлэх, 2022 оны 6 дугаар сарын 30-ны дотор 50 хувийг, 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор үлдсэн ажлыг дуусгаж ашиглалтад оруулах үүрэг өгч, төсөл, арга хэмжээ бүрийг хэсэгчлэн ашиглалтад оруулах боломжийг судалж, аль болох дэмжиж ажиллахыг үүрэг болгосон байна.

2.45 Өнөөдрийн байдлаар I ээлжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40-60 хувьтай, II ээлжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 20-40 хувьтай, нийт 27 багцаас ашиглалтад орсон нэг ч барилга байхгүй, 12 багцын зураг төсөлд магадлал хийгдэж, зургийн дагуу гүйцэтгэлийг засварлах ажил хийгдэж байна. Харин 15 багц ажлын зураг төсөлд магадлал хийгдээгүй, засварлах ажил эхлээгүй нь хөрөнгө үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байгаа тул ажлын гүйцэтгэлд эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна

2.46 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2²⁶, 7.3²⁷, Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7²⁸, 10.1.14²⁹ дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан:

1. **Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хувьд:** хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх оны гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан;
2. **Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд:** гэрээ байгуулагдсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг тус тус барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг ТЕЗ нарт даалгажээ.

2.47 Аудитаар санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж үзэхэд 933.1 тэрбум төгрөг буюу 65.8 хувийг төсөл, арга хэмжээний бодит ажлын гүйцэтгэлээр олгож, дээрх шийдвэрийг үндэслэн ТЕЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 26.7 хувь буюу 378.4 тэрбум төгрөгийг байршуулсан нь тухайн төсөл, арга хэмжээний 2021 онд санхүүжүүлэх дүнгийн 41.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 19. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн дүн (сая төгрөг)

№	ТЕЗ	Үргэлжлэн хэрэгжиж байгаа		Шинээр хэрэгжиж байгаа		Үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан			
		ТАХ-ний тоо	Барьцаанд	ТАХ-ний тоо	Барьцаанд	ТАХ-ний тоо	2021 онд санхүүжих	Барьцаанд байршуулсан	Эзлэх хувь
1	ЭМС	19	10,687.2	14	93,168.3	33	154,717.8	103,855.5	67.1
2	БШУС	109	60,034.9	39	19,980.1	148	241,107.5	80,015.0	33.2
3	ЗТХС	25	47,906.7	9	3,957.4	34	121,361.4	51,864.1	42.7
4	БХБС	31	30,624.7	39	8,719.0	70	128,461.6	39,343.7	30.6
5	СоС	28	21,846.5	14	8,295.9	42	58,099.6	30,142.4	51.9
6	CaC	3	5,300.6	2	11,173.9	5	82,460.5	16,474.5	20.0

²⁶ цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;

²⁷ Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

²⁸ төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;

²⁹ ухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх.

7	ЭХС	4	9,173.6	7	3,394.2	11	16,510.0	12,567.8	76.1
8	МУЕС	14	10,433.4	3	1,614.0	17	24,093.4	12,047.4	50.0
9	ХНХС	11	4,691.6	8	4,215.4	19	15,212.5	8,907.0	58.6
10	ЗГХЭГД	11	3,416.5	14	3,876.7	25	17,035.3	7,293.2	42.8
11	УЕП	2	3,982.0	1	900.0	3	8,045.2	4,882.0	60.7
12	ХХААХҮС	5	866.3	10	3,184.5	15	8,245.4	4,050.8	49.1
13	БОАЖС	4	2,853.7	3	638.1	7	9,445.0	3,491.8	37.0
14	МУИХД			1	1,800.0	1	3,570.3	1,800.0	50.4
15	БХС	2	1,551.1			2	3,600.0	1,551.1	43.1
16	МУШС	1	68.2			1	12,675.4	68.2	0.5
17	ШЕЗ			1	26.4	1	1,000.0	26.4	2.6
	Нийт	269	213,437.0	165	164,943.9	434	905,640.9	378,380.9	41.8

Эх сурвалж: Сангийн яам

2.48 Зарим төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал,

ЗТХС-ын багцад 2019 оны Засгийн газрын 430 дугаар тогтоолыг үндэслэн байршуулсан:

- Авто замчдын гудамжнаас Монполимет комплекс орон сууц хүртэлх авто зам /УБ, СБД, 1 дүгээр хороо/ ТАХ-ний 63.5 сая;
- Дүүргийн доторх авто зам, явган хүний зам /УБ, БГД/ ТАХ-ний 444.6 сая;
- Зам талбайн тохижилт, ногоон байгууламж, авто зам, авто замын засвар /УБ, БЗД, 6, 15, 18, 25, 26 дугаар хороо/ ТАХ-ний 381.8 сая;

БШУС-ын багцад:

- Архангай аймгийн оюутны дотуур байрны спорт заал барих газрын асуудал бүрэн шийдэгдээгүй тул 748.3 сая;
- Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн БУА-ыг 2019 оноос эхлэн гүйцэтгэсэн боловч дотор цахилгаан, заслын ажил хийгдээгүй байхад улсын комисс ашиглалтад хүлээн авч барьцаанд байршуулсан 450.0 сая төгрөгийн санхүүжилттэй 313.6 сая төгрөгийг олгосон;

Соёлын сайдын багцад:

- Төв халхын дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/ ТАХ-ний 1,710.0 сая;

ЭХС-ын багцад:

- Электрик ком ХХК 2018 оны 12 дугаар сард Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЦДАШ-ыг ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан боловч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тул 705.3 сая, нийт 4,053.5 сая төгрөгийг хугацаанд нь ашиглаагүй тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх акт тогтоолоо.
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/ ТАХ-ний гүйцэтгэгч санхүүжилтэд барьцаа хөрөнгийн данснаас гэрээний үнийг давуулан 5.1 сая төгрөгийг олгосон;
- Барьцаа хөрөнгийн дансанд Сургуулийн барилгын өргөтгөл /Говь-Алтай, Чанадмань сум/ ТАХ-ний хийгдээгүй магадалшгүй ажлын зардал болох 4.1 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Говь-Алтай, Алтай сум/ ТАХ-ний зохиогчийн хяналтын зардал болох 1.9 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

2.49 Дээрх тогтоолоор цар тахлын үед ажлын байр хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор төсөл, арга хэмжээний санхүүжилтэд зохицуулалт хийж, барьцаа хөрөнгийн дансанд он дамжуулан байршуулахыг ТЕЗ нарт даалгаж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.6³⁰-д заасантай нийцэхгүй, данс, бүртгэлийн тогтолцоо алдагдах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт нь ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн 3 хувиас хэтэрсэн:

- ЭМС-ын багцад 71,478.4 сая;
- ЗТХС-ын багцад 42,939.5 сая;
- БХБС-ын багцад 32,957.3 сая;
- БШУС-ын багцад 28,780.3 сая;
- Соёлын сайдын багцад 25,999.7 сая;
- ЭХС-ын багцад 10,537.0 сая;
- МУЕС-ын багцад 6,963.2 сая;
- ЗГХЭГД-ын багцад 4,426.6 сая;
- УЕП-т 2,695.6 сая, нийт 226,777.6 сая төгрөгийг төсвийн ерөнхий дансанд буцаан төвлөрүүлэхээр байна.

Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг сайжруулах, хариуцлагажуулах шаардлагатай байна

2.50 Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж материал татан авалт саатсанаас гэрээний хугацаа хэтэрсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгуулах зорилгоор комисс ажиллаж барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан дутуу ажлыг гүйцэтгээгүй барилгыг ашиглах боломжгүй байна. Тухайлбал,

³⁰ Барьцаа хөрөнгийн зориулалтаар орж ирсэн орлогыг тухайн мөнгө тушаасан байгууллага, иргэнд шилжүүлэх

Өвөрхангай аймагт:

- Хангамж өргөө ХХК-ийн гүйцэтгэсэн Тарагт сумын Засаг даргын тамгын газрын БУА 75.0 хувийн гүйцэтгэлтэй, барьцаа хөрөнгийн дансанд 77.0 сая төгрөгийг байршуулсан байхад 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн БУ-34/2020 дугаартай комиссын дүгнэлтээр барилгыг ашиглалтад оруулсан байна. Гэвч гүйцэтгэгч ажлыг бүрэн гүйцэтгээгүй, хуурамч зураг хавсарган ирүүлсэн, БУА-ыг дутуу хийсэн учраас ашиглаж эхлээгүй.



Зураг 2. ЗДТГ-ын барилгын зураг, 2022 оны 5 дугаар сар

- ДШЛ ХХК-ийн гүйцэтгэсэн Хархорин сумын Аялал жуулчлалын гудамж төслийн гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн ажил 64.0 хувийн гүйцэтгэлтэй, санхүүжилтийн 92.6 хувийг олгож, үлдэх 7.4 хувь буюу 19.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, явган зам, гадна хайс, сүүдрэвчийн ажил 70.0 хувийн гүйцэтгэлтэй боловч санхүүжилтийг 100.0 хувь авсан байхад комиссын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн БУ-28/2021 дугаартай актаар байнгын ашиглалтад хүлээж авсан бөгөөд одоогийн байдлаар гадна хайсны ажлыг бүрэн хийгээгүй, явган зам тавиагүй, сүүдрэвчийн ажил хийгдээгүй байна.
- Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд 2012-2020 оны Төсвийн тухай хуулиар хөрөнгө батлагдаж хэрэгжүүлсэн 4,717.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 320 суудалтай сургуулийн барилгын гүйцэтгэгчээр Есүй ордон ХХК шалгарч, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр 4,716.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байгуулж, санхүүжилтээ 100 хувь авч, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн УҚД-2020/97 дугаартай комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан боловч гадна, дотор заслын ажил бүрэн хийгдээгүй 2022 оны 6 дугаар сарын байдлаар ашиглаж эхлээгүй;



Зураг 3, 4. Сургуулийн барилгын зураг, 2022 оны 6 дугаар сар

- Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ суманд 2019-2020 оны Төсвийн тухай хуулиар хөрөнгө батлагдаж хэрэгжүүлсэн 3,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 320 суудал сургуулийн барилгын гүйцэтгэгчээр Хөвсгөл суварга ХХК шалгарч, 3,496.7 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулж, санхүүжилтээ 100 хувь авч, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн УҚД-2020/95 дугаартай комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан боловч гадна цахилгаан, гадна, дотор заслын ажил бүрэн хийгдээгүй, 2022 оны 6 дугаар сарын байдлаар ашиглаж эхлээгүй;



Зураг 5, 6, 7. Сургуулийн барилгын зураг, 2022 оны 6 дугаар сар

- Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Соёл спортын цогцолборыг 3,297.8 сая төгрөгөөр барьж байгуулсан боловч ашиглалтад орсноос хойш дээрээс ус алддаг, 2 давхрын ариун цэвэр, халуун усны өрөөг ашиглах боломжгүй байгаа боловч гүйцэтгэгч засварлаагүй, 7 албан хаагч ажилладаг, урсгал зардлыг батлаагүйгээс халаалтын өр үүссэн.

Зураг 8. Соёл спортын цогцолборын барилгын зураг, 2022 оны 5 дугаар сар



- Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Монгол Дайван ХХК-ийн гүйцэтгэсэн Гэр хорооллын усан хангамжийн төслийг 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан боловч ашиглах боломжгүй;
- Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдсан 8,058.0 сая төгрөгийн өртөг бүхий 100 ортой эмнэлгийн барилгыг улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан боловч Арвис интернэйшнл ХХК барилгын ажлыг гүйцэтгэхдээ дээврийн битүүмжийг алдагдсанаас борооны ус гоождог, дээврийн хар цаас хууларсан, дээврийн налууг норм, дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй.
- Энигма констракшн ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээн авсан Био аюулгүй ажиллагааны III шатлалын лабораторийн барилгын ажлын гүйцэтгэхдээ барилгын норм ба дүрмийн шаардлагыг хангаагүйгээс дээвэрт ус тогтдог, цэвэр бохир усны систем, дулаан хангамжийн ажлын зургийн алдааг залруулаагүйгээс ашиглах боломжгүй байна.

Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилгын ашиглалт хангалтгүй байна

2.51 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийж буй зарим худалдан авалтыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүйгээс зарим тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хугацаанд нь нийлүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй, цаг хугацаанд нь ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

2.52 Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4³¹, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3³², 3.4³³ -т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал,

2021 онд хугацаандаа нийлүүлэгдээгүй:

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Морин хуур" хөгжим худалдан авах ТАХ-ний хүрээнд морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-04 дугаартай 521.1 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай, хуулийн XIII.4.1.1.9 дугаартай Ерөнхий боловсролын сургуульд "Морин хуур" хөгжим худалдан авах ТАХ-ний хүрээнд морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-09 дугаартай тай 631.4 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай тус тус байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/173 дугаар тушаалаар томилогдсон 4 хүний бүрэлдэхүүнтэй бараа хүлээн авах комиссын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр нийт 4736 ширхэг 1,152.5 сая төгрөгийн хөгжмийн зэмсэг хүлээн авснаар тайлагнаж, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэвч актыг фото зургаар баталгаажуулаагүй, аудитаар 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Эгшиглэн Магнай ХХК-ийн агуулахын тооллогоор СӨБ-д нийлүүлэх 400 ширхэг морин хуурыг үйлдвэрлээгүй, нийлүүлээгүй 4612 ширхэг 1,120.1 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй байх тул бараа нийлүүлэх хуваарийг гаргаж, 1,031.3 сая төгрөгийн үнэ бүхий 4212 ширхэг морин хуурыг нийлүүлэх талаар хугацаатай албан шаардлага, СӨБ-ийн байгууллагад нийлүүлэх үйлдвэрлээгүй 400 ширхэг морин хуурын 88.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.
- Ерөнхий боловсролын сургуулийн цайны газар, сургуулийн дотуур байранд гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах 1,285.8 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 21-ны өдөр Голден дрийм ХХК-тай байгуулж, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/102 дугаартай бараа хүлээн авах комиссын актаар 12 нэр төрлийн 1,285.8 сая төгрөгийн үнэ бүхий 2476 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон. Гэвч аудитаар Голден дрийм ХХК-ийн агуулахад тооллого хийх боломжгүй, агуулахын нөхцөл хүнд, бараануудад эвдрэл гэмтэл гарч байгааг баримтжуулсан бөгөөд нийлүүлээгүй 12 нэр төрлийн 1,065.7 сая төгрөгийн үнэ бүхий 1715 ширхэг барааны үлдэгдэлтэй байх тул барааг нийлүүлэх талаар хугацаатай албан шаардлага хүргүүлэв.
- Сургууль, цэцэрлэгийн сургаалтын хэрэгслэгдэхүүн, ширээ сандал, тавилга хэрэгсэл худалдан авах 631.4 сая төгрөгийн дүнтэй ерөнхий гэрээг ТХААГ 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Анун ХХК-тай байгуулсны дагуу БШУЯ-аас 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Анун ХХК-тай Худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулж, 2021 оны 12 дугаар сард бараа хүлээн авах комиссын актаар 275 ширхэг 137.5 сая төгрөгийн үнэ бүхий багшийн бичгийн шүүгээг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэвч аудитаар Анун ХХК-ийн агуулахад хийсэн тооллогоор 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар барааг бүрэн нийлүүлээгүй, 275 ширхэг 137.5 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй байна. Иймд бараа нийлүүлэх хуваарийг гаргаж, үлдэгдэл барааг нийлүүлэх талаар хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

Өвөрхангай аймагт:

- Баянгол мед ХХК-ийн Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн чих, хамар, хоолойн багц тоног төхөөрөмжийн өвчтөний сандлын автомат тохиргооны горим ажиллахгүй, хянах дэлгэцийн мэдрэгчийн ажиллагаа доголдолтой.

Баянхонгор аймагт:

- ЭМТ-д хуваарилсан 2.1 сая төгрөгийн Gmobile интернэтэд холбох төхөөрөмж нийлүүлэгдээгүй;

Баян-өлгий аймагт:

³¹ Захиалагчийн эрх, үүрэгт худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах

³² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана

³³ ТЕЗ нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллана

- Нийт 6.3 сая төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг үзлэгийн ор дутуу нийлүүлсэн;

Өмнөх ондуудад гэрээ байгуулсан боловч 2022 оны 4 дүгээр сарын байдлаар нийлүүлэгдээгүй:

- Сургуулиудад сурагч ширээ, сандал нийлүүлэх гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Долоон Болдог ХХК-тай байгуулсан боловч хэрэгжилт хангагдаагүй, 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар тус компанийн агуулахад 220.9 сая төгрөгийн тавилга үлдээгдлээр, 232.5 сая төгрөгийн үнэ бүхий тавилгыг үйлдвэрлээгүй байна. Иймд бараа нийлүүлэх хуваарийг гаргаж, үлдээгдлээр байгаа 28 нэр төрлийн 5534 ширхэг тавилгыг ашиглагч байгууллагад нийлүүлэх албан шаардлага, үйлдвэрлээгүй 13 нэр төрлийн 3518 ширхэг тавилгын 232.5 сая төгрөгийн үнэ бүхий барааны дүнгээр гэрээний алданги тооцож төлбөрийн акт тогтоон үйлдвэрлээгүй барааг үйлдвэрлэж нийлүүлэх талаар хугацаатай албан шаардлага өглөө.
- ЕБС болон сургуулийн дотуур байранд тавилга нийлүүлэх гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Евроэлектроникс ХХК-тай байгуулсан боловч гэрээний хэрэгжилт хангагдаагүй, аудитаар 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 2 нэр төрлийн 84 ширхэг 16.9 сая төгрөгийн барааны үлдэгдэлтэй, Евроэлектроникс ХХК-ийн агуулахын тооллогоор 385 ширхэг барааг үйлдвэрлээгүй байх тул бараа нийлүүлэх хуваарийг гаргаж, үлдэгдэл барааг нийлүүлэх талаар хугацаатай албан шаардлага, үйлдвэрлээгүй 385 ширхэг 132.5 сая төгрөгийн барааны дүнгээр гэрээний алданги тооцож төлбөрийн акт тогтоолоо.

БШУС-ын багцад бэлтгэсэн компьютер, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгийг хугацаанд нь ашиглагчид хүлээлцэн өгөөгүй, нийлүүлэгч байгууллагын агуулахад их хэмжээгээр хадгалагдаж, ашиглалтгүй байгаа нь УИХГ-үүд өөрсдийн сонгогдсон тойрогт ажиллахаар явах үедээ тухайн техник, хэрэгслийг тараадагтай холбоотой байна. Тухайлбал,

- БШУС-ын багцын Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн өнгөт принтер 1ш, хар принтер 1ш, 42 инчийн өнгөт зурагт 1ш, суурин компьютер 1ш-ийг Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгт очих үеэрээ аваачиж өгсөн боловч 1.9 сая төгрөгийн 1ш суурин компьютер ажиллахгүй;
- Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/ 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй энэхүү хөтөлбөрийг хэзээ, хэн ямар зорилго, үр дүнд хүрэхээр баталсан нь тодорхойгүй, нийлүүлсэн цахилгаан даралтат хөгжим нь мэргэжлийн түвшинд ашиглах боломжгүй, хянах дэлгэц нь хятад хэл дээр учраас ашиглахад хүндрэлтэй байна

2.53 Хуулиар хэрэгжүүлэхээр баталсан зарим арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс ашиглалт хангалтгүй, үргүй зардал гарах эрсдэлтэй байна.

Тухайлбал,

- БШУС-ын багцаас химийн кабинетын сургалтын хэрэглэгдэхүүнийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл, Тарагт сумдад нийлүүлсэн боловч Хужирт, Зүүнбаян-Улаан, Тарагт сумд нь стандартын шаардлага хангасан химийн кабинетгүйн улмаас ашиглалт хангалтгүй, татах шүүгээг бүрэн угсраагүй, бусад хэрэглэгдэхүүнийг сургалтад хэрэглээгүй шинээрээ байна.
- Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ ТАХ нь тухайн суманд орон нутгийн санхүүжилтээр өмнө нь баригдсан байхад дахин Ахмадын өргөөний барилга барихаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар уг барилгад нэмж 250.0 сая төгрөгийн санхүүжилт баталсан.
- Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ ТАХ-г 2020-2021 онд 1,033.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөж, 2021 онд 633.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүн, хийх ажил тодорхойгүй учраас аймгийн Засаг дарга техникийн тодорхойлолт батлан хэрэгжүүлэхдээ байршлыг өөрчилж, Тариалан, Улаан-Уул, Цэцэрлэг, Цагаан-Уул, Шинэ-Идэр, Баянзүрх сумдад хуваарилсан. Ихэнхдээ орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх боломжтой тоног төхөөрөмж, гэр, автомашин худалдан авах, урсгал зардлын шинжтэй тэжээлийн үр, оготно устгах багаж авахад зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн, нийлүүлсэн ихэнх тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, худалдан авсан техник хэрэгслийн ашиглалт, үр дүнд ашиглалтын хугацааны турш хяналт хэрэгжүүлэхгүй, хариуцлага тооцохгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна

2.54 Захиалагч, захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагаас байнгын ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтэд тавих хяналт хангалтгүй, барилгын ажил бүрэн дуусаагүй байхад ашиглалтад оруулсан нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1³⁴, 40 дүгээр зүйлийн 40.1.8³⁵, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.1 дэх хэсгийн 8.2.1³⁶-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал,

³⁴ Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:

14.1.1. зураг төслийн дагуу баригдсан байх;

14.1.2. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

14.1.3. байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;

14.1.4. зэргэлдээ орших барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байх.

³⁵ барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах;

³⁶ арилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

- Молор констракшн ХХК-тай 2014 оны 6 дугаар сарын 25-ны өдөр 3/165 дугаартай 2019 оны 7 дугаар сард 1,439.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн 2020 онд байнгын ашиглалтад хүлээн авсан Хэнтий аймгийн Дадал сумын 150 ортой дотуур байрны барилгын дээвэрээс ус алдаж, дотор хана мөөгөнцөртсөн, розетка, гадна дотор камер ажиллахгүй, бохир хөлдсөн, дотор таазыг галд тэсвэргүй дүүжин материалаар хийсэн, барилгын хаявч суулт өгч, ан цав гарсан байх тул дээрх ажлуудыг засварлан хийж, биелэлтийг ханган ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.
- Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын 2020 оноос он дамжин хэрэгжиж буй 453.6 сая төгрөгийн гэрээний үнэтэй цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг Бридж констракшн ХХК гүйцэтгэн ашиглалтад өгсөн боловч зарим хэсгийн хананд цууралт үүссэн, явган замын хавтан хөдөлгөөн ихтэй, цонхны дотор талын хана даган дээвэрээс ус гоожсон, барилгын хүзүүвч хэсэгт ус зайлуулах хоолой байхгүйгээс ус тогтдог, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам шаардлага хангахгүй, шалны хулдаасыг солих шаардлагатай;
- Баянхонгор аймгийн Баянбулаг сумын 2019 оноос дамжиж хэрэгжсэн 1,842.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 160 хүүхдийн сургуулийн барилгыг Шинэ өлгийн зам ХХК нь гүйцэтгэж улсын комиссоор хүлээлгэн өгсөн бөгөөд ашиглалтын явцад 4 ангийн цонх хагарсан, номын сангийн хана болон зарим ангиудын хананд өнгөний шохой, будаг хагарч хуурсан, дусаал гоожсон, таазны замаскийг хийгээгүй, гадна талбайн камер ажиллахгүй;
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2, 7, 9 дүгээр багийн 4,995.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 640 хүүхдийн сургуулийн барилгыг Хөх бүрдний эх ХХК гүйцэтгэж улсын комиссоор хүлээлгэн өгсөн бөгөөд ашиглах явцад дээврийн залгаасаар дусаал дусдаг, усны нөөцийн савны хананд цууралт үүссэн, цонх болон шилэн хананы хэсгүүдээр дулаан алдалт ихтэй, хананы зарим хэсэгт өнгөний цууралт үүссэн;
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын “Номгон” ахлах сургуулийн барилга нь ашиглалтын явцад ханын өнгөн хэсгийн шаварт хагаралт үүссэн, залны үүдэн хэсэгт гилсэн хавтангаар хийсэн нь цөмөрч эвдрэл үүссэн, ангиудын гар угаалтуур цөмөрч эвдрэл үүссэн, шээлтүүрийн арын хананд ус нэвчсэн, ханын доод хэсгээр хийсэн плита унаж, хагарч байгаа, суултуурыг нааж бэхлээгүй, буланд хийсэн тор ил гарсан;
- Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 5 дугаар цэцэрлэг/ ТАХ-г гүйцэтгэгч Тана орд ХХК-ний гэрээний дүн 222.4 сая төгрөг ба 150.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, барьцаа дансанд 71.5 сая төгрөг байршиж байна. Ажлын гүйцэтгэлээс 8 төрлийн ажил хийх байхад хугацаатай үүрэг даалгавар өгч ашиглалтад хүлээн авсан. Тус барилгын агуулахын дээврийг чанаргүй хийснээс хана дагаж ус нэвчсэн;
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны төвийн эмнэлгийн барилгын их засварын ажлыг Гуулин-Эрдэнэ ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгын гадна өнгөлгөөний хэсэгт бага зэрэг цууралт өгсөн, агааржуулалтгүйгээс хэвтэн эмчлүүлэгчдийн өрөөний цонх мөөгөнцөртсөн, эмнэлгийн стандарт хангахгүй;
- Хөвсгөл аймгийн Тариалан сумын Халуун усны барилгыг 144.9 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан Голден прогресс ХХК гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөвт тусгасан гадна тохижилтын ажил болон комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн ажлыг хийгээгүй байхад 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн ББКД-67-52/21 тоот комиссын актаар хүлээн авсан;
- Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/ -н ажлыг Хөвсгөл Мон Трэйвел ХХК 398.2 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэхдээ чийрэгжүүлэх төхөөрөмж 5 ширхэгийг дутуу, жижиг гэрэл 4 ширхэгийг суурилагаагүй, том гэрэл, 4 ширхэг суурилуулаагүй байхад 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн БХБЯ/202001098/1.3.12 дугаартай комиссын актаар хүлээн авсан байна.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Эндус-Эрхэт ХХК-тай 27.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дээврийн ус цуглуулах ховилыг зураг, төсөвт тусгасны дагуу хийгээгүй, салбар цэцэрлэгийн цонхыг солихдоо хуучин модон цонхны суурин дээр хийсэн нь зай, завсартай байхад 2021 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн ББКД-67-24/21 дугаар актаар байнгын ашиглалтад хүлээн авсан;
- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ ажлыг гүйцэтгүүлэхээр Бумбах ХХК-тай 73.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дээврийн агааржуулалтыг дутуу хийсэн, цахилгааны ажил хангалтгүй, шалны хулдаасыг зурагт заасны дагуу хийгээгүйгээс чанаргүй болсон байхад байнгын ашиглалтад хүлээн авсан.
- Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ ТАХ-нд ажлын хэсгийн тэмдэглэлээр өгсөн ажил дутуу байхад комисс хүлээж авсан.
- Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэл дутуу байхад комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна.

2.55 Ашиглалтад хүлээн аваагүй барилгад үйл ажиллагаа явуулсан тохиолдлууд илэрч байгаа нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6³⁷-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал,

Өвөрхангай аймагт:

- Тэрхийн ундраа ХХК-ийн гүйцэтгэсэн Баянгол сумын Соёлын төвийн барилга;
- Өв дулаан ХХК-ийн гүйцэтгэсэн Баянгол сумын уламжлалтын эмнэлгийн барилга;
- Хангамж өргөө ХХК-ийн гүйцэтгэсэн Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын барилга;

Орхон аймагт:

- Баян-Өндөр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга;

Нийслэлд:

³⁷ Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

- Хонгор тосгоны Эрүүл мэндийн төв зэрэг барилгууд байна.

2.56 Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалт, чанар байдалд Засгийн газар болон ТЕЗ-дын дотоод хяналт хэрэгжихгүй байгаагаас өмнөх онуудад ашиглалтад хүлээн авсан зарим барилга ашиглалтын шаардлага хангахгүй, байнгын ашиглалтад хүлээн аваагүй зарим барилгад үйл ажиллагаа явуулж байна.

2.57 Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3³⁸, 14 дүгээр зүйлийн 14.3³⁹, 40 дүгээр зүйлийн 40.1.8⁴⁰-д заасны дагуу өмнөх онуудад байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн хэвийн ажиллагаа хангагдаж байгаа эсэхийг үнэлж, гүйцэтгэгч байгууллагатай харилцаа үүсгээгүйгээс барьцаа хөрөнгийн дансанд гүйцэтгэгчид олгох санхүүжилтээс байршуулсан хөрөнгийг чөлөөлөөгүй байна. Тухайлбал,

- БШУЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2013-2017 онд байнгын ашиглалтад орсон 8 барилга, байгууламжийн 231.9 сая төгрөг байршиж байгаагаас 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 4 ТАХ-ний 65.5 сая төгрөгийн үлдээдэлтэй байна.

2.58 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, Сангийн сайдын 282 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 7 дугаар зүйлийн 7.3.3-т “холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх” зарчмыг баримтлаагүй байна. Тухайлбал,

ХХААХҮС-ын багцад:

- Булган аймагт хэрэгжсэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор өсвөр насны 67 бухыг 98.0 сая, үржлийн 83 толгой гунжийг 150.0 сая төгрөгөөр, ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 119.0 сая төгрөгийн хүлэмж худалдан авч иргэдэд олгосон боловч эзэнжүүлж, эргэн төлөлтийн гэрээ байгуулаагүй.
- Хөвсгөл аймагт хэрэгжсэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд Баяншувуут ХХК 2233.2 сая төгрөгийн 80 тугалтай үнэ, 4 бух нийлүүлэхээс техникийн тодорхойлолтод 3-4 настай гэж заасан байхад хөгшин үнээ нийлүүлсэн, малын хариулга, арчилгаа муу, хашаа хороог бэлтгээгүйгээс 31.5 хувь буюу 70.1 сая төгрөгийн 52 толгой мал хорогдсон;

БШУС-ын багцад:

- Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилга /УБ, СБД/-д байрлуулж ашиглах тоног төхөөрөмж нийлүүлэх 875.0 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Ай Ти Зон ХХК-тай байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1 дугаартай комиссын актаар 18 нэр төрлийн 568 ширхэг тоног төхөөрөмж хүлээн авсан боловч барилга барих газрын зөвшөөрөл олгогдоогүйн улмаас тоног төхөөрөмжийг ашиглах боломж бүрдээгүй байна.

ЭХС-ын багцад:

- Хуулийн XVIII.1.30 дугаартай “Бадамлах дөл” дулааны станцын өргөтгөл /Ховд, Жаргалант сум, Наран баг/ 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг 1,000.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх ажлын хүрээнд хувийн өмчийн Бадамлах дөл дулааны станцыг өмчлөгч байгууллагад хөрөнгө оруулахаар төлөвлөсөн;
- Багийн сэргээгдэх эрчим хүчний холболт /Хөвсгөл, Төмөрбулаг сум/ ТАХ-ний хүрээнд 257.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нарын зайн хураагууртай сэргээгдэх эрчим хүчний станцыг суурилуулсан боловч суурилуулсан цагаас эхлэн зөвхөн 2 хэрэглэгч ашигладаг, хадгалж, хамгаалж, хариуцах байгууллага тодорхойгүй;
- Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, их-Уул сум, Мандал, Сараалж баг/ ТАХ-ний хүрээнд 2020 онд 199.7 сая төгрөгөөр эрчим хүчинд холбох ажил хийсэн боловч багийн төв хэрэглэгч багатай, цахилгааны эх үүсвэрт одоо болтол холбоогүй;

ХНХС-ын багцад:

- Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ ТАХ-ний хүрээнд 2021 онд 77.2 сая төгрөгөөр барьсан боловч 2022 онд дахин 250.0 сая төгрөгийн өртөгтэй Ахмадын өргөө барьж байна.

2.59 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүй, хэрэгжүүлэгч байгууллагын ажлын уялдаа холбоо

³⁸ барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа” гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг

³⁹ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна

⁴⁰ барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах

хангалтгүй зэрэг нь бэлтгэсэн хөрөнгө ашиглалтгүй байх нөхцөл болж, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал,

Хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй:

- Хуулийн XII.1.88 дугаартай Сумын төвийн тохижилт /Өвөрхангай/ 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд хэрэгжиж дуусах ТАХ-г аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/161 дугаартай захирамжаар 8 сум, 1 багийг тохижуулахаар зардал хуваарилсан боловч хийсэн ажлын тоо хэмжээ, чанар харилцан адилгүй, урсгал зардлын шинжтэй арга хэмжээнд зарцуулсан.

Ашиглаагүй:

- ЭХС-ын багцад 2014-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 24,069.6 сая төгрөгийн үнэ бүхий эрчим хүчний барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.

Ашиглах боломжгүй:

- Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 2015-2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Залан мөнх ХХК 1,279.9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Дөрөө хангинуурын хөвдөг гүүрийг зэвэрч цоорсон хуучин гүүрийг нөхөж, гагнан угсарсны улмаас аюулгүй, найдвартай ажиллагаа хангаагдаагүй, цөн түрэх болон гол гэсэх үеэр татаж авч, буцааж тавих боломжгүй бөгөөд гүйцэтгэгч байгууллагад зүгшрүүлэх тохируулах хугацаанд удаа дараа санал тавьсан боловч харуу өгөхгүй байсаар чанарын баталгааны хугацаа дууссан байна. Уг гүүр нь 2021 оны 7 дугаар сарын үерийн усанд живж ашиглах аргагүй болсон тул сумын ИТХ-ийн шийдвэрээр 5.0 сая төгрөгөөр хуурай газарт татан гаргажээ. Уг ТАХ нь ЗТХС-ын багцад 2013-2016 онд “Гүүр, 4 ширхэг /Сэлэнгэ мөрний төмөр бетон 437.02 у/м гүүр, зураг, төсөл Сэлэнгэ мөрний Дөрөө хангинахын хөвдөг гүүр, Дэлгэрмөрөн голын хөвдөг гүүр, бирваазын шинэчлэл, Ерөө голын төмөр бетон гүүр /Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Их-Уул сум” нэрээр Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн бөгөөд хуульд тусгасан нэрээр тооцвол элэгдлийн хугацаа 75 жил байхад 5 жил хүрэхгүй хугацаанд ашиглалтгүй болж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ. Гүүр ашиглалтгүй болсноос шалтгаалан иргэд сумын төв ороход талдаа 200 км зам туулж, эдийн засаг, зарцуулах цаг хугацааны хохирол амсаж байна.

Цар тахлаас шалтгаалан дуусаагүй барилгад комисс ажиллуулж байнгын ашиглалтад авсан боловч ашиглалтын шаардлага хангаагүй:

- ЭМС-ын багцад 2013 оноос эхлэн хэрэгжсэн, 19,371.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Энигма констракн ХХК БУА гүйцэтгэсэн ХӨСҮТ-ийн Био аюулгүй III шатлалын лабораторийн барилгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн БА-255/2021 дугаартай актаар байнгын ашиглалтад хүлээн авсан боловч төсөл, арга хэмжээ 7 жил үргэлжлэн хэрэгжих хугацаанд сонгосон технологи шаардлагад бүрэн нийцэхгүй болсон, мөн гүйцэтгэгч ажлаа бүрэн гүйцэтгээгүйн улмаас 2022 оны 6 дугаар сарын байдлаар ашиглаж эхлээгүй байна.
- Хөвсгөл аймгийн Их-уул суманд 2020 оны 11 дүгээр сард байнгын ашиглалтад хүлээн авсан цэцэрлэгийн барилгын гадна талбайн гэрэлтүүлэг асахгүй, тоглоомын талбайн шалавч дутуу, зарим 00-ын өрөө агааржуулалтгүй, барилгын төсөвт тоо хэмжээг нь баталсан камерын дэлгэц байхгүй, гадна бохирын систем өвөл хөлдсөн байна.

2.60 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж бэлтгэж байгаа ч тухайн тоног төхөөрөмжийг ашиглах байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх ажлыг орхигдуулснаас хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал,

- Баянхонгор аймгийн Галуут, Бууцагаан сумын ЭМТ-д хүлээлгэн өгсөн тус бүр 40.1 сая төгрөгийн үнэтэй 2 ком шүдний иж бүрэн тоног төхөөрөмжийг шүдний нарийн мэргэжлийн эмч байхгүйгээс ашиглалтгүй;
- Багийн хөгжлийн дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төслийн хүрээнд 2020-2021 онд тус бүр нь 19.8 сая төгрөгийн үнэтэй 7 ширхэг арьс шир элдэх тоног төхөөрөмжийг 138.9 сая төгрөгөөр худалдан авч сумдад нийлүүлсэн боловч төхөөрөмж хүчин чадал муутай, хэрэгцээ шаардлагад нийцээгүй тул нийлүүлсэн цагаасаа хойш ашиглалтгүй, мөн 99.0 сая төгрөгийн арьс шир боловсруулах төхөөрөмжийг 2 жилийн турш ашиглаагүй, тайлант онд нэмж 39.6 сая төгрөгийн 2 төхөөрөмж худалдан авсан ч мөн л ашиглалтгүй.
- ЭМС-ын багцаас тус бүр нь 3.3 сая төгрөгийн үнэтэй 25 ширхэг Мустанг-5 мотоциклыг 82.0 сая төгрөгөөр худалдан авч Хөвсгөл аймгийн багийн дарга, эмчид нийлүүлсэн боловч нэг бүрийн үнэ нь зах зээлийн үнээс 0.5 сая төгрөгөөр илүү, хүчин чадал муутай.

2.61 Аудитаар нийт 27,913.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 10 барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгаагүй, 49.5 сая төгрөгийн их засварын ажлыг капиталжуулж бүртгээгүй байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 40 дүгээр сувилал цэцэрлэг/ ажлыг 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн БА-274/2021 дугаартай актаар;
- Орон сууцны гадна фасадын дулаалга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 23 дугаар байр/-ын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн комиссын дүгнэлтээр;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ыг 2021 оны 6 дүгээр сарын 07-ны өдөр;
- Цэцэрлэгийн барилга 150 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/-той барилгыг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн БА-192/2021 дугаартай комиссын дүгнэлтээр;
- Баянголын амны цэвэр усны шугамын ф600 мм голчтой төв шугамын холболтын ажлыг 2020 оны 5 дугаар сарын 01-нд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын ББАОКД- 33/2020 дугаартай дүгнэлтээр;
- Автомашины нийтийн эзэмшлийн зогсоолын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо/-ыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ЗБХХ-2020/25 дугаартай комиссын актаар;

- Баянголын амны усан сан өргөлтийн насосны станцын автоматжуулалтын ухаалаг систем, барилга, тоноглолын хамт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төслийн хүрээнд барьсан барилгыг 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ББАОКД- 33/2020 дугаартай актаар;
- Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 10, 11 дүгээр хороо/-г 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ЗТ-171/2021 дугаартай дүгнэлтээр;
- Халуун усны барилга/ Улаанбаатар, Хан-Уул дүүрэг Биокомбинат/-ыг 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн БА-186/2021 дугаартай дүгнэлтээр;
- Завхан аймгийн Түдэвтэй сумын 1,194.9 гэрээний үнийн дүн бүхий барилгыг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 19/2021 дугаартай дүгнэлтээр тус тус байнгын ашиглалтад оруулсан.
- Говь-Алтай аймгийн Тонхил сумын ЕБС-ийн барилгын 49.5 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн боловч капиталжуулж бүртгээгүй.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтээр хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн эрх зүйн орчин сайжирсан байна

2.62 Өмнөх аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Сангийн сайдад 3, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 4, нийт 11 зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

2.63 Харин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үр ашгийг дээшлүүлэх, төсөвлөлтийн шаардлага хангсан төсөл, арга хэмжээг батлуулах үүднээс төсвийн төлөвлөлтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийн шаардлага, аргачлалын дагуу зохион байгуулах, цахим сангийн ашиглалт, хэрэглээг төлөвлүүлэх зөвлөмжийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлснийг эрх зүйн орчны хувьд ахиц дэвшил гарсан гэж үзлээ.

2.64 Дэлхийн банкнаас гаргасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад баримтлах 8 элемент болох хөрөнгө оруулалтын стратеги бодлоготой байх, төслийн албан ёсны үнэлгээ хийгдсэн байх, төслийн төлөвлөлтөд хөндлөнгийн үнэлгээ хийсэн байх, төслийн сонголт ба төлөвлөлт нь үр ашигтай, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, төслийн хэрэгжилт ил тод нээлттэй байх, зохицуулалт нь ойлгомжтой байх, төслийн хэрэгжилтийн явцад тохируулга, сайжруулалт хийдэг байх, хөрөнгийн нэгдсэн удирдлагаар зохицуулах, хэрэгжсэн төслүүдийн чанар, ашиглалтад үнэлгээ хийдэг нэгдсэн мэдээллийн сантай байх зарчмуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

2.65 Эдгээр арга хэмжээний үр дүнд 2021 онд дараах дэвшлүүд гарсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчлэн баталж 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.
2. Олон улсад нийтийн зориулалттай дэд бүтэц болон нийгмийн салбарын төслүүдийг дан ганц төсвийн эх үүсвэр, гадаад зээл тусламж бус хувийн хэвшлийн эх үүсвэрээр хэрэгжүүлдэг туршлагыг нэвтрүүлэх шаардлага үүссэнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газраас 2021 онд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл”-ийг боловсруулан УИХ-д өргөн барьсан нь төсвийн ачааллыг урт хугацаанд бууруулах, дэд бүтцийн болон нийгмийн салбарын төслүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар урт хугацаанд үр ашигтай түншилж хэрэгжүүлэх, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх томоохон бодлогын арга хэмжээ гэж үзэж байна.

2.66 Түүнчлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой тусгайлан бүлэг нэмж худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор дуусгах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэмнэлтийг зарцуулахгүй байх, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулахгүй байх, төсөл, арга хэмжээний хэрэгжилт хуулиар батлагдсанаас хойш өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий шийдвэр гаргахгүй байхаар зохицуулсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд илэрдэг зөрчил, дутагдал 2023 оноос эхлэн арилах нөхцөл бүрдсэн гэж үзэхээр байна.

2.67 Засгийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг хугацаанд нь, чанартай хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, ТХААГ, Нийслэлийн ЗДТГ-т удаа дараа хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын газрын тогтоолоор үүрэг болгосон ч хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь хариуцлагын тогтолцоо бүрдээгүйг харуулж байна. Тухайлбал,

2021 оны 2 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн ЗДТГ-т:

- Худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх;
- Төсвийн нийт хөрөнгө оруулалт, өмч бүртгэл, ашиглалтын болон мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, орон нутгийн төсвийн болон гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах хууль тогтоомжийг сайжруулахыг;

Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоолоор:

- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй уялдуулан Засгийн газрын 2019 оны 430, 2020 оны 253 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах;
- 2021 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байх;
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарах;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээ, хуулийн дагуу хариуцлага тооцохыг;

2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 22 дугаар тэмдэглэлээр Засгийн газрын гишүүдэд:

- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж дуусгах, худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулахыг тус тус даалгасан байна.

2.68 Үндэсний аудитын газраас 2018-2021 онд хийсэн аудитаар өгсөн 16 ТЕЗ-д хамаарах 90,351.8 сая төгрөгийн зөрчил арилгах 47 албан шаардлага, 2,224.3 сая төгрөгийн зөрчлийг барагдуулах 8 төлбөрийн акт хугацаандаа хэрэгжээгүй байна.

2.69 Иймд Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, зөрчлийг арилгах акт, албан шаардлага, Засгийн газар, Сангийн яамнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд баримтлах зохицуулалтыг төсөл, хөтөлбөрийг захиалагч, хэрэгжүүлэгч, ашиглагч байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хэвшүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 351,850.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1825 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

3.2 Шинээр хэрэгжүүлэхээр баталсан 256,948.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1665 төсөл, арга хэмжээний 8-88 хувь нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.26⁴¹, 6.1.10⁴² дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6.4⁴³ дэх заалттай нийцээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 9-өөс үзнэ үү)

- 168 ТАХ буюу 11 хувь нь Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- 119 ТАХ буюу 8 хувь нь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 800 ТАХ буюу 88 хувь нь Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөтэй тус тус уялдаагүй байна.

3.3 Мөн 405 төсөл, арга хэмжээ буюу 24.2 хувь нь орон нутгийн холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналд үндэслээгүй Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1⁴⁴-д, 3.2.3⁴⁵ дахь хэсэгт заасны дагуу эрэмбэлэгдэж, үнэлгээ хийгдээгүй байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна

3.4 Төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 29.3.4⁴⁶, 24.6⁴⁷, 29 дүгээр зүйлийн 29.4⁴⁸, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1⁴⁹, 40 дүгээр зүйлийн 40.2⁵⁰ -т зааснаар барилга, байгууламж, түүний их засварын ажлыг гүйцэтгэхдээ зураг төсөл, ажлын даалгаврыг урьдчилан боловсруулж батлуулсан байх, газрын зөвшөөрөл, бусад техникийн нөхцөл олгогдсон байхаар тусгайлан заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

НИТХ-ын тогтоолд:

- 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 39 багц ТАХ-нээс 17 нь төсөл нэг бүрээр туссан бол 46,800.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 багц ТАХ-г /668 болж задарсан/ ерөнхий байдлаар баталсан;
- Шинээр хэрэгжих 685 /захиралтаар задарсан тоо/ ТАХ-нээс зураг төсөв шаардлагатай 18,840.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 88 ТАХ-г түүвэрлэн төсөвлөлтийн шаардлага хангуулсан эсэхийг тулган баталгаажуулахад 843.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ-ний зураг төсвийг төсөв баталсаны дараа боловсруулсан;
- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 214 ТАХ-нээс зураг төсөв шаардлагатай 102 ТАХ байна. Үүнээс 19,922.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ буюу 57.8 хувийг зураг төсөвгүй баталсан;

Дорноговь аймагт:

- Айраг сумын 64.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 айлын орон сууцны гадна тоглоомын талбай, авто зогсоол, явган хүний зам байгуулах ажил;
- Алтанширээ сумын 198.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төвлөрсөн шугам сүлжээнд цэвэр усны тоног төхөөрөмж суурилуулах ажил;
- Сайншанд сумын 2 дугаар багт 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашины зогсоол барих ажил

⁴¹ Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах.

⁴² орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

⁴³ Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 6.2-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон материалыг хавсаргасан байна.

⁴⁴ төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх

⁴⁵ энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх;

⁴⁶ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

⁴⁷ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.”

⁴⁸ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴⁹ 12.1. Барилгын зураг төсөл дараах шаардлагыг хангасан байна:

12.1.6. Барилгын зураг төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх

⁵⁰ 40.2. Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

3.5 Орон нутгийн төсөв баталснаас хойш зураг, төсвийг нь боловсруулсан төсөл, арга хэмжээнүүд:

Дорноговь аймагт:

- Даланжаргалан сумын сургуулийн хуучин дотуур байрыг төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц болгон засварлах ажил;
- Дэлгэрэх сумын төсөвт байгууллагуудын дотор сантехникийн засвар, төвлөрсөн шугам сүлжээнд холбох холболтын ажил;
- Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажил;
- Улаанбадрах сумын ЦДАШ солих болон дэд станц барих ажил;
- Иххэт сумын ЗДТГ-ын барилгын их засвар;
- Өргөн сумын Ахмадын өргөөний барилга барих ажил;
- Эрдэнэ сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга барих ажил;
- Сайншанд сумын 1 дүгээр баг 30 айлын орон сууцны барилгын дээврийн засварын ажил;
- Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнж гудамжны 111-р байрны дээвэр, гадна фасад засвар;
- Сайншанд сумын 3 дугаар багийн гэр хорооллын гудамжаар цэвэр, бохир усны нэгдсэн шугам татах ажил;
- Сайншанд сумын 6 дугаар багийн Чойлонгийн гудамжинд цэвэр, бохир усны төв шугам татах ажил;
- Сайншанд сумын 8 дугаар багийн 233, 245 дугаар байр /хуучнаар 28, 29-р байр/-ны гадна авто зогсоол, тоглоомын талбай байгуулах ажил;
- Сайншанд суманд шинээр баригдах Мандах наран хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил;
- Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн гадна фасад засвар;
- Аймгийн төвийн Дулааны 2-р эх үүсвэрийн технологийн шинэчлэлийн ажил

3.6 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршил, нэр, төсөвт өртөг тодорхойгүй, ерөнхий нэрээр, зураг төсөвгүй болон зураг төсвийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жагсаалт баталснаас хойш боловсруулж, батлуулж байгаа нь төлөвлөсөн хугацаа, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт өөрчлөлт орох зэргээр хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашигт нөлөөлөх, тайлант хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөл болж байна.

3.7 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь арвилан хэмнэлтгүй, үр ашиг багатай төдийгүй Төсвийн тухай хуулийн 4.1.24⁵¹, 6 дугаар зүйлийн 6.4.1⁵², 6.4.2⁵³-т заасныг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

Чиг үүрэгт хамаарахгүй:

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсөвт үл хамаарах ГИХГ-ийн хэрэгцээнд 2020 онд 294.4 сая төгрөгөөр 2 ширхэг автобус, 2021 онд 75.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, 75.0 сая төгрөгөөр тавилга, эд хогшлыг худалдан авсан, зөрчил жил бүр давтагдсан;

Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай:

- Дорноговь аймгийн Мандах наран хорооллын шугам шилжүүлэх, Мандах наран хорооллын шилэн кабелийн тоног төхөөрөмж худалдан авах зэрэг барилга байгууламжийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой 34.0 сая төгрөгийн;
- Дорнод аймагт Төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой 1,172.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ-г төлөвлөж, хэрэгжүүлсэн;
- Дундговь аймагт 270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 ТАХ хэрэгжүүлснээс 203.3 сая төгрөг буюу 75 хувийг сургалт, сургалтын хоол цай, буудал, тээвэр шатахуун, эрүүл мэндийн дэмжлэг, орон сууцны дэмжлэг, буцалтгүй тусламж, сургалтын төлбөр зэрэгт зарцуулсан;
- Завхан аймгийн Яруу сумын Нарийн давааны цас түрж, зам нээх ажилд 500.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан;
- Нийслэлд 767.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ нь өмчид бүртгэгдэхгүй орон сууцны засвар, тооллого судалгаа, сургалтын зардал;
- Нийслэлийн БЗД-т 600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газар ашиглалт болон орчны бохирдолд судалгаа хийх ажил;
- Нийслэлийн БГД-т 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэлийн ажил;
- Нийслэлийн СБД-т 96.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 дугаар хороо, 47 дугаар байрны гадна фасадын засварын ажил;
- Нийслэлийн ХУД-т 260.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн зориулалттай орон сууцны засварын ажил;
- Нийслэлийн ЧД-т 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 дугаар хорооны 21-р байрны фасад засварын ажил;
- Орхон аймагт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 8 ТАХ-нд 81.2 сая төгрөг;
- Хэнтий аймагт Хэнтий аймгийн байгаль, ан амьтан, ёс заншил танин мэдэхүйн төслийн хүрээнд Непко ХХК-тай 100.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн үнэ бүхий "Хэнтий нэвтэрхий толь" (I, II боть) хэвлүүлсэн;

⁵¹ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁵² Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁵³ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2. төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

- Өвөрхангай аймагт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 3 арга хэмжээ нь нийт хөрөнгө оруулалтын зардлын 58.5 хувийг эзэлж, аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал 400.0 сая төгрөг, Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал 85.0 сая төгрөг;
- Өмнөговь аймагт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 263.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г санхүүжүүлсэн;
- Сүхбаатар аймагт Авто тээврийн улсын үзлэг тооллого, оношилгооны зардал нэртэй 9 сая төгрөгийн урсгал зардал;
- Сэлэнгэ аймагт 86.4 сая төгрөгийн 36.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 урсгал засвар, 50.0 сая төгрөг сумдад хэрэгжих 10 ТАХ баталсан;
- Төв аймагт аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт хөрөнгө төвлөрүүлэх, ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, “Мон” төслийн зээлийн төлбөр төлөх зэрэг 1,498.7 сая төгрөгийн;
- Увс аймагт Мини захын дэнчинг Ус рашаан Эрдэнэ ХХК-д буцаан олгоход 18.6 сая төгрөг;
- Ховд аймагт 159.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г аймгийн Онцгой комиссын шийдвэрээр;

3.8 Мөн Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчиж дараах худалдан авалтыг хийсэн байна. Үүнд:

Дорноговь аймагт:

- Замын-Үүд суманд 11.6 сая төгрөгөөр Төрийн албан хаагчдад тоног төхөөрөмж худалдан авсан;
- Замын-Үүд суманд ГИХГ-т 72.6 сая төгрөгөөр тавилга, эд хогшил, 67.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авсан;

Говь-Алтай аймагт:

- Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин нийлүүлэх ТАХ-ний гүйцэтгэгч Морьт шагай ХХК-аас 32.0 сая төгрөгөөр Toyota crown-S210 маркийн суудлын автомашин тус тус худалдан авсан.

Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулаагүй, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулаагүй байна

3.9 Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 1148 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 187,458.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1122 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтаар 537, харьцуулалтын аргаар 417 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 194 шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 20. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны төрөл арга, зарцуулсан хугацаа, ил тод байдал (тоо)

№	Аймаг, нийслэл	ТАХ-ний тоо	Үүнээс:						Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад зарцуулсан дундаж хугацаа (хоног)
			Харьцуулалт	НТШ	ШХА	Цахим	Уламжлалт	Гомдол санал гарсан	
1	Архангай	8	2	2	4	8	0	0	14
2	Нийслэл	444	135	242	67	433	11	16	59
3	Баян-өлгий	19	2	0	17	17	2	0	7
4	Баянхонгор	13	10	2	1	13	0	1	13
5	Булган	4	3	1	0	2	2	1	68
6	Говь-Алтай	5	4	1	0	5	0	0	67
7	Говьсүмбэр	14	2	8	4	14	0	0	13
8	Дархан-уул	45	30	9	6	45	0	0	53
9	Дорноговь	63	34	18	11	60	3	1	33
10	Дорнод	21	10	3	8	13	8	2	78
11	Дундговь	24	5	3	16	24	0	0	20
12	Завхан	4	4	0	0	4	0	1	9
13	Орхон	111	55	54	2	111	0	3	48
14	Өвөрхангай	4	2	2	0	4	0	1	9
15	Өмнөговь	209	62	142	5	194	15	0	30
16	Сүхбаатар	16	9	6	1	16	0	3	17
17	Сэлэнгэ	72	19	14	39	72	0	1	41
18	Төв	26	10	16	0	26	0	2	71
19	Увс	9	6	3	0	7	2	0	29
20	Ховд	5	3	1	1	5	0	0	13
21	Хөвсгөл	10	5	3	2	8	2	0	16
22	Хэнтий	22	5	7	10	12	10	0	78
Нийт дүн		1148	417	537	194	1093	55	32	

Эх сурвалж: ОНТАГ

3.10 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасны дагуу цахимаар 1093, уламжлалт аргаар 55 төсөл, арга хэмжээний урилгыг мэдээлсэн байна. Шалгаруулалтын явцад 32 гомдол гарч, тендер дахин зарласан нь гэрээ оройтож байгуулах, хэрэгжилт удаашрахад нөлөөлсөн байна.

3.11 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад зарцуулсан хугацаа аймгуудын дунджаар 7-78 хоног байгаа бөгөөд сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал,

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар:

- Зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний 90 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж санхүүгийн саналын нээлтийг хийхдээ “Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа”-ны 6.4⁵⁴-т заасныг зөрчсөн;
- Нийт 475.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмыг дагаж мөрдөөгүй;
- НЗДТГ, УБ хотын ЗАА, НХААГ, НЗХГ, “УБЗЗА” ОНӨААТҮГ, СХД-ийн ХААА зэрэг газрууд 15,554.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 ТАХ-ний үнэлгээг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.3-т заасан ТББ-т тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй, ТББ-т тусгасан шаардлага хангаагүй оролцогчдыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;
- НЗД нийт 4 удаагийн захирамжаар “УБЗЗА” ОНӨААТҮГ-т 10,430.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 ТАХ эрх шилжүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.5⁵⁵-д заасан үндэслэлээр шууд гэрээ байгуулсан. Гэтэл “УБЗЗА” ОНӨААТҮГ нь дээрх ажлыг хэрэгжүүлэх туслан гүйцэтгэгч, мөн 6 төрлийн түүхий эд бараа материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн 34.2⁵⁶, 34.3-т заасныг дагаж мөрдөөгүй, 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй 6 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан;
- НЗД 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өвөлжилтийн бэлтгэл хангах ТАХ-г 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр эрх шилжүүлснээс УБ хотын ЗАА нь уг тендерийг зарлахдаа төсөвт өртгийг үндэслэл болгоогүй, ХАА-ны журмыг буруу сонгон, гэрээ шууд байгуулсан;

Нийслэлийн дүүргүүд:

- 9,875.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 48 ТАХ-нд шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага өгөө.
- Дээрх 48 гүйцэтгэгчийн ирүүлсэн материалыг шалгахад ерөнхий нөхцөлийг магадлах шалгуур 65, техникийн чадавх болон туршлагыг үнэлэх шалгуур 42, нийт 107 шалгуур үзүүлэлтийг хангаагүй;

Өмнөговь аймагт:

- Ханхонгор сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авахдаа үнэлгээний хороо нь ажлын даалгавраас зөрүүтэй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулсан байна.

Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул байгаа нь улсын хэмжээнд удирдлагын нэгдсэн систем, цахим бүртгэл байхгүйтэй холбоотой байна

Хүснэгт 21. Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт (сая төгрөг)

№	Аймаг, нийслэл, сум дүүргийн нэр	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Ажил эхэлснээс хойш олгосон нийт санхүүжилт	2021 онд олгосон санхүүжилт	Нийт арга хэмжээ	Хэрэгжиж дууссан эсэх	
							Тийм	Үгүй
А	1	2	3	4	5	6	7	8
1	Архангай	905.1	377.6	208.3	123.8	8	5	3
2	Баян-Өлгий	274.2	274.2	254.7	238.1	14	12	2
3	Баянхонгор	2,572.3	1,508.0	2,007.4	1,427.3	27	22	5
4	Булган	510.0	510.0	506.2	506.2	6	6	0
5	Говь-Алтай	632.3	632.3	505.9	505.9	10	7	3
6	Говьсүмбэр	1,912.7	1,760.5	1,248.1	1,133.3	27	18	9
7	Дархан-Уул	39,656.6	19,167.0	9,329.8	9,329.8	151	102	49

⁵⁴ Техникийн доод оноог хангасан зөвлөхөд санхүүгийн саналыг нээх өдөр, цагийг албан бичгээр болон утсан холбоогоор мэдэгдэнэ. Энэ өдөр нь дээрх мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш таваас багагүй бөгөөд санал нээлтэд оролцох хүсэлтэй зөвлөхөд энэ боломжийг олгохуйц хоногийн дараа байна.

⁵⁵ 34.1.5.гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

⁵⁶ Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

8	Дорноговь	19,815.7	12,527.1	9,669.9	8,130.1	69	55	14
9	Дорнод	1,113.7	1,029.7	976.5	961.5	21	20	1
10	Дундговь	1,547.1	1,547.1	1,271.0	1,271.0	27	18	9
11	Завхан	168.4	168.4	164.9	164.9	14	12	2
12	Орхон	45,016.9	29,579.2	38,841.1	24,451.5	249	213	36
13	Өвөрхангай	1,086.0	1,086.0	956.8	956.8	7	6	1
14	Өмнөговь	91,245.7	64,831.8	41,878.4	25,528.3	283	267	16
15	Сүхбаатар	2,022.4	1,252.0	1,694.4	896.0	17	17	0
16	Сэлэнгэ	1,908.6	1,841.4	1,504.4	1,401.2	51	40	11
17	Төв	3,402.3	2,552.3	2,691.9	2,286.0	34	28	6
18	Увс	1,393.3	1,393.3	673.3	673.3	17	15	2
19	Ховд	532.5	532.5	588.4	493.4	19	17	2
20	Хөвсгөл	2,398.9	974.1	1,143.2	696.2	16	4	12
21	Хэнтий	2,017.8	1,906.4	1,504.4	1,438.8	38	34	4
22	Нийслэл	504,213.6	199,484.8	240,994.1	114,187.6	1343	884	459
	Бүгд	724,346.1	344,935.7	358,613.1	196,801.0	2448	1802	646

Эх сурвалж: ОНТАГ

3.12 Орон нутгийн төсвөөс 2021 онд 724,346.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2448 төсөл, арга хэмжээнд 196,801.0 сая төгрөгийн санхүүжилт олгож **57.1** хувийн гүйцэтгэлтэй, нийт хөрөнгө оруулалтын 58.0 хувийг Улаанбаатар хотод оруулжээ.

3.13 Барилга угсралтын ажил гүйцэтгэхдээ БНБД-ийг мөрдөж ажиллаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Тухайлбал,

Нийслэлд:

- УБЗЗА ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 1,000.0 сая төгрөг төсөвт өртөгтэй Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалын ажил, хурд сааруулагч, тэмдэглэлийн ажлын 11 байршилд хийсэн хурд сааруулагчийн 472 м.кв талбайн тэмдэглэгээ арилсан;
- Хотын гол болон туслах гудамж замуудын 244.8 сая төгрөг төсөвт өртөгтэй тэмдэглэгээний ажлын хүрээнд Сургууль, цэцэрлэг орчмын явган хүний гарц, хурд сааруулагчийн ажлыг гүйцэтгэсэн УБЗЗА ОНӨААТҮГ-ын хийсэн 19 байршил дахь хурд сааруулагчийн 1071.47 м.кв талбайн тэмдэглэгээ арилсан;
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажлын хүрээнд хийсэн гудамж замуудын хэвтээ тэмдэглэгээний 484.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгч УБЗЗА ОНӨААТҮГ-ын 5 байршлын явган хүний гарц 1881.4 м.кв, 2 байршлын 323.0 м.кв хурд сааруулагч, нийт 2204.3 м.кв тэмдэглэгээ арилсан. Мөн төслийн хүрээнд хийсэн Сүхбаатар дүүргийн орон сууцны хороолол доторх авто замын засварын 297.4 сая төгрөгийн өртөгтэй ажлын гүйцэтгэгч УБЗЗА ОНӨААТҮГ нь 22 м зам талбайн (66 м.кв асфальтбетон хучилт) хучилтын ажлыг зургийн авторын зөвшөөрөлгүй өөрчилсөн;
- Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний зориулалтын автомашин 40 ширхэгийг нийлүүлэх 4,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгч Моннис ХХК тээврийн хэрэгслийн дагалдах тоног төхөөрөмжүүдээс нэг бүр нь 25.9 сая төгрөгийн үнэтэй 40 ширхэг амьсгалын аппарат, 2.5 сая төгрөгийн дефибрлятор, нийт 1,000.0 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлээгүй. Түргэн тусламжийн төвд нийлүүлсэн 71-60 УАК улсын дугаартай автомашины серийн дугаар, 51-36 УАР улсын дугаартай автомашины арлын дугаар зөрсөн. Дагалдах хэрэгслээр тоноглогсон 4 хаалгатай 40 ширхэг тээврийн хэрэгсэл нийлүүлсэн нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтээс зөрүүтэй;

Өмнөговь аймагт:

- Булган сумын өвлийн хүлэмж, 10 айлын орон сууцны зарим байр, Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлын гүйцэтгэл дутуу, чанарын хангалтгүй.

3.14 Шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглагч байгууллага тодорхойгүй, бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй байна. Үүнд:

Нийслэлд:

- Нийтийн эзэмшлийн зам талбайд 1,996.1 сая төгрөгөөр бэлтгэсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үйл ажиллагааг хариуцан явуулах ашиглагч байгууллага тодорхойгүйгээс одоог хүртэл ашиглалтгүй, гүйцэтгэгч харуул хамгаалалтын асуудлыг хариуцаж байна.
- Төсөвт өртөг нь 1,996.1 сая төгрөгийн үнийн дүнтэй СХД-ийн 22 дугаар хороо, Тахилт, Цагдаа толгой орчимд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ТАХ-г 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ЗТ-116/2021 дугаартай комиссын актаар хүлээн авсан боловч ашиглагч байгууллага тодорхойгүйгээс хөрөнгө тоногдох, эвдрэх зэрэг нөхцөл бүрдэхээр байна.

Дорноговь аймагт:

- Айраг сумын 64.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол, явган хүний зам байгуулах ажил;
- Замын-Үүд суманд 2020 онд хэрэгжсэн 565.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ёслол хүндэтгэлийн төв талбайн өмнө авто машины зогсоол байгуулах ажил;
- Сайншанд сумын 2 дугаар багт 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашины зогсоол байгуулах ажил;
- Сайншанд сумын 6 дугаар багийн 166.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Чойлонгийн гудамжинд цэвэр, бохир усны төв шугам татах ажил;
- 358.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн төвийн Дулааны 2-р эх үүсвэрийн технологийн шинэчлэлийн ажил;

- 698.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн зуслангийн гадна тохижилт, гадна инженерийн шугам сүлжээний ажил;
- 55.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нэгдсэн эмнэлгийн дүрс оношилгооны төвийн засварын ажил;
- 28.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайншанд сумын Зүүнбаян багийн гудамж талбайн камержуулалт;

Говь-Алтай аймагт:

- 186.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон 3 ТАХ-ий хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;

Дархан-Уул аймагт:

- Мэдээлэл технологийн албаны бүртгэлд тусгах 17.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Hollyland mars дүрс дамжуулагч, 10.5 сая төгрөгийн өртөгтэй 50 ширхэг зөөврийн хогийн савыг тус тус бүртгэж аваагүй байна.

3.15 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ашиглалтын байдлыг шалгахад дараах зөрчил илэрлээ. Тухайлбал,

Өмнөговь аймагт:

- Гэр хорооллын айл өрхөд зориулалтын хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж эхлээгүй;
- Булган сумын сургуулийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн угсраагүй, туршиж шалгаагүй;
- Барилгын материалын лабораторийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын 28.3 сая төгрөгийн 11 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлээгүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй;
- Гэр хорооллын айл өрхөд зориулалтын хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд 233.7 сая төгрөгийн өртөгтэй 100 ширхэг хог ангилан хаях савыг гэр хорооллын айлуудад байршуулсан боловч зориулалтаар нь ашиглахгүй байгаа, 54.6 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг шил, лааз хүлээж авах тоног төхөөрөмжийг ажиллуулж туршаагүй, ашиглаагүй, хог ялган ангилах 20 ширхэг савнаас 3 ширхэг нь эвдэрсэн;
- Ёл кино театрт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 12 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлснээс театрын суудлын бүртгэлийн програмыг ашиглаж чадаагүй;

Дорноговь аймагт:

- 2020-2021 онд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан 126.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайншанд сумын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн тодотгох ажил,
- 1,990.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэлийн ажил,
- 129.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улаанбадрах сумын ЦДАШ солих болон дэд станц барих ажил;
- 165.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажил;

Дорнод аймагт:

- Нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжүүд нь ашиглалтгүй, тус байгууллагын агуулахад хадгалаастай;
- Хэрлэн сумын доод бетон гүүр болон дунд модон гүүрэнд хийсэн 7.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомат хаалт нь эвдрэл гэмтэл үүссэний улмаас бүрэн хүчин чадлаар ашиглах боломжгүй байна.

3.16 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээнд зохиогч, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

Өмнөговь аймагт:

- Ханхонгор суманд хэрэгжсэн Хөдөөгийн багийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, багийн төвийн барилга шинээр барих 169.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын захиалагчийн хяналтыг сумын ЗДТГ-ын мэргэжилтэн, нярав, нягтлангууд гүйцэтгэсэн;
- Цогт-Овоо сумын 187.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн засварын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;

Өвөрхангай аймагт:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын барилгын гадна фасад, дотор заслын ажлын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр Арвай проект ХХК ажилласан ч их засварын ил, далд ажлын актыг баталгаажуулахад зохиогчийн хяналт хийгээгүй;

Дорноговь аймагт

- Алтанширээ сумын ЕБС-ийн хичээлийн байрны их засварын ажлыг 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн комиссын актаар хүлээж авсан. Ажлын тоо хэмжээг тулгаж үзэхэд 29.3 м.кв шаланд цементэн тээшилгээ хийгээгүй хулдаас дэвссэн, 1 ширхэг бүрэгд хаалга суулгаагүй, гадна орцны таазанд ус чийгээс хамгаалагдсан 6 ширхэг гэрэлтүүлэгч угсраагүй, хамгаалалттай хоёрлосон далд унтраалга 5 ширхэг, розетка унтраалгын блок 5 ширхэг байх байтал угсраагүй;
- Алтанширээ сумын Хаяа, Тойг багийн барилгын өргөтгөл барих ажлыг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн комиссын акт үйлдэж хүлээж авсан. Техникийн тодорхойлолттой тулгаж үзэхэд хуучин багийн төвийн барилгын гадна фасадыг засварлаж шинээр өргөтгөн барьсан гадна фасадыг өнгийн эмульсээр ижилсүүлэхээр тусгасныг хэрэгжүүлээгүй, шинэ өргөтгөлийн гадна хана тор татаж шавардлага хийхээр тусгасныг хавтангаар орлуулсан, хөгжлийн бэрхшээлтэй, тахир дутуу иргэдэд зориулсан тэргэнцрийн налуу зам хийгдээгүй, дотор хана тэгш бус, лампиран тааз доош цүлхийсэн байдалтай, дээрээс ус гоожсон, зарим газарт цууралт үүссэн;
- Сайншанд сумын автозамд нийтийн тээврийн өргөтгөлийн автобусны зогсоол байгуулах ажлыг Дэлгэр баясах зам ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Нийт 5 байршилд автобусны зогсоол барьсан байгаа ба гүйцэтгэгчийн ирүүлсэн төсөвт замын бетон хашлага 1x3x18м, нийт урт 46м-ээр тооцох байтал аудитаар 1x3x10 зогсоол бүр бага хэмжээний зөрүүтэй, нийт урт 33-34м хэмжээтэй байна. Мөн нийт 5

ширхэг автобусны зогсоолын 4 нь сүүдрэвчтэй, асфальтбетон хучлага тэгш бус, хашлаганы түвшин жигд бус, хашлага хоорондоо завсар, зайтай;

- Сайншанд сумын төвийн автозамд тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хучлагын засварын ажлыг Дэлгэр баясах зам ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичигт хэрэгжүүлэх байршил тодорхойгүй, хариуцсан албан тушаалтан нь мэдэхгүй гэсэн тайлбар ирүүлсэн. Аудитаар ажлын гүйцэтгэлийг шалгахад замын голын тасархай тэмдэглэгээ, хурд сааруулагчийн тэмдэглэгээ, явган хүний замын тэмдэглэгээ бүдгэрсэн, зарим замд арилсан, сэргээсэн, шинээр будсан нь тодорхойгүй, муруй, урт богино хэмжээтэй, зарим газар хурд сааруулагч хөндийрсөн, ховхорсон, асфальтбетон хучлагын нүхний засварыг хаана хийсэн нь тодорхойгүй, замын тэмдэг хаана шинээр суурилуулсныг ялгах боломжгүй, чанаргүй ТАХ-г ашиглалтад хүлээн авсан байна

3.17 Дээрх байдлаас үзэхэд улсын хэмжээний нэгдсэн бүртгэл, цахим систем байхгүйгээс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төрөл, зориулалт, төсөвт өртөг, санхүүжилт, хэрэгжилтийг бүрэн хянах боломжгүй байна.

3.18 Иймд орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтэд улсын төсвөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд хэрэгжүүлж буй Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системээр нэгдсэн байдлаар бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал байхад төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэхгүйгээр олон тоогоор төлөвлөж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан⁵⁷ төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчмыг алдагдуулж байна.
2. Сангийн яамнаас 2019 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд аргачлал, журам болон цахим систем www.publicinvestment.gov.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлж, нэгдсэн бодлогоор төлөвлөх эрх зүйн орчныг бүрдүүлснээр төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг сайжруулахад ахиц, дэвшил гарсан ч цаашид системийн ашиглалт, шуурхай байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаагүй, түүнд тавих хяналт сул байгаад дүгнэлт хийж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон сангуудын үйл ажиллагааны төлөвлөлт зарцуулалттай нягт уялдуулах шаардлагатай байна.
4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилах хуулиар тодорхойлсон зарчмыг баримтлаагүй, мөн төрийн өмчийн хөрөнгийн бүртгэлд бүртгэх боломжгүй урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөө, тэгш хүртээмжийг бууруулжээ.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих барилга, байгууламж, их засварын 345 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 325 буюу 94.2 хувьд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойш буюу барилгын улирал эхэлснээс хойш зохион байгуулсан нь холбогдох хуульд⁵⁸ заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байхад нөлөөлжээ.
6. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаарх хууль, журмуудын хэрэгжилт, түүнд тавих дотоод болон хөндлөнгийн хяналт хангалтгүйгээс тендерийн хэмнэлтээр гэрээний үнийн дүнгийн 15 хувиас хэтэрсэн нэмэлт гэрээ байгуулах, нэмэлт ажил гүйцэтгүүлэх, магадлалаар баталгаажаагүй өртгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх, худалдан авах ажиллагаанд эрх тэгш, шударгаар өрсөлдөх, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах нөхцөлийг бууруулж ашиг сонирхлын зөрчил гаргасан байж болзошгүй байна.
7. Барилга, байгууламжийн зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдмэл байдлаар хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн хариуцлагын тогтолцоог сайжруулснаар үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.
8. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллага, захиалагч, зохиогчийн хяналт хангалтгүйгээс барилга угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэх, дуусгалгүй орхих, данс бүртгэлд тусгахгүй байх зэргээр хөрөнгө эзэнгүйдэх, чанар байдал нь ашиглалтын шаардлага хангахгүй байх нөхцөл үүсгэж байгаа тул барилга

⁵⁷ 5.2.12-т “төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөх;

⁵⁸ ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх

байгууламжийг төлөвлөхөөс ашиглалтын хугацаа дуусах хүртэл хугацаанд кодчилж, бүртгэлжүүлэн нэгдсэн хяналтын тогтолцоо бий болгох хэрэгтэй байна.

9. Хөрөнгө оруулалтын санхүүжилтээр баригдсан барилга, байгууламж, худалдан авсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилгын хуваарилалт, ашиглалт хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байгаа тул улсын хэмжээний нэгдсэн тооллого хийж, бүртгэлийг цахимжуулж мэдээллийг хөрөнгө оруулалтын удирдлагын системд оруулах нь зүйтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцүүлж, салбарын түвшинд төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусгаж буй зөрчил давтан гарч байгаад анхаарал хандуулах;
2. Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үйл ажиллагаанд материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатал гарч, төслүүд хугацаандаа хэрэгжихгүй байх, удаашрах зэрэг нөхцөл үүссэн нь цаашид ийм тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх зүйн орчныг тодорхой болгох;
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар сүүлийн 11 жилд Улсын Их Хуралд толилуулсан асуудалд шинжилгээ хийлгэж, үр дүнд тулгуурлан тодорхой шийдвэр гаргахыг тус тус толилуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээг авч, төсвийн төлөвлөлтөд улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төсөв хоорондын уялдааг хангуулах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримталж, төсвийн хөрөнгөөр барьж ашиглаж байгаа болон дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн улсын хэмжээний нэгдсэн үзлэг, тооллого хийж, бүртгэлээр тавих хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг зөрчсөн, төрийн албан хаагчдад уг хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцох;

Сангийн сайдад:

- Төсвийн нийт хөрөнгө оруулалт буюу улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, санхүүжилтийн бусад эх үүсвэрийг нэгдсэн удирдлага, зохицуулалтын хүрээнд төлөвлөх, хянах, нэгдсэн зохицуулалтын системийг бий болгох;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн цахим систем (www.publicinvestment.gov.mn/)-ийг холбогдох бусад салбарын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн системүүдтэй уялдуулж, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах;
- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн жил дамжуулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах шийдвэр нь санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж, бүртгэлийн тогтолцоо, төсвийн сахилга батыг алдагдах зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байх тул хууль, журмыг баримталж ажиллах;

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлэн төсвийн саналыг төсвийн хязгаарт багтаан боловсруулж, төсвийн төлөвлөлтөд хууль, эрх зүйн орчныг чанд мөрдөж ажиллах;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн, газар эзэмших зөвшөөрөлгүй, зураг төсөл, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт болон захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, үр дүнг тооцож ажиллах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэж буй байгууллагуудын гэрээний үүрэг, хариуцлагыг тооцдог, мэргэжлийн түвшинд үнэлж, дүгнэн үр дүнг нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог бий болгох;

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримталж, төсвийн хөрөнгөөр барьж ашиглаж байгаа болон дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн улсын хэмжээний нэгдсэн үзлэг, тооллого хийж, дуусаагүй орхигдсон барилга, байгууламж бүрээр мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, эцэслэн шийдвэрлэх;

Барилга, хот байгуулалтын сайдад:

- Төсвийн хөрөнгөөр боловсруулсан барилга, байгууламжийн зураг төсөл, төсвийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, төсвийн төлөвлөлтөд ил тод, нээлттэй ашиглах боломж бүрдүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022-06-10 № 03/4121
танай _____ -ныг № 01/1204 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Я.САРАНСҮХ ТАНАА

Хариу өгөх тухай

Танаас ирүүлсэн 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 01/1204 тоот албан бичигтэй танилцлаа.

Танай байгууллагаас хийж гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766009465

Сангийн яамны ...р сарын ...-ны өдрийн
..... тоот албан бичгийн хавсралт

Тайлангийн төсөлд өгөх санал, тайлбар:

Тайлбар 1-ийг харна уу

1. Тайлангийн төслийн дүгнэлт хэсгийн 1-т тусгагдсан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим бүрэн хангагдахгүй байгаа нь хэт олон төсөл, арга хэмжээг тухайн жилд төлөвлөх, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг багтаамжийг харгалзан үзэхгүй байгаатай шууд холбоотой байна” гэсэн дүгнэлтийг хасах.

Тайлбар: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар жилийн хөгжлийн төлөвлөгөө, 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 зэрэг богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг баталж, түүний дагуу бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хангахад төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж, санхүүжилтийг тусгасан. Мөн төсвийн төсөлд тусгахаар ирүүлсэн төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, цахим системийн дагуу хэрэгжүүлж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, ач холбогдол бүхий төслүүдийг төлөвлөж байна.

Тайлбар 2-ыг харна уу

2. Тайлангийн төслийн 2-т тусгагдсан “Сангийн яамнаас 2019 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд төлөвлөлтийн аргачлал, журам болон цахим систем /www.publicinvestment.gov.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг сайжруулахад томоохон ахиц, дэвшил гарсан ч цаашид хэрэгжилтийг жигдрүүлэх, холбогдох салбарын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн системтэй уялдуулбал төлөвлөлт болон хяналтын нэгдсэн удирдлага бүрэн хангагдахаар байна” гэсэн хэсгийг Сангийн яамнаас 2019 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд төлөвлөлтийн аргачлал, журам болон цахим систем /www.publicinvestment.gov.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг сайжруулахад томоохон ахиц, дэвшил гарсан байна гэж засах.

Тайлбар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг 2019 оноос эхлэн улсын хэмжээнд нэвтрүүлж, 21 аймаг, нийслэл, бүх ТЭЗ нар холбогдон ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар үндэсний 8 системтэй холбогдож шаардлагатай мэдээллийг солилцож байгаа бол нийт 2400 хэрэглэгчидтэй байна.

Тайлбар 3-ыг харна уу

3. Тайлангийн төслийн 3-т “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд уялдуулж төлөвлөөгүй, мөн төрийн өмчид хамаарахгүй, хөрөнгийн бүртгэлд бүртгэх боломжгүй урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөө, тэгш хүртээмжийг бууруулж байна” гэсэн хэсгийг “Төсвийн эх үүсвэр хангалтгүй, хэрэгцээ шаардлага өндөр байдгаас зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүй мөн төрийн өмчид бүртгэхэд хүндрэл үүсэж болзошгүй зарим төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн хөрөнгө оруулалтын үр нөлөө, тэгш хүртээмжийг бууруулахад нөлөөлөх магадлалтай байна” гэж засах.

Тайлбар 4-ийг харна уу

4. Тайлангийн төслийн 6-д туссан “Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан журмуудын хэрэгжилт хангалтгүй, хяналтын тогтолцоо сул байгаагаас тендерийн хэмнэлтээр гэрээний үнийн дүнгийн 15 хувиас хэтэрсэн нэмэлт гэрээ байгуулах, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил гүйцэтгүүлэхэд зарцуулж байгаа нь худалдан авах ажиллагаанд эрх тэгш, шударгаар өрсөлдөх, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах нөхцөлийг бууруулж байна” гэсэн хэсгийг хасах.

Тайлбар: Тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсөвт өртгийг Төсвийн тухай хуулиар баталж байгаа бөгөөд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу батлагдсан төсөвт өртөг багтаан төслүүдийг хэрэгжүүлэх, бүрэн ашиглалтад оруулах шаардлагын хүрээнд нэмэлт гэрээг холбогдох хууль, Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу байгуулсан байна.

Тайлбар 5-ыг харна уу

5. Тайлангийн төслийн зөвлөмж хэсгийн Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан хэсгийг холбогдох хэрэгжүүлэгч байгууллагууд зөвлөмж болгож өгөх, зарим зөвлөмжийн утга агуулга давхардсан байх тул найруулгыг анхаарах.

Тайлбар 6-ыг харна уу

6. Тайлангийн төслийн зөвлөмж хэсгийн Сангийн сайдад хандсан 2, 3 дахь заалтыг нэгтгэж найруулах, 4 дэх заалтыг хасах.

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1. Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 2. Цахим системээр дамжуулан хийгдэж буй төлөвлөлт шаардлагад бүрэн нийцэхгүй байх тул саналыг хүлээн авах боломжгүй

